



ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” судалгааны үр дүн 3
2. Хуулийн төсөл боловсруулах үйл явцыг ил тод болгож, улс төрийн хүрээн дэх авлигаас урьдчилан сэргийлэх нь . . . 16
Б.Батзориг
3. Монголын уул уурхайн салбар дахь инноваци ба эрх зүйн орчин. 20
Ж.Нямдулам
4. Хэрэглэгчийн ёс бус үйлдэлтэй холбогдон үүсч буй харилцааг эрх зүйгээр зохицуулах хэрэгцээ, шаардлага. 24
Б.Мөнгөннахиа, Ж.Хулан
5. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүний хэлбэр. 30
Ж.Бямбадорж
6. Монгол Улс дахь танхайрах гэмт хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх зарим асуудал. 36
Д.Туяацэцэг

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл. 39
Бат-Очир
2. Гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын уламжлал, Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомж дахь онцлог. 46
Б.Хишигтогтох

ЭРХ БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Эрүүгийн хэргийн нотлох баримтын ойлголт, ангилалын асуудал 51
Ж.Болдбаатар
2. Нийгмээс тусгаарлах албадлага 55
Г.Амаржаргал

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Цусанд угаарын хий тодорхойлох шүүх-химийн шинжилгээ, судалгааны асуудал. 61
Б.Аюушбаатар

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэлийн асуудал 64
Ш.Чулуун

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Олон улсын шилжилт хөдөлгөөн ба Монгол Улсын өнөөгийн байдал 70
Б.Нармандах

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1. Трудовая занятость осужденных в процессе детерминации пенитенциарной преступности 76
Минкова Елена Анатольевна

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Д.ЗҮМБЭРЭЛХАМ
ДОКТОР(Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Б.БАТ-ЭРДЭНЭ
МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧ, ДОКТОР(Ph.D),
ПРОФЕССОР

Б.БОЛДБААТАР
МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Ж.ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР(Sc.D), ПРОФЕССОР

Н.ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР(Ph.D), ПРОФЕССОР

А.ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР(Ph.D), ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Б.ЭНХБОЛД
ДОКТОРАНТ

ЭРХЛЭН ГАРГАСАН:

С.ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Б.МӨНХЗУЛ
МАГИСТР

**КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ****“ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН
НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ”
СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

Хууль зүйн яамны захиалгаар Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтнууд, их сургуулийн зарим профессор, багш, практик байгууллагын ажилтнуудын хамтарсан судалгааны баг¹ хүн худалдаалах гэмт хэргийн талаар криминологи судалгааг 2014 оны 6-аас 10 дугаар сард хийсэн. Энэхүү судалгааны үр дүнгээс тоймлон толиулж байна.

Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал

Дэлхий дахинаа хүний наймаа газар авч байгаатай

¹ Багийн ахлагчаар ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, математикийн болон хууль зүйн магистр Б.Мөнхдорж, нарийн бичгийн даргаар мөн төвийн эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр Д.Сумъяацэрэн, гишүүдээр Цагдаагийн сургуулийн Эрүүгийн тагнуулын тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D) Р.Баярмагнай, мөн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D) С.Гантулга, ЦЕГ-ын Гэмт хэрэгтэй тэмцэх газрын хэлтсийн дарга Б.Дэлгэрсайхан, Цагдаагийн сургуулийн Мөрдөх ажиллагааны онол, тактикийн тэнхимийн дэд профессор, хууль зүйн магистр Г.Амаржаргал, Дотоод хяналт, аюулгүй байдлын албаны Соёл хүмүүжил, олон нийтийн хэлтсийн сэтгэл зүйч, сэтгэл судлалын магистр А.Баярцэцэг, Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Гадаад хэлний тэнхимийн багш П.Уранбадам, ЦЕГ-ын Мэдээлэл, технологийн төвийн ахлах мэргэжилтэн Б.Баяндүүрэн, Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр Б.Мөнхсэргэлэн, Төгсөлтийн дараах сургуулийн туслах ажилтан Х.Ундрах нар ажиллав.

холбоотойгоор Хятад, Өмнөд Солонгос, Япон, Малайз, Хонконг, Сингапур, Макао, Турк, Израиль болон Югослав, Дорнод Европын бусад улс оронд худалдаалагдаж хохирсон Монгол Улсын иргэдийн тоо нэмэгдсээр байна.

Монгол Улсын иргэд гадаадад зорчих явдал үлэмж хэмжээгээр нэмэгдсэн. Өнөөгийн байдлаар гадаадын 191 улс оронд 131 мянга орчим монголчууд амьдарч байна.² Хил хязгаар нээлттэй болж зарим улсад визгүй зорчих шинэ боломжууд нээгдсэн. Мөн дотоодод хөдөө орон нутгаас хот суурин газар руу шилжин нүүх хөдөлгөөн ч ихэсчээ.

Гэвч эдгээр өөрчлөлт нь гадаадад гарч мөнгө олж сайхан амьдрахыг мөрөөдсөн иргэд, ялангуяа охид, бүсгүйчүүдийг хил давуулан гадаадад худалдаалах хялбар “зууш” болох эрсдэлийг нэмэгдүүлсэн гэж болно. Шалтгаан нь охид, эмэгтэйчүүдийг гадаад оронд өндөр цалин, орлого ихтэй ажилд оруулах, гадаадын иргэнтэй гэр бүл болоход нь зуучилна гэж ов мэх хэрэглэн, урхиндаа оруулах замаар энэ гэмт хэргийг үйлдэж байна.

Бээжин хотод болсон Хятад, Монгол хоёр улсын консулын уулзалтаар *Монгол Улс, Орос, Хятадын дундах хүн наймаалах, хил дамжуулан*

² 2014 оны 10 дугаар 23-ны өдрийн Гадаад харилцааны яамны мэдээлэл

худалдаалах төв цэг болжээ гэж албан ёсоор хүлээн зөвшөөрсөн.³

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлыг графикаар үзүүлбэл: (График № 1, 2 3)

Хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдлын авч үзвэл: (График № 4,5)

Хүн худалдаалах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэж байгаа байдал

Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх энэ судалгааг УДШ-ийн 2009-2013 оны тайлан мэдээ, 2002-2008 оны энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн ХЗҮХ-ийн судалгааны тайланд тулгуурлан явууллаа.

Хүн худалдаалах гэмт хэргийн гаралт буурах хандлагатай байгаа мэт боловч эрх зүйн зохицуулалтын боловсронгуй бус байдал шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид энэ гэмт хэргийн талаар нэгдмэл ойлголт хангалтгүй, энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөх ажиллагаа явуулах арга зүй дутмаг, гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо хангалттай бүрдээгүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан цагдаагийн байгууллагад бүртгэгдэх энэ

³ Ц.Эрдэнэ. Та бид хүний наймааны төв цэгт амьдарч байна //Ардын эрх сонин.2006.11.08, 217 /495/



График № 1

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэрэг




График № 2

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг




График № 3

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн хөдөлгөөн






График № 4




График № 5

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн болон шүүхээр шийдвэрлэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн харьцуулалт



төрлийн гэмт хэргийн тоо бодит амьдралд үйлдэгдэж буй хэргийн тооноос харьцангуй бага байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Түүнчлэн, бүртгэгдсэн гэмт хэрэгт мөрдөх ажиллагаа явуулахдаа гэмт хэргийн бүрэлдэхүүнийг болон эрүүгийн хэрэгт нотлогдвол зохих нөхцөл байдал, тухайн хэргийн онцлог байдал зэргийг тогтоож чадаагүйгээс шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хэрэгсэхгүй болох, зүйлчлэл өөрчлөгдөж Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлд заасан “Биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг” болгож хувирах тохиолдол цөөнгүй байгаа нь шүүхийн байгууллагын цахим санд байгаа хэргүүдийн шийтгэх тогтоолуудад судалгаа хийж үзэхэд тогтоогдлоо.

Учир нь амьдралд үйлдэгдэж буй хүн худалдаалах

гэмт хэргийн дийлэнх нь эмэгтэйчүүдийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулсан байдаг тул энэ төрлийн гэмт хэргийг биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл гардаг нь практик ажилтнуудаас авсан судалгааны дүнгээс ажиглагдаж байна.

Хүн худалдаалах эрүүгийн 10 хэргийн материалтай танилцах явцад тухайн гэмт хэргийн хохирогчдын аюулгүй байдлыг хангах, эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль зүйн туслалцаа, үйлчилгээнд хамруулах, хохирогчийн хувийн байдлыг тогтоох талаар хангалттай ажиллаагүй, нотлох баримтыг хангалттай цуглуулаагүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг үнэн зөв шийдвэрлэгдэх боломжийг үгүйсгэж байна.

Судалсан эрүүгийн хэргийн хохирогчдын дийлэнх нь эмзэг байдлаа ашиглуулсан, хууртагдсан, хүчинд автсан зэрэг аргагүй нөхцөл байдлын улмаас байнгын биеэ үнэлсэн буюу бэлгийн мөлжлөгт өртжээ. Өөрөөр хэлбэл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогчид нь эцсийн хүрэх цэг хүртлээ зуучлагчдын тусламжтайгаар хүнээс хүнд дамжигдан зарагддаг бөгөөд энэ үе шатуудад хийгдэж буй элсүүлэлт, тээвэрлэлт, дамжуулалт, орогноулалт нь байнга хүч хэрэглэсэн хэлбэртэй байдаггүй байна. Хохирогчдын олонх нь сайн дураараа элсэгдсэн байх бөгөөд тэднийг хуурч мэхлэх, залилах, итгүүлэн үнэмшүүлэх хандлага илүүтэй байна.

Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, Эрүүгийн хууль болон ЭБШХ-



ийн зүйл, заалтад заасан агуулгыг практик байгууллагын албан хаагчид тодруулбал, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид нэг мөр ойлголтгүй байдал зэргээс шалтгаалан шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хэргийг буруу зүйлчлэх, зүйлчлэл өөрчлөх тохиолдлууд байсаар байна.

Бидний хийсэн судалгааны объект болох эрүүгийн хэргийн материалуудаас үзэхэд, мөрдөн байцаалтын төлөвлөлт, зохион байгуулалт, хамтын ажиллагаа дутмаг, ЭБШХ-ийн 80 дугаар зүйлд заасан нотлогдвол зохих нөхцөл байдлууд болон бусад байдлуудыг хангалттай бус тогтоосон зэрэг нь ажиглагдаж байна.

Шүүгч, хууль сахиулах байгууллагын ажилтнаас авсан санал асуулгын үр дүн


Судалгаанд Улаанбаатар хотын цагдаагийн газрын Баянзүрх, Баянгол дүүргийн цагдаагийн хэлтсийн албан хаагчид, Орхон, Дархан-Уул, Булган, Сэлэнгэ зэрэг аймгийн цагдаагийн хэлтэс, газрын албан хаагчид, Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурорууд, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх, Эрүүгийн хэргийн анхан шатны нэгдүгээр шүүхийн шүүгчид, төрийн бус байгууллага иргэд зэрэг нийт **150** гаруй хүн хамрагдсан. Үүнээс 146 санал хүчинтэйгээр тооцогдсон.

Судалгаанд оролцогчдын насны байдлаар харуулбал:



Судалгаанд оролцогчдын насны байдлын үзүүлэлтээс харахад аль ч байгууллагын төлөөллийн дийлэнх хувь нь залуу насны хүмүүс төлөөлж судалгаанд оролцсон байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хэлбэрүүдийн талаар дурдахдаа судалгаанд оролцогчид дараах хэлбэрийг нэрлэжээ. Үүнд:



Судалгаанд оролцогчдын саналаар тус гэмт хэрэгт бэлгийн мөлжлөгийн хэлбэр зонхилж байдаг гэж 21.9% нь, хөдөлмөрийн мөлжлөг гэж 10% нь, эд эрхтний худалдаа 0.6% нь үзсэн байна. Мөн захиалгат гэрлэлт 0.6%, хүүхэд үрчлэлтийн хэлбэр байна гэж 0.6%-ийн санал ирүүлсэн байна. Үүнээс үзэхэд, манай улсад дийлэнх үйлдэгдэж байгаа гэмт хэрэг нь бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг зонхилж байна гэж үзэж байна. Үүнээс гадна мэргэжилтнүүдийн дийлэнх нь буюу 40% нь энэ төрлүүд бүгд л манайд хэрэгжиж байна гэж үзжээ.

Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй шалтгаан, нөхцлийг судалгаанд оролцогчид дараах байдлаар илэрхийлсэн байна. Үүнд:

1. Нийгмийн байдал
2. Ядуурал
3. Цалин хөлсний хүртээмж муу
4. Эцэг эхийн

хараа хяналт сул, ар гэрийн байдал

5. Эрх зүйн мэдлэг дутмаг
6. Сэтгэлгээний ядуурал
7. Ажлын байр хомс
8. Амар хялбар аргаар мөнгө олох сэдэл
9. Хилийн хяналт шалгалт муу
10. Гэнэн томоогүй зан
11. Мэдээлэл муу байдал

12. ЕБС-ийн сургалтын үйл ажиллагааны чанар муу

13. Мэргэжил, боловсрол эзэмшээгүй байдал

14. Зуучлагчдад тавих хяналт сул

15. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх алба хаагчид дутмаг

16. Төрийн болон ТББ-ын хамтын ажиллагаа хангалтгүй

Судалгаанд хамрагдагсад энэ төрлийн гэмт хэргийн шалтгааныг нэг талаас нийгмийн хүчин зүйл, нөгөө талаас хувь хүний хүчин зүйлтэй холбож тайлбарласан байна. Нийгмийн хариуцлага сул байдал, эцэг эх, гэр бүлийн хараа хяналтгүй байдал, төр засгийн зүгээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хэрэгжилт, хувь хүний аливаад хандах хандлага, сэтгэлгээний байдал зэрэг нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл болж байна гэж үзэж болохоор байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль батлагдан хэрэгжиж эхэлснээр гарсан үр



дүн өөрчлөлтийн талаарх санал: шүүмжлэлтэй хандсан төдийгүй

Эерэг	Сөрөг
Ахиц гарч байна	Хангалттай сайн хэрэгжиж чадахгүй байна
Тодорхой хэмжээгээр гаралт буурсан	Үр дүн тодорхойгүй байна
Тодорхой өөрчлөлтүүд орж байна	Хэрэгжилт сул
-	Урьдчилан сэргийлэх, иргэдэд мэдлэг түгээх ажил хэрэгжихгүй байна
-	Гэмт хэргийн гаралт багасна гэж бодож байсан

Цаашид Хүн худалдаалахтэй тэмцэх тухай хуулийг боловсронгуй болгох чиглэлээр дараах саналыг илэрхийлсэн байна. Үүнд:

1. Хохирогчийн эрхийг хамгаалах, шалтгаан, нөхцлийг хамгийн түрүүнд зогсооход анхаарах

2. Илрүүлэх тал дээр тусгай баг ажиллуулах

3. Садар самуунтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

4. Хэрэгжилтийг хангах

5. Хүлээлгэх хариуцлагыг чангатгах

6. Гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхой оновчтой болгох

7. Нэмэлт, өөрчлөлт оруулах

8. Хуулийн сансцыг чангатгах

9. Монгол Улсын элсэн орсон Олон улсын гэрээ конвенцын дагуу хөрш зэргэлдээ орнууд руу хил давуулан хүн худалдаалах гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх талаар тусгах

10. Зөөлрүүлэх болон адилтгах санкц нь адилхан хэт хөнгөрөхгүй, чанга байх

11. Хариуцлага тооцох санкцуудаа нэмэгдүүлэх

12. Илрүүлэх тал дээр тусгай баг ажиллуулах.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэнд судалгаанд оролцогчид

цаашид хохирогчийн эрхийг хамгаалах, хэрхэн ажиллавал үр дүнтэй талаар санал илэрхийлсэн байна.

Эрүүгийн хуульд 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулснаар гарсан үр дүн, өөрчлөлтийн талаарх санал:

Эерэг	Сөрөг
Үр дүн, илрүүлэлт сайжирсан	Ахиц гараагүй
Хэрэгжиж байгаа, ахиц гарсан	Заалт тус бүрийг бусад зүйл, заалтаас ялгах
Практикт сайн хэрэгжиж байна	113, 124 дүгээр зүйлд заасан гэмт хэргүүд ялангуяа 113 дугаар зүйлээр шүүхээр шийдвэрлэгдэх хэргүүд цөөн, 113 дугаар зүйлээр шийдвэрлэх хэргийн материал 124 дүгээр зүйл ангиар шийтгэгдэх явдал түгээмэл байна.
Хэрэг илэрч энэ талаар зохиогдож байгаа ажил ихэссэн	Хэм хэмжээ, зүйл заалтыг нэг мөр ойлгох шийдвэрлэх практик хуулийн байгууллагад байхгүй.
	Давхар зүйлчлэлийг арилгах

Цаашид Эрүүгийн хуулийг боловсронгуй болгох чиглэлээр дараах саналыг илэрхийлсэн байна. Үүнд:

1. Хохирогчийн эрх ашгийг хамгаалах, насны хязгаарлалт, зүйлчлэлийг өөрчлөх

2. Иргэдийн оролцоо чухал

3. Ялын бодлогыг чангатгах

4. Эрүүгийн хуулийн зүйлийг нэг мөр болгох, зүйл өөрчлөгдөх боломжийг хориглох

5. Хариуцлагыг өндөржүүлж боловсронгуй болгох

6. Сэдэл зорилгоор зүйлчлэлийг нарийн тусгаж хариуцлагыг чанаржуулах

7. Энэ төрлийн гэмт хэргийг тусд нь нэг бүлэг болгон оруулах

8. Биеэ үнэлэхийг зуучлах, Хүн худалдаалах гэмт хэргийн ялгааг сайн гаргаж өгөх

9. Зохион байгуулагч, захиалагчийг олж илрүүлэх, түүнд оногдуулах шийтгэлийг чангатгах, гэмт хэрэг үйлдэгч болон зуучлагчид дан ял оноодог нь дутагдалтай.

Эрүүгийн хуульд 2008 онд гарсан нэмэлт өөрчлөлт нь практикт хэрэгжиж үр дүнгээ өгч байгаа, сэтгэл ханамжтай, орсон үр дүнг 80% илэрхийлсэн бол цаашид анхаарах асуудалд хохирогчийн эрхийн асуудал чухлаар тавигдаж байна.

Хүн худалдаалах, ялангуяа

хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай саналаа ирүүлснийг багцлан доорхи хүснэгтээр харуулбал:

Үүнээс нийгэмд энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдээлэл, ойлголт хүргэх үйл ажиллагаа харьцангуй бага байсан ч сүүлийн жилд хөтөлбөр үйл ажиллагаагаар сайжирч байна. Эргээд энэ үйл ажиллагааны хэрэгжилт, хүртээмж, хамрах хүрээ зэрэгт анхаарах шаардлага байсныг асуулгын үр дүнгээс харж байна.



КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Давуу тал	Сул тал
Нийгэмд тодорхой хэмжээнд энэ төрлийн гэмт хэргийн тухай ойлголт бий болсон.	Хяналт сул
Сурталчилгаа, мэдээлэл сайн явагдсан.	Нэр төдий хэрэгжиж байна. Хамрах хүрээ бага.
Сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил сайжирч байна.	Төсөв мөнгө тусгагдаагүйгээс бусад үйл ажиллагаа явуулах боломжгүй.
Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа сайжирч байна.	Бодит амьдралд хэрэгжихэд дутмаг зүйл их байна.
Мэдээллийн хүртээмж, агуулгын байдал сайжирсан	Нийтэд тэр болгон хүрч чадахгүй байна. Энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий бүлэгт энэ сурталчилгааг хүргэх.
Урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн хүчийг татан оролцуулах хэрэгтэй.	Сурталчилгаа, ухуулгын үргэлжлэх хугацаа 2-3 минутаар хэмжигддэг. Давтамж тодорхойгүй.
	Төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа сул
	Үндэсний хөтөлбөрийн талаар ойлголттой хүн цөөн

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа

Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан, нөхцлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор УИХ 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль батлан гаргасан. Өмнө нь бие даасан хууль байхгүй, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн, далайц хангалтгүй байлаа. Учир нь тэмцэх, урьдчилан сэргийлэх нийгмийн хандлага, мэдээлэл дутмаг, эрх зүйн болон үйл ажиллагааны орчин, тогтолцоо дутмаг байв.

“Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр⁴”-ийг 2006 оноос гурван үе шаттайгаар хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн хэрэгжилт 2016 онд дуусгавар болно.

⁴ Засгийн газрын 2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 234 дүгээр тогтоолоор баталсан

Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, шинээр гарч байгаа хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах, аливаа гэмт халдлага, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг иргэдэд эзэмшүүлэх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2012-2015 онд хэрэгжих *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг*

Засгийн газрын 2012 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 252 дугаар тогтоолоор баталсан. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх чиглэлийн 4.1.6-д “хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх” заалт тусгагдсан. 5.6-д Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.6. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.6.1.хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг иргэдэд сурталчлан таниулах;

5.6.2.хүн худалдаалахтай тэмцэх, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгтөртөхөөс хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тодорхой зорилтот бүлгүүдэд зориулан тогтмол зохион байгуулах, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх;

5.6.3.хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтныг сургаж мэргэшүүлэх, чадавхижуулах арга хэмжээг тогтмол авах.

Хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөөнд сургалт зохион байгуулах, судалгаа хийлгэх, гарын авлага, ном бэлтгэх, сэрэмжлүүлэг, зурагт хуудас тараах, төрийн бус байгууллага, хуулийн этгээд, хамт олныг татан оролцуулах, тэдний идэвх санаачлагыг дэмжих энэ талаар мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг 8 төрлийн арга хэмжээнд нийт



130 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хууль зүйн сайдын 2013 оны 1 дүгээр сарын 28-ны А/11 дүгээр тушаалаар байгуулагдаж, үйл ажиллагаа нь тогмолжиж, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа идэвхжиж байна.

Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Дэд зөвлөлд Эрүүл мэндийн яам, Хөдөлмөрийн яам, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал, хууль сахиулах байгууллага, хүүхдийн төлөө газрын болон төрийн бус байгууллагын төлөөлөл орсон байна. Дэд зөвлөлөөс 2016 он хүртэл төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд хууль заасны дагуу хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мэдээлэл сонсох, хэлэлцэх, уулзалт, семинар, сургалтууд зохион байгуулах зэрэг хэлбэрээр ажиллаж байна.

Хууль зүйн яам, Азийн сангийн дэмжлэгтэйгээр Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна. Улмаар энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг оролцуулан 9 дүгээр сард ХЗЯ-нд хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Хөтөлбөрийн зорилго нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг төлөвшүүлэх, цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гүүнтэй тэмцэх, хууль тогтоомжийг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх, сургалт, сурталчилгааны

оновчтой аргыг хэрэглэн зорилтот бүлгүүдийг хамруулах юм.⁵

Дэд зөвлөлөөс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах ажлын хүрээнд Хүйсийн тэгш эрхийн төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Дундговь, Замын-Үүд дэх хамгаалах байрны санхүүжилтэд тус бүр 7.0 сая төгрөг, Мөрдөн байцаах газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Эрүүгийн цагдаагийн газарт тус бүр 8.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж гардуулж өгч, дэмжлэг үзүүлжээ.

Хүйсийн тэгш эрхийн төвөөс Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Орхон, Өвөрхангай, Төв, Архангай, Хөвсгөл, Баянхонгор аймгийн хэсгийн төлөөлөгч, ерөнхий боловсролын сургуулиудыг хамруулан зохион байгуулсан 1 өдрийн сургалтад 13.3 сая төгрөг, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах, ТВ, сонин мэдээллийн сайтууд радиогийн 30 сэтгүүлч хамруулан 2 өдрийн сургалт зохион байгуулахад 5.9 сая төгрөг, 60 секунтын сэрэмжлүүлэг шtroкыг “Ричмүүн” ХХК-тай 2.4 сая төгрөгийг санхүүжилтээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллажээ.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх шторкийг ХЗҮХ, Төмөр замын LCD дэлгэцээр тогтмол цацаж байна. Мөн сэрэмжлүүлэг бүхий хуудсыг Азийн сангийн санхүүжилтээр 240,000 хувь хэвлүүлэн гадаад улсад суугаа элчин сайдынаам, Консулын газар, Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал, Төмөр

⁵ <http://moj.gov.mn>

замынбуудал, Замын-Үүд болон бусад хилийн боомтуудад тараажээ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5.7-д “Цагдаагийн болон тагнуулын байгууллага нь хүн худалдаалах үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, хүн худалдаалахтай холбоотой зар сурталчилгаанд хяналт тавина” гэж заасны дагуу цагдаа, тагнуулын байгууллага холбогдох чиг үүргийн дагуу үйлажиллагаа явуулж байна.

ЦЕГ-ын Гэмт хэрэгтэй тэмцэх газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилтнууд ажиллаж байна.

Гадаад харилцааны яам, Консулын газар, гадаад улсад суугаа элчин сайдын яамдын зүгээс хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр сүүлийн үед үр дүнтэй ажиллаж байна. Учир нь гадаадад байгаа иргэдэдээ мэдээлэл хүргэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, тэдний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, эх оронд авчрах зэрэг олон ажлыг хийж байна. Тухайлбал, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон 2013 онд 82, 2014 оны эхний 9 сарын байдлаар 84 иргэнийг эх оронд нь авчирсан байна.

Хүн худалдаалахтай тэмцэх хуулиар үүрэг хүлээсэн, үндэсний хөтөлбөрт тодорхой ажил, арга хэмжээ хийхээр тусгагдсаны дагуу яамд, агентлагууд, тухайлбал, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, боловсрол, эрүүл мэнд зэрэг



КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

яамд, хил, бүртгэл, мэргэжлийн хяналт, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагууд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зааснаар төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх үүднээс

хамгаалах байр, хохирогчдод үзүүлэх тусламж үйлчилгээ, хохирогч хүүхдийг хамгаалах, олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр сургалт, сурталчилгаа хийх зэрэг ажлыг ХЗЯ-аас авч хэрэгжүүлж байгаа нь нийгэмд зөв хандлага төлөвшүүлэх, хүн худалдаалахтай тэмцэх ажилд чухал түлхэц болж, зохих үр дүнгээ өгч байна. Монгол Улсад хүн худалдаах гэмт хэргийн

эсрэг үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд 2000 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж ирсэн ч өнгөрсөн хугацаанд хийсэн ажил нь албан бус байсан гэж үзэж, нэг зорилгын төлөө ТББ-ууд нэгдэж хүчээ нэгтгэж, “Хүний наймаатай тэмцэх ТББ-уудын сүлжээ” (<http://moj.gov.mn>) байгуулжээ. Үүнд, 20 орчим байгууллага багтжээ.

ДҮГНЭЛТ, САНАЛ

№	Дүгнэлт	Санал
1	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар төр хүлээсэн үүргээ биелүүлж, төрийн бус байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулж, үндэсний хөтөлбөр 3 үе шаттай хэрэгжсэн, Эрүүгийн хуульд тодорхой нэмэлт, өөрчлөлт орсон, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бие даасан хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль батлан гаргасан зэрэг ахиц байна. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаарх эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн. Гэвч эрх зүйн зохицуулалтыг цаашид боловсронгуй болгох шаардлагатай.	-Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаатай холбоотой үндэсний хууль тогтоомжийг нэгдэн орсон олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх; -Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх зохицуулалтыг Гэмт хэргийн тухай, Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Зөрчлийн тухай, Мөрдөх албаны тухай хуулийн төсөлд оновчтой байдлаар тусгах, -Эрүүгийн хуулийн хуулийн 113, 124 дүгээр зүйлд заасан хэм хэмжээг өөрчлөн найруулах, -Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах,
2	Монгол Улсад биеэ үнэлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг, зөрчил нэмэгдэх хандлагатай байна. Биеэ үнэлэгчдийн тоо нэмэгдэж, гудамж, талбайгаас саун массаж, зочид буудал руу шилжиж байна. Түүнчлэн, биеэ үнэлэгчдээс хохирогч элслүүлэх замаар хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх хандлага нэмэгдэж байна. Мөн биеэ үнэлэх явдлаас үүдэн ХДХВ/ДОХ-ын тохиолдлын тоо 179-д хүрч, үүний ихэнх нь биеэ үнэлэгчид байжээ.	-Садар самууныг сурталчлах, биеэ үнэлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагыг чангатгах, -Саун массаж, зочид буудлын үйл ажиллагааны стандартыг боловсронгуй болгох, тавих хяналтыг сайжруулах, -ХДХВ/ДОХ-ын халдвар авсан хүний бүртгэл судалгаа хийх, тавих хяналтыг сайжруулах чиглэлээр эрүүл мэнд, цагдаагийн байгууллагын хамтран ажиллах журам боловсруулан баталж мөрдөх, хамтын ажиллагааг сайжруулах,
3	Хүн худалдаалах гэмт хэргийн хүрээ уламж тэлж, суурь шалтгаан нөхцөл арилаагүй, тэмцэх хууль сахиулах байгууллагын тогтолцоо, харилцан ажиллагаа, хүн, хүч дутмаг, олон улсын хамтын ажиллагаанаас шалтгаалан тэмцэл үр дүнд хүрэхгүй байна. <u>Манай улсын үндэсний аюулгүй байдлын хэмжээнд нөлөөлж буй аюул, эрсдэл мөн.</u>	-Хүн худалдаалах гэмт хэргийн суурь шалтгаан, нөхцлийг арилгах, хүчин зүйлийн нөлөөллийг саармагжуулах, хуулиудын хэрэгжилтийг хангах зорилгоор өмнөх хөтөлбөрийн хэрэгжилт дуусч байгаатай холбогдуулан “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр” -ийг шинээр боловсруулж, батлуулан, хэрэгжүүлэх,



		-Урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалал, нөхөн сэргээх, гэмт хэргийг шийдвэрлэх (PPPP) ажлыг эрчимжүүлэх, тасралтгүйгээр зохион байгуулах, -Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гадаад, дотоодын санхүүжилтээр явагдаж буй төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг ХЗЯ, Дэд зөвлөлөөс уялдуулан зохицуулж, нэгдсэн байдлаар явуулахад удирдлага зохион байгуулалтаар хангах, энэ чиглэлийн сургалт, сурталчилгааг нэгдсэн бодлогоор явуулах, -Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ялангуяа сургалт, соён гэгээрүүлэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн сэтгэл зүйн хохирлыг арилгах чиглэлээр сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтэн, төвүүдийн үйл ажиллагааг дэмжиж, үүнд татан оролцуулах, -Энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хүмүүсээс харахад хувь хүний хүчин зүйлд сэтгэлгээний хандлага, амьдралын зорилго зорилтын зүйлсийг сэтгэл зүйн нөлөөлөл чиглэлээр сурталчлах, -Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах, төрийн болон төрийн бус байгууллагын хооронд мэдээллийн сүлжээг үүсгэж, харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллах эрх зүйн болон үйл ажиллагааны орчныг сайжруулах,
4	Хүн худалдаалах гэмт хэргийн хэлбэр, төрөлнэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, -гадаад, дотоодод бэлгийн мөлжлөгт өртөх -гадаад, дотоодод насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн мөлжлөгт өртөх -гадаадад хөдлөмрийн мөлжлөгт монгол иргэд өртөх -Монгол Улсад гадаадын иргэд хөдөлмөрийн мөлжлөгт өртөх -дотоодод хөдөлмөрийн мөлжлөг, боолчлох гэмт үйлдэл -хүний цус, эд, эрхтэнг хууль бусаар авахын тулд худалдаалах гэх мэт.	-Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж, дагнах тэмцэх хүн, хүчийг нэмэгдүүлэх, тэмцэх мэргэжилтэнг мэргэшүүлэх, сургах, -ХСИС-ийн харъяанд байгуулагдах Мөрдөгчийн сургуульд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, -Хууль сахиулагч, прокурор, шүүгч нараас хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх, хянах, шүүх чиглэлээр мэргэшүүлэх, давтан сургалтуудыг үе шаттай явуулах, -Хууль сахиулагч, прокурор, шүүгч нарын хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх сургалтыг ХЗЯ-аас нэгдсэн зохион байгуулалттайгаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулах, -Дотоодод монгол болон гадаад улсын иргэд хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн хяналт, хөдөлмөр, барилга, уул уурхайн зэрэг төрийн байгууллагын хяналтыг чиглүүлж ажиллуулах, -Хүүхэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болохоос, ялангуяа бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд хүүхдийн болон цагдаагийн байгууллагын хяналтыг чиглүүлэх,



	Умард Солонгос, Вьетнам, Филиппин улсын иргэд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх явцдаа энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох явдал гарч байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг болохын хувьд туйлын мэдрэмтгий, арга хэлбэрээ байнга өөрчилж, нууц далд, зохион байгуулалтанд орж байна. Энэ төрлийн гэмт хэрэг хүрээгээ тэлэхэд бэлгийн аялал жуулчлал голлох нөлөө үзүүлж байгаа бөгөөд насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлэх явдал гарч байна. Мөн хар тамхи, мансууруулах бодис гэх мэт зохион байгуулалттай бусад гэмт хэргүүдтэй хавсран үйлдэгдэх магадлал өндөр байна. Хэдийгээр албан ёсоор бүртгэгдсэн тохиолдол байхгүй ч цус, эд эрхтэний наймаа үйлдэгдэж болзошгүй байна.	-Хүний цус, эд, эрхтэнг хууль бусаар авах, хууль бус мэс засал хийх, гадаадын хөрөнгө оруулалтай эмнэлэг, эмчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, -Үрчлэгдсэн насанд хүрээгүй хүүхдийн эрх, ашиг сонирхлоог араас нь хяналт тавьж, хамгаалах тогтолцоог сайжруулах, -Хүн худалдаалах гэмт хэрэг голчлон үйлдэгдэж буй хотуудад болон хилийн чанадад холбогдох байгууллагын хүч, арга хэрэгслийг чиглүүлж, хяналт шалгалтыг чангатгаж, урьдчилан сэргийлэх судалгааг зохион байгуулах, -Монголднасанд хүрээгүй хүнийг бэлгийн мөлжлөгт, тэрдундаа секс жуулчлалд ашиглаж байна гэсэн мэдээллийг нухацтай мөрдөн байцаах, шалгах,
5	<u>Хүн худалдаалах гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэж буй байдалд төдийлөн эерэг өөрчлөлт гараагүй зэрэг нь судалгааны явцад ажиглагдлаа.</u> Хүн худалдаалах гэмт хэрэгтэйхйх тэмцэл нь хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж буй этгээдийг илрүүлэх, хэргийг нь хянан шийдвэрлэх, энэ гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах талаарх механизмыг сайжруулах шаардлагатай. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай, хар тамхи, хүн худалдаалах гэмт хэргийг гүйцэтгэх ажлын хүч, арга хэрэгслээр тэмцэхэд эрх зүйн орчин хангалттай биш байна. Судалгаанаас харахад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурорууд нь хүн худалдаалах гэмт хэргийн талаар нэгдсэн нэг ойлголт хангалтгүй байгаа байдал ажиглагдсан.	-Хүн худалдаалахтай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх зохицуулалтыг Гэмт хэргийн тухай, Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Зөрчлийн тухай, Мөрдөх албаны тухай хуулийн төсөлд оновчтой тусгах, -Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9.1.3 дугаар зүйлд “Гүйцэтгэх ажлын ажлыг цагдаагийн байгууллага гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор” гэдэг үгийн өмнө “Урьдчилан сэргийлэх” гэж нэмж оруулах, -Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт “Гүйцэтгэх байгууллага ... дор дурьдсан ажиллагаа явуулахад “прокурор” бичгээр урьдчилан зөвшөөрөл өгнө гэснийг “тухайн тойргийн ерөнхий шүүгчээс бичгээр зөвшөөрөл авна” гэж өөрчлөн найруулах, -Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.3-т “Гүйцэтгэх байгууллага хяналттай хүргэлт, хяналтын худалдан авалт арга хэмжээ явуулахдаа тухайн тойргийн ерөнхий шүүгчээс бичгээр зөвшөөрөл авна” гэж нэмэх, -Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтыг хүчингүй болгох, -НҮБ-аас гаргасан хүний эрхтэн шилжүүлэхтэй холбогдолдтой олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох асуудлыг судалж, шаардлагатай гэрээ, конвенцид нэгдэн орох, - Үндэсний хууль тогтоомжид туссан нэр томъёог нь Донорын тухай хуульд олон улсын жишигт нийцүүлэх, -Хүн худалдаалах гэмт хэргийг шалгах ажиллагаан дахь жишиг төлөвлөлт, зохион байгуулалт, хамтын ажиллагааны загварчлалыг гаргах,




		-Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомж зэргийг харьцуулсан, эсвэл энгийн үг хэллэгээр гэхдээ нэг мөр ойлгогдохоор тайлбарласан сургалтын хэрэглэгдэхүүнийг гаргах, -Энэ төрлийн сургалтыг тогтмол зохион байгуулж, үүгээр нэг төрлийн бус хэд хэдэн төрлийн жишээ нь хүн худалдаалах гэмт хэргийн тухайн үеийн нөхцөл байдал, үйлдлийн арга, тухайн үед хэргийг шийдвэрлэж буй байдал, анхаарах асуудлуудыг нарийвчлан үзүүлсэн сургалтыг зохион байгуулах, -Энэ төрлийн гэмт хэргийг мөрдөх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн шалтгаан нөхцлийг илрүүлж арилгах талаар ЭБШХ-д заасан агуулгыг нэг мөр ойлгох, хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах,
6	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрх, ашгийг хамгаалах механизмыг сайжруулах шаардлага байна.	-Энэ төрлийн гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах үндсэн механизмыг сайжруулах. Энэ нь тухай хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэх, гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүд ямар нэгэн эрсдэлд орохоос хамгаалагдана, -Хохирогч хамгааллын цогц үйлчилгээг бий болгох, хууль, эрх зүйн орчныг сайжруулах, -Хохирогчдод зориулсан “Хохирогчийг дэмжих сан” байгуулж, зардлыг цаг алдалгүй гаргаж ажиллах, -Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд, тэр дундаа хууль сахиулах болон шүүх тогтолцоонд ажиллаж буй хүмүүсийг сургах, хохирогсдод тусалцаа, хамгаалалт үзүүлэхэд тусгайлан нэмэлт төсөв төсөвлөх, хохирогсдыг тогтоох, илрүүлэх асуудлаар төрийн албан хаагчдыг бэлтгэх, хохирогсдыг хамгаалах үйлчилгээнд хамруулах албан ёсны процедурыг бий болгох, -Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсныхоо үндсэн дээр үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө хохирогсдод ЭБША явуулахгүй байх,
7	Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр төрийн бус байгууллагууд тодорхой үр дүнд хүрч, туршлагажиж байна. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд зохион байгуулалттай, нэгдмэл нэг зорилгын төлөө хамтарч ажиллах хэрэгтэй байна. Тухайлбал, төрийн байгууллагаас төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллах, тэднийг чадавхжуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Эргээд төр засгийн зүгээс гэрээлсэн ажлыг бодит үр дүнгээр тооцож, хийсэн ажилд нь хяналтаа тавих хэрэгтэй. <u>Энэ чиглэлийн төрийн бус байгууллагууд олон тоогоор байдаг боловч идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь цөөхөн байна.</u>	-Төрийн бус, олон улсын байгууллагаас явуулж буй хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх чиглэлийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдмэл байдлыг хангуулах, сургалтын чанар, хамрах хүрээг нэмэгдүүлэх, -Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн төрийн бус байгууллагын нийгмийн хариуцлага, үүрэг оролцоог нэмэгдүүлэх,



8	Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, зар сурталчилгаа, цахим орчин, нийгмийн сүлжээнд (<u>facebook, messenger, skype</u> гэх мэт) тавих хяналт сул, түүний хэрэглээ, хүрээ улам бүр нэмэгдэж байна.	-Хэвлэлмэдээллийн байгууллага, ялангуяатусгай хэрэгцээтсонингууд иргэдээс ирүүлсэн, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх магадлалтай заруудад болон интернэт дэх биеэ үнэлэлт, хүний наймааны талаарх асуудалд анхаарах хандуулж, хяналтын нэгдсэн тогтолцоотой болох, -Зар сурталчилгааны тухай хуульд заасан хариуцлагын тогтолцоог чангатгаж, хууль бус зарлал байрлуулсан, ийм зараас шалтгаалан хүн худалдаалах болон бусад гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах; -Биеэ үнэлэх, садар самууныг сурталчлах болон цаашлаад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд цахим ертөнц буюу нийгмийн цахим сүлжээнд тавих хяналт Мэдээлэл, технологи, харилцаа, холбооны газартай хамтран хэрэгжүүлэх, -Олон нийтийн сүлжээ ашиглан, түүнчлэн өөр бусад аргаар энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа гэдгийг энгийн, ойлгомжтой байдлаар сурталчлах, иргэдэд ойлгуулах замаар хууль сахиулах байгууллагаас энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох явдлаас хамгаалах нөхцлийгбий болгох, -Цагдаа, тагнуулын байгууллага дахь цахим гэмт хэрэгтэй тэмцэх алба, хүн хүчийг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай болжээ. -Хүн худалдаалах гэмт хэргийн талаар сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үүрэн телефоны операторуудыг ашиглан хэрэгжүүлэх, -Олон нийтэд хөдөлмөрийн мөлжлөгийн нэг хэргийг шүүж байгааг ил тодоор гаргаж хохирогчид ноцтой хохирол учирдаг гэсэн ойлголтыг бий болгож, хүлээн зөвшөөрүүлэх, -Олон нийтийн хүчээр гэмт хэргийн мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэдэг тогтолцоог бий болгох,
9	Хүн худалдаалах гэмт хэргийн ихэнх нь гадаадад үйлдэгддэг, эсвэл гадаад улсын иргэд холбогдож байгаа учраас олон улсын хамтын ажиллагаа нэн чухал байна.	-Монгол Улсын иргэдээ олноор оршин сууж ажиллаж, амьдардаг, сурдаг гадаадын улсад шаардлагатай тохиолдолд элчин сайдын яамд, эрх зүйн атташе ажиллуулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх, хөөцөлдөх, ялангуяа Малайз, Хонконг гэх мэт. -Эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцаа үзүүлэх гэрээ шаардлагатай улстай байгуулж, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, -Гадаадад байгаа Монгол Улсын иргэд хүн худалдаалахтай холбоотой гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад гадаадад суугаа элчин сайдын яамдын үйл ажиллагааг сайжруулж, холбогдох байгууллагуудтай хамтран үр дүнтэй ажиллах, зарим шаардлагатай улс оронтой хамтран ажиллах гэрээ байгуулж, харилцан мэдээлэл ажиллах боломжийг улам нэмэгдүүлэх.



10	Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх олон нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулах, ялангуяа төгсөх ангийн 9-12 дугаар ангийн сурагч, их, дээд сургуулийн оюутнуудад хүн худалдаалах гэмт хэргийн хор уршигийг таниулах, ойлгуулах, түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэг дутмаг байна. Хөдөө орон нутагт мөн анхаарах. Хөдөө их, дээд сургуульд суралцахаар орж ирсэн охидууд эрсдэлд өртөх магадлал байгааг судалгаагаар харуулсан байна.	-Хуульд заасны дагуу хүн худалдаалах гэмт хэргээ урьдчилан сэргийлэх зорилгоор дунд сургуулийн төгсөх анги, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгаж, түүний дагуу хичээл орж, анхан шатны мэдээлэл, таниулга, сэрэмжлүүлэг хийх.
----	---	--



ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫГ ИЛ ТОД БОЛГОЖ, УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Б.Батзориг

Тахарын ерөнхий газрын дэд дарга, доктор (Ph.D)



Авлигаас үр дүнтэй урьдчилан сэргийлж тэмцэхэд иж бүрэн, олон талт хандлага шаардлагатай.¹ “Авлигатай тэмцэх хамгийн эхний алхам бол засгийн газрууд ард түмэндээ ил тод, ардчилсан, хариуцлагатай байх явдал. Мөн ард түмэн ил тод, шударга байдлыг шаардаж байх хэрэгтэй.”² Өөрөөр хэлбэл, авлигатай тэмцэх олон талт цогц арга хэмжээний нэг нь төрийн байгууллагын ил тод байдлыг хангах явдал гэдгийг эрдэмтэн судлаачид төдийгүй, авлигатай тэмцэж үр дүнд хүрсэн улсын туршлага баталдаг.


Ямарваа нэгэн хууль дүрэмд захирагдахгүй дураараа авирлах

дуртай, ард түмэнд үйлчлэх төрийн албыг өөрсөддөө үйлчлэх байгууллага, мөнгө олох хэрэгсэл гэж хардаг хүмүүсийн хувьд хууль бус үйл ажиллагаа нь олон нийтэд ил болоход дургүй. Ил тод байдлыг хөндөхөд зайлшгүй авлига гэсэн ойлголтыг хөнддөг. Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлын талаарх мэдээллээ хуваалцъя.

Монгол Улс дахь улс төр, хууль хяналтын хүрэн дэх авлигын нөхцөл байдал³

Транспаренси интернэшнл олон улсын байгууллагаас жил бүр хийдэг судалгаанаас харахад Монгол Улс дахь авлигын түвшин сүүлийн 3 жил дараалан буурч байгаа боловч авлигад өртөх эрсдэлтэй орны ангилалд байсаар байна. /Зураг 1./

Зураг 1. Монгол Улсын Авлигын төсөөллийн индекс, оноор (0-10 үнэлгээгээр) Эх сурвалж: http://www.transparency.org/research/cpi/cpi_2008/0/



¹ Батлагдсанаас хойш 10 хүрэхгүй жилийн дотор 150 улс нэгдэн орсон НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн удирдгал хэсгээс

² Их Британи Улсын Транспаренси Интернэшнл байгууллагын гүйцэтгэх захирал Чандрашехар Кришнанний хэлсэн үгнээс.

³ Улс төр хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын төсөөллийн 2013 оны судалгааны дүнгээс. Цахим холбоос <http://iaac.mn/menu/24>




нөлөөлжээ.

Авлигын индекс сайжрахад нөлөөлсөн хуулийн зохицуулалтаас нийтлэг зүйлийг ажиглаж болно. Энэ бол ИЛ ТОД байдал юм.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээнээс харахад авлигын төлөв байдал буюу эрсдэл 2011 оноос дараалан буурсаар 73.6 пункт байна. (Зураг 2). Хэдий авлигын улс төр, хууль хяналтын байгууллагын үнэлгээ буурсаар байгаа ч 73.6% гэсэн үнэлгээ нь авлигын эрсдэл өндөр байгааг илэрхийлж байна.

Зураг 2. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөлөл оноор (0-100 үнэлгээгээр) Эх сурвалж: <http://iaac.mn/content/396#.VGCih86wrmQ1-5> үнэлгээний системийг 0-100 үнэлгээний системд хувиргасан.



Улс төрийн хүрээний авлигын голлон чиглэгдэж буй үйл ажиллагаа:

- уул уурхайн салбарын үйл ажиллагаа,
- бизнест болон намд эрх мэдлээ тогтоох үйл ажиллагаа,
- дэд бүтцийн салбарын үйл ажиллагаа өндөр үзүүлэлттэй байна.

Авлигын хэлбэрүүдийн түгээмэл тархацын үнэлгээ:

- намд хандив авах,
- лоббидох

- төрийн өмчийг завших,
 - санал худалдан авах,
 - хууль бус хандив авах
- Авлигын үед хэрэглэдэг аргууд:

- хамаарал бүхий этгээдэд давуу тал олгох,
- шууд өөрт нь өгөх, хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх,
- үйл ажиллагааны зардал болгож өгөх,
- мөрийтэй тоглож санаатай алдах,
- өмгөөлөгчөөр болон зуучлагчаар дамжуулан хээл хахууль өгөх, эд зүйлсийг зах зээлийн

дээр ашиг сонирхол нь нэгдэж нийлсэн хүрээлэл давамгайлсан

- хувийн эрх ашгийг урьтал болгосон нам дамжсан, нэг нутаг, нэг аймаг гэж нутгархсан хүрээлэл давамгайлсан
- найз нөхдийн хүрээлэл давамгайлсан

Авлигад хүчтэй нөлөөлж буй хүчин зүйлс:

- Төрийн албан дахь төрийн томилгоо
- бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхол улс төрд нөлөөлж буй байдал
- улс төрийн намын санхүүжилтийн механизм
- сонгуулийн өнөөгийн тогтолцоо
- Улсын Их Хурлын үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны дүнд авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлс:

- Улс төрийн томилгоо,
- улс төрийн хүрэн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхол,

Дурдсан судалгааны дүнгээс харахад нийтийн болон улс орны эрх ашгийг нэн тэргүүнд тавьсан улс төрийн бүлэглэлийн нөлөө маш бага, харин хувийн болон явцуу эрх ашгийг нэн тэргүүн тавьсан бүлэглэлүүдийн нөлөө монголын улс төрд хүчтэй байна.

Улс төрийн хүрээний авлига нь намд хандив авах, хувийн ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, ийм шийдвэр гаргуулахын тулд лоббидох, улс төрийн зорилготой хандив өгөх, авах, сонгогчдын саналыг



худалдан авах, төрийн өмчийг ашиглан шамшигдуулах, хувьдаа завших, өөрийн эрх мэдлээ худалдах, бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах зэрэг хэлбэрээр зонхилон илэрч байгаа нь Монгол Улс дахь улс төр болон бизнесийн бүлэглэлүүд хоорондоо нэгдэж нэг ашиг сонирхолтой болсоныг харуулж байна.

Улс төрийн авлига илүү их зохион байгуулалттай, илүү далд хэлбэртэй болж байгаа нь нийгэмд ноцтой сөрөг үр дагаварт хүргэнэ. Түүнчлэн, УИХ-ийн шийдвэр гаргах түвшинд авлигын эрсдэл өндөр байгааг судалгааны дүн харуулж байна.

Улс төр, хууль хяналтын байгууллага дахь тод байдал

Ил тод байдалхангалтгүй байх тохиолдолд авлига их байх эрсдэл өндөр, ил тод байдал сайжрах тутам авлига үүсэх эрсдэл багасдаг гэж үзвэл дараах энгийн томъёогоор улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх ил тод байдлыг тодорхойлъя.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрэн дэх ил тод байдал 2010 онд 12.6 хувь⁴ (100 онооны үнэлгээгээр) байсан бол 2014 онд 15.4 хувь болж сайжирсан боловч маш хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн байгууллагын ил тод байдал 100 үнэлгээ авахаас 15.4 гэсэн үнэлгээ авчээ.

Дээдэс нь суудлаа олохгүй бол доодос нь гүйдлээ олохгүй⁵ гэдэгчлэн авлигатай тэмцэх, шударга ёсыг тогтоон бэхжүүлэх үйлсийг уриалан манлайлагчид

⁴ Б.Батзориг. Авлигаас урьдчилан сэргийлэх нь: Засгийн газрын ил тод байдал //2011 онд “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” сэдэвт үндэсний чуулгауулзалт; УИХ-ын ТББХ, НҮБХХ-ийн “Захиргааны шинэтгэл: асуудал ба шийдэл” сэдэвт бага хуралд тавьсан илтгэлээс

⁵ Монгол ардын зүйр цэцэн үг

нь улс төрчид байдаг. Иймээс улс төрийн хүрээнийхэн өөрсдөө ил тод байдлыг эхлэх хэрэгтэй. Тухайлбал, улс төрийн намын санхүүжилт, сонгуулийн санхүүжилт, УИХ болон Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулалт, хэлэлцүүлэг, шийдвэрлэлт гэх мэт.

Улс төрийн хүрэн дэх авлигыг эрсдлийг нэмэгдүүлэх хүчин зүйлийн нэг болох Хуулийн төсөл боловсруулах үйл явцын хаалттай байдлыг энэхүү илтгэлээр хөндөн та бүхэнтэй санал солилцож байна.

Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байж, энэ эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан эдлэх талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1-д заасан.⁶ Төрийн эрх барих дээд байгууллагын төлөөлөгч болох УИХ-ын гишүүн мөн хуулийн 23 дугаар зүйлийн 1-т зааснаар иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах үүрэгтэй. Энэхүү үүргээ гүйцэтгэх, түүнчлэн, ард түмэн эрх мэдлээ хэрэгжүүлэх боломж нь УИХ-аас гаргаж буй шийдвэрүүд тэр дундаа хуулийн төсөл боловсруулах, батлах бүхий үйл явцыг ил тод болгох явдал юм.

Монгол Улсын Төрийн нууцын тухай болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл боловсруулах явц улсын нууцын зэрэглэлд хамаарахгүй.

Энэ нөхцөл байдлыг хоёр тохиолдолд ил тод байдлыг хангаж болно:

1. УИХ, Засгийн газраас

⁶ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. 1992 №1

гаргасан шийдвэр гаргах явц тодорхой нөхцөлд нууц байж болох ч батлагдсаны дараа хэн санаачилсан, хэн санхүүжүүлсэн, хэний хийсэн судалгаанд тулгуурлаж хийгдсэн гэх мэдээлэл ил байх,

2. УИХ, Засгийн газраас гаргах шийдвэрийн төсөл санаачлах, боловсруулахаас батлах бүхий үйл явц ил тод байх.

Дээр дурдсан мэдээллийг ил тод болгох нь улс төрийн хүрээний авлигаас урьдчилан сэргийлэхэд тустай. Олон улсын практикаас харахад, гадаад, дотоодын тодорхой бүлэглэлийн эрх ашгийг хамгаалах үйлдлийг санаатай болон санамсаргүй хийх тохиолдол гардаг. Энэ нь гишүүд болон албан тушаалтнуудыг бусдаас хараат болгож улмаар бусдын гар, хөл болохоос өөр аргагүй байдалд хүргэх эрсдлийг бий болгодог. Үүнээс хамгаалах нэг арга бол яах аргагүй үйл явцыг ил тод болгох явдал юм.

УИХ, Засгийн газраас гаргах шийдвэр гаргах үйл явцтай холбоотой ямар мэдээлэл ил байх шаардлагатай вэ?

1. Батлагдах хуулийн жагсаалт

2. Хуулийн төсөл боловсруулж эхэлсэн

3. Хуулийн төсөл боловсруулахыг анх хэн санаачилсан

4. Хуулийн төсөл боловсруулах ажлыг хэн санхүүжүүлсэн

5. Хуулийн төсөл боловсруулах ажилд ашиглагдаж байгаа судалгаа шинжилгээ ажил, түүний явц

6. Хуулийн төсөлд өгсөн албан ба албан бус саналууд

7. Хуулийн төсөл Засгийн



газар, Улсын Их хуралд хэлэлцэгдэх үеийн тэмдэглэлүүд

УИХ, Засгийн газраас гаргах шийдвэр гаргах үйл явцтай холбоотой ямар мэдээлэл ил байхын ач холбогдол:

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хамгаалах,

2. Улс төрийн хүрээний авлигаас урьдчилан сэргийлэх,

3. Улс төр, биенесийн хүрээний ашиг сонирхлын зөрчлийг ил болгох,

4. Хуулийн төсөлд олон нийтийн саналыг авах боломж нэмэгдэх,

5. Улс төрийн хүрээний талаарх хийсвэл төсөөлөл өөрчлөгдөх,

Одоогийн нөхцөл байдал ямар байна вэ?

Тус илтгэлийг бэлтгэх хүрээнд 2014 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр УИХ, Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон яамдын албан ёсны цахим хуудастай танилцахад дор дурдсан үр дүн гарч байна. Үүнд:

1. Улсын Их хурлын <http://www.parliament.mn/laws/projects> гэсэн цахим хуудсанд зөвхөн УИХ-ийн гишүүдийн өргөн барьсан хуулийн төслүүд

2. Засгийн газрын <http://zasag.mn/> цахим хуудас

3. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын <http://cabinet.gov.mn/> цахим хуудсанд хуулийн төсөл байхгүй

4. Хууль зүйн яамны http://moj.gov.mn/draft_law.html цахим хуудсанд УИХ-д өргөн барьсан болон боловсруулж буй хуулийн төсөл, тэдгээрийн үзэл баримтлал, танилцуулга

5. Сангийн яамны http://mof.gov.mn/?page_id=5991 цахим хуудсанд боловсруулж буй хуулийн төсөл

6. Боловсрол, шинжлэх ухааны яам <http://www.meds.gov.mn/frontpage> цахим хуудсанд хэлэлцүүлж байгаа журам

Бусад яамдын цахим хуудсанд боловсруулж буй төсөлтэй холбоотой мэдээлэл байхгүй эсхүл байрлуулах цэс алга байв.

Хуулийн судалгаа хийдэг судлаач, багш нартай уулзаж УИХ-аас батлагдсан хуулийн хувийн хэрэгтэй танилцах зөвшөөрөл авахад ямар хугацаа шаардагддаг талаар асуухад 1 сараас доошгүй хугацааны дараа тухайн мэдээлэлтэй танилцах боломж бүрддэг. Түүнээс

хуулбарлан авах боломж байдаггүй гэсэн болно.

Дүгнэлт

Асуудлыг шийдвэрлэхийн тулд нэн тэргүүнд асуудалтай нь тэмцэх үү эсхүл асуудал үүсгээд байгаа хүнтэй тэмцэх үү гэсэн шийдлийн нэгийг сонгох шаардлагатай бол хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх замыг эргэлт буцалтгүй сонгосон манай орны хувьд хүнийг авлигад өртүүлээд байгаа шалтгаан, нөхцлийгарилгаад дараа нь харьцангуй цэвэр тунгалаг орчинд авлигын гэмт хэрэг үйлдээд байгаа хүнтэй хатуу тэмцэх нь зүйтэй гэдэгтэй судлаачийн хувьд санал нийлдэг.

Иймд улс төрийн хүрээний буюу том авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд юуны өмнө УИХ, Засгийн газраас гаргах шийдвэр гаргах үйл явцтай холбоотой бүхий л мэдээллийг ил тод болгоход чиглэгдсэн эрх зүйн болоод зохион байгуулалтын арга хэмжээ авах саналыг дэвшүүлж, энэхүү сэдвийг та бүхний өмнө нээлттэй үлдээж байна.



**МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ
ИННОВАЦИ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Ж.Нямдулам

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх
зүй, криминологийн тэнхимийн дэд профессор,
доктор (Ph.D), цагдаагийн хошууч*

Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд улсынхаа хөгжлийн гарц, хэтийн төлөвлөлтөө тодорхойлсон хөтөлбөр боловсруулж, инновацийг эрчимжүүлэх тал дээр анхаарал хандуулж байгаа энэ үед Монгол Улс ч улс орныхоо хөгжлийн гарц, хэтийн төлөвлөлтийг боловсруулах, бүх салбарт инновацийг хөгжүүлэх, улс орны эдийн засгийг үр ашигтай, шинэ санаагаар хөгжүүлэх чиглэлийг баримтлах шаардлагатай байна.

Инноваци гэж шинэ бүтээмж, шинэ санааг эдийн засгийн эргэлтэд оруулж, үйлдвэрлэл, үйлчилгээ, төрийн удирдлагын салбарт дэвшилтэт үр нөлөө авчрах шинэ буюу шинэчлэгдсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ технологийн процесс, мөн удирдлага, зохион байгуулалт, санхүү, эдийн засгийн болон бусад шийдлүүд инновацийн үр нөлөө юм¹. 2012 онд Монгол Улс Инновацийн тухай хуулийг баталж, “инноваци” гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл явцыг хэлнэ гэж тодорхойлжээ.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газар улс орны эдийн засгийн хөгжлийн гол гарцыг уул уурхайн салбарт хандуулж, энэ салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татаж, уул уурхайн салбар эрчимтэй хөгжсөн. Харин сүүлийн 2 жилд энэ салбарыг сорьсон он жилүүд байж, зах зээлд алтны үнэ буурч, зарим уул уурхайн компаниуд хаагдаж, уул уурхайн томоохон төслийг хэрэгжүүлэгч Рио Тинто болон Монгол Улсын Засгийн газар хооронд татварын маргааны асуудал үүсч, ажиллагсдаа цомхотгох, уурхайг түр зогсоож, зарцуулалтаа царцаах арга хэмжээ авсан нь эргээд энэ нь ирээдүйг харсан шийдэл биш юм гэдгийг инновацилаг компаниуд олж харж байна. Өнөөдөр технологийн инновацийг уул уурхайн салбар дахь аль нэг дан ганц асуудлыг оновчлох энгийн хэрэгсэл гэж харахаас илүүтэйгээр уул уурхайн баялаг бүтээх иж бүрэн гинжин хэлхээг оновчлох үйл ажиллагааны технологи гэж харж байна.

Засгийн газар экспортын чиг хандлагатай үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд уул уурхайн салбарыг тус орны эдийн засгийн тэргүүлэх салбар болгон тодорхойлсон

бөгөөд тодорхой хөнгөлөлтийг эдлүүлэн байгаль орчинд сөрөг нөлөө багатай тэргүүний техник, технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах зэрэг таатай нөхцөл бүрдүүлэн ажиллаж, уул уурхайн салбараас улсын эдийн засагт оруулж буй хувь нэмэр өсч, 2010 онд 2.704.877.8 сая төгрөгний нэмүү өртөг үйлдвэрлэсэн нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 28.2%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 65.4 хувь, экспортын бүтээгдэхүүний 84.4 хувийг тус тус бүрдүүлж байна. (Хүснэгт №1)

Сүүлийн 10 жилд алт олборлолт 17 дахин, зэс-молибдений хүдэр олборлолт 30.4 хувь, хайлуур жоншны баяжмал үйлдвэрлэлт 14.6 хувиар тус тус өссөн байна. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ сүүлийн 6 жилийн дотор эрчимтэй өсч, улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нэмэгдэж байна. (Хүснэгт №2)

Монгол улс 2013 оны эхний улирлын байдлаар нийт 39 оронд бараа, бүтээгдэхүүн экспортлосноос БНХАУ-д 92.1 %, Канад улсад 2.4 %, ОХУ-д 1.9 %, Судан улсад 0.7 %, Энэтхэг улсад 0.6 %, БНСУ болон ХБНГУ-д тус бүр 0.4 %, Итали

¹<http://en.wikipedia.org/wiki/Innovation>.
Хандалт. 17.09.2014.



Хүснэгт №1.

Үзүүлэлт	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Дотоодын нийт бүтээгдэхүүний	10.1%	12.7%	17,3%	18.0%	30%	27.5%	28.2%	28.2%
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний	47.3%	49.6%	64,7%	65,5%	72%	67.8%	64.3%	65.4%
Экспортын нийт бүтээгдэхүүний	56.7%	58.9%	70.8%	75,8%	67.9%	68.8%	80.7%	84.6%

Хүснэгт №2.

Уул, уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ /сүүлийн 6 жилээр/

№	Бүтээгдэхүүн	х/нэгж	2008	2009	2010	2011	2012	2013
1	Бүхэллэг жонш	мян.тн	206.7	233.4	239.4	245	219.1	344.2
2	Флотацын баяжмал	мян.тн	102.7	93.7	108.3	109.9	115.7	115.3
3	Баяжмал дахь зэс	мян.тн	130	126.3	129.7	130.2	126.8	129.8
4	Баяжмал дахь молибдени	тн	1141	1153	1403.9	1978.3	1783.6	2408.7
5	Цагаан тугалганы баяжмал /50%/	тн	22	47	-	27.5	87.5	15
6	Гянт болдын баяжмал /68%/	тн	77.1	78.2	182.2	244.5	141.9	38.6
7	Нүүрс	мян.тн	6665	7517.1	8074.1	9237.6	9691.6	13163.9
8	Алт/химийн цэврээр./	кг	18500	21900	21267	18087	15184	9803
9	Катодын зэс	тн	2376.1	2474.5	2618.4	3006.5	2586.6	2470.1
10	Төмрийн хүдэр	мян.тн	33.5	167.7	180	265.1	1387.4	1379.0
11	Цайрын баяжмал /чийгтэй/	мян.тн	-	22.8	109.9	154.7	143.6	156.5
12	Цувимал зэс	тн	-	195.5	221.2	-	-	-
13	Молибденийн исэл	тн	-	-	157.8	2664	2112.2	156.5

болон Их Британи улсад тус бүр 0.3 %, Вьетнам улсад 0.2 % ногдож байгаа нь экспортын 99.3 хувийг эзэлж байна. Экспортын 98.0 %-г эрдэс баялаг, унэт ба хагас унэт чулуу, унэт металл, боловсруулсан арьс шир, ангийн ус, тэдгээрээр хийсэн эдлэл зэрэг эзэлж байна.²

Өнөөдөр манай улсад 10 гаруй нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явагдаж байгаа бөгөөд энэ нь ихэвчлэн анхан шатны боловсруулалт хийсэн баяжмал маягаар экспорлож байна. Цаашид нөөц нь тогтоогдсон

ашигт малтмалын орд газруудыг ашиглалтанд оруулахаас гадна одоо ажиллаж байгаа үйлдвэрүүд дээр технологийн шинэчлэл хийх, өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн гаргах чиглэлд анхаарах шаардлагатай юм. Үүний тулд уул, уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах, тогтвортой байдлыг хангаж өгөх, төрийн оролцоог зохистой хэмжээнд оролцуулах зэрэг нөхцөл, бололцоог бүрдүүлэх нь чухал юм. Дэлхийн томоохон эдийн засагчид үзэхдээ: аливаа улс орон уул, уурхайн салбараа хөгжүүлэх гол бодлого бол эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал юм. Хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн

улс орон хөгждөггүйг олон орнуудын жишээн дээр тулгуурлан тогтоосон байдаг.

Монгол Улсын эдийн засагт уул уурхайн салбарын хөгжил мэдээж эерэг нөлөө үзүүлэх нь гарцаагүй, гэхдээ бид энэ салбарыг болгоомжтой, удаан хугацаанд алгуур хөгжүүлэх нь чухал юм. Өөрөөр хэлбэл хэдхэн жилийн дотор улс орныхоо баялагийг гадаадын компаниудад олборлуулахгүйн тулд бодлогын хувьд нухацтай хандах хэрэгтэйг эрдэмтэн судлаачид анхааруулсаар байна.

Уул уурхайн яамнаас “Төрөөс эрдэс баялгийн салбарын талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг УИХ-аар батлууллаа.

² Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. Тайлан 2013 оны 1 дүгээр улирал. 2013 оны 4 дүгээр сарын 1-нд нийтлэгдэв. www.nso.mn



Энэхүү бодлогын баримт бичиг төрөөс эрдэс баялгийн салбарт 2025 он хүртэл баримтлах бодлогыг тодорхойлох юм. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын баримт бичиг нь үндсэн 4 бүлэг, 14 хэсэг, 70 заалтаас бүрдэж байгаа ба эрдэс баялгийн салбарт баримтлах зарчмуудыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор эрх зүй, татварын орчны талаар аливаа шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээнд суурилж, оролцогч талуудын хууль ёсны эрх ашгийг хохироохгүй байх;
- Олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих;
- Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж нээлттэй, ил тод, хариуцлагатай байх, хөрөнгө оруулагч нь хууль дээдлэх, харилцан ашигтай ажиллах, хэрэгжүүлэхэд төрөөс хөрөнгө оруулагчдад ижил тэнцүү нөхцөл олгож, өмчийн хэлбэрээр ялгаварлахгүй байх, компанийн сайн засаглалыг дэмжих;
- Улсын болон хувийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байгаа бүх шатны геологийн судалгаа, олборлолт, боловсруулалтын

ажлын талаарх хуулиар хориглоогүй мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй байлгах;

- Эрдэс баялгийн салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, стандартыг олон улсын түвшинд хүргэж, хэрэгжилтийг хангах зэрэг болно.

Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журам, ард иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” хэрэгжсэнээр улсын эдийн засагт оруулах уул уурхайн салбарын өгөөж нэмэгдэж, эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын нэг цонхны бодлого бодитойгоор хэрэгжиж, эдийн засгийн хөгжил дан ганц нэг салбараас хамааралгүйгээр олон тулгуурт эдийн засгийн хөгжлийн үндэс бүрдэх юм.

Үүнтэй зэрэгцэн уул уурхайн салбарын эрх зүйн орчны асуудал дахин түлхүү яригдаж, ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэх хуулийн төслийн хэлэлцүүлэг хийгдэж байгаа үетэй холбогдуулан энэ асуудлыг хөндөн тавих нь зайлшгүй асуудал болоод байна.

Өнөөдөр манайд уул уурхайн салбарт 34 хууль тогтоомж, 183 хэм хэмжээний акт, 295 стандарт үйлчилж байна³. Эдгээрээс уул уурхайн салбарын харилцааг зохицуулсан гол хууль болох Ашигт малтмалын тухай хууль анх 1994 онд батлагдаж, 3 жилийн хугацаанд хэрэгжин 1997 онд шинэчлэгдэн, 2006

онд одоогийн мөрдөж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. Энэ шинэчлэн найруулсан хуульд өмнөх хуулиас зарчмын ялгаатай олон зүйл, заалтууд орсон. Тухайлбал, ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдолтой, түгээмэл тархацтай, энгийн гэсэн ангилалтай болгож стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордыг ашиглахад хэний хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосноос үл хамаарч төрийн оролцоотой байхаар хуульчилсан. Мөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээг нэмэгдүүлсэн, хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч Засгийн газрыг төлөөлж санхүү, геологи, уул уурхайн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах боломжтой болсон. Түүнчлэн, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн.

Эдгээр хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчигдсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх бүхий этгээдүүд нь эрх бүхий улсын байцаагч болон тухайн орон нутгийн Засаг дарга юм. Эдгээр субъектүүдийн хуулиар олгогдсон эрх хэмжээ өргөн боловч харин хуулийн хэрэгжилтэд хяналт тавих нь сул байгаа нь өнөөгийн бодит байдлаас харагдаж байгаа юм. Дээрххуулиудын хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүрэг бүхий Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улсын Мэргэжлийн хяналтын

³ www.legalinfo.mn



ерөнхий газраас 2013 явуулсан шалгалтаар байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэнд өгсөн үнэлгээгээр нийт аж ахуйн нэгжийн 15.8% нь сайн, 36.8% нь хангалттай, 47.4% нь хангалтгүй гэж үнэлэгдсэн байна. Мөн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээгээр нийт аж ахуйн нэгжийн 10.5% нь сайн үнэлгээ авч, 68.4% нь хангалтгүй үнэлгээ авчээ. Энэ нь хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага болон уул уурхайн компаниудын хууль, дүрэм, журмын хэрэгжилт сул байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын Засгийн газар сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд ашигт малтмалын лиценз олголтыг хязгаарлалт, хяналт нарийн тогтоолгүйгээр ихээр олгосноор «нийгмийн хариуцлага»-гүй гадаад, дотоодын уул уурхайн компаниуд олборлолт явуулахдаа тогтоосон хэмжээнээс хэтэрсэн химийн хорт бодис ашиглах, ашигт малтмал цэвэрлэсэн усаа голын урсгал руу шууд урсгах, үүнээс болж хүн, амьтан хордож, гол горьхи ширгэж, олборлолт явуулсан газартаа нөхөн сэргээлт хийхгүй орхих, овоолоод орхисон шороо, нүхэнд нь хүн, мал унаж осолдох явдлууд сүүлийн жилүүдэд эрүүгийн тоо бүртгэлд өссөн үзүүлэлт гарч байгаа нь энэ салбарт хуулийн хяналтыг чангатгах, эрх зүйн орчинг сайжруулах асуудал яригдах үндэс болсон юм.

Энэ үүднээс Монгол Улсын Загийн газар 2011 онд улсын хэмжээнд усны тооллого явуулсан⁴. Уг тайланд Монгол улсын хэмжээнд нийт 5128 гол, горхи бүртгэгдсэнээс 852 нь ширгэсэн, 9306 булаг, шанд бүртгэгдсэнээс 2277 нь ширгэсэн, 3747 нуур, тойром бүртгэгдсэнээс 1181 нь ширгэсэн, 429 рашаан ус бүртгэгдсэнээс 60 нь ширгэсэн гэжээ. Энэ нь нэг талаас голын сав газрын хөрс, ургамал бүрхэвчийн өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлт, ноогөө талаас уул уурхайн буруу үйл ажиллагааны улмаас усны горим, нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэж байгаатай холбоотой юм. Баримт дурдахад Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт үйл ажиллагаагаа явуулдаг «Алтан Дорнод», «Монгол газар» компаниуд тус сумын нутагт байрлах Орхон голын урсгал руу алт угаасан усаа урсгаснаас болж Орхон гол бүхэлдээ бохирдон, уг хэрэг өнөөг хүртэл шүүхээр шийдвэрлээгүй байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль⁵-иар эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий субъектэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор байхаар хуульчилсан.

⁴ Монгол Улсын Засгийн газрын хэрэгжуулэгч агентлаг Усны хэрэг эрхлэх газраас 4 жил тутамд улсын хэмжээнд усны тооллогыг явуулдаг. Энэ жил 2011 оны тооллого явуулж, тайлан гаргажээ. Усны хэрэг эрхлэх газрын 2011 онд явуулсан усны тоологын дүн. Өнөөдөр сонин. 2013 оны 7 дугаар сарын 9-ны дугаар №286

⁵ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. Төрийн мэдээлэл. УБ. 2002. №.1

Монгол Улсад одоогоор экологийн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах тусгай мэргэшсэн мөрдөн байцаагч, прокурор байхгүй бөгөөдүүнтэй холбоотойгоор энэ гэмт хэргийн байгаль орчинд учруулсан бодит хохирлыг тогтоох, хэргийн газрын үзлэгийг нарийвчлан хийх, хэмжилтийг буруу хийх, нотлох баримтыг дутуу үнэлэх зэрэг хүндрэл байгаа нь судалгааны явцад харагдаж байлаа.

Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэгт явуулах мөрдөн байцаалтын ажиллагаа нь бусад гэмт хэргээс өвөрмөц онцлогтой бөгөөд, тэр дундаа байгаль орчинд учирсан бодит хохирлыг тогтоох асуудалд мэргэжлийн байгууллагын шинжээчдийг оролцуулан дүгнэлт гаргуулдаг, гэвч хэргийн нотолгоо нь дан ганц тэр дүгнэлт дээр тулгуурлаж хийгдсэн нь уншиж танилцсан эрүүгийн хэргүүдээс харагдаж байлаа. Эдгээр дүгнэлт нь зөвхөн байгаль орчны экологийн хохирлыг тогтоосон дүгнэлт гаргаж байгаа нь өрөөсгөл бөгөөд уг хэргийн шийдвэрлэхэд бодит нотлох баримт болж чадахгүй байна. Тиймээс энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд экологийн бодит хохирлыг эдийн засгийн тооцоон дээр бодитой тогтоох шаардлагатай юм. Үүний тулд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд энэ төрлийн шинжилгээний хэлтсийг байгуулах, мэргэшсэн шинжээчдийг бэлтгэх шаардлагатай байна.



ХЭРЭГЛЭГЧИЙН ЗҮЙ БУС ҮЙЛДЭЛТЭЙ ХОЛБОГДОН ҮҮСЧ БУЙ ХАРИЛЦААГ ЭРХ ЗҮЙГЭЭР ЗОХИЦУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Б.Мөнгөннахиа, Ж.Хулан

Санхүү эдийн засгийн дээд сургуулийн багш



Хэрэглэгчийн зүй бус үйлдэл, түүнтэй холбогдон үүсч буй эрх зүйн харилцааг эрхзүйгээр зохицуулах хэрэгцээ, шаардлагын тухай өгүүлэхийн өмнө хэрэглэгч гэж хэн вэ? Хэрэглэгчийн эрхзүй гэж юу вэ? гэдгийг тодорхойлох нь зүйтэй болов уу.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 3.1.1-д “Хэрэглэгч гэж бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад зориулан захиалж, худалдан авч, үйлчлүүлж байгаа, эсхүл хэрэглэж байгаа хувь хүнийг хэлнэ” хэмээн томъёолсон байдаг. Харин хэрэглэгчийн эрхзүй гэдэг нь иргэдийн материаллаг, соёлын болон бусад хэрэгцээг хангахад чиглэсэн харилцааг зохицуулж буй хэд хэдэн салбар эрхзүйг (захиргааны эрх зүй, иргэний



эрхзүй, эрүүгийн эрхзүй гэх мэт) бүрдүүлэгч эрхзүйн институт юм. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрхзүйн зохицуулалт манай улсад 1990-ээд оноос бүрдэж эхэлсэн бөгөөд “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль” (2003 онд шинэчлэн найруулсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хууль үйлчилж байгаа), Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс сайшаан дэмжсэн “Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад баримтлах үндсэн зарчим”, “Монголын хэрэглэгчдийн эрхийн тухай тунхаг” зэрэг хууль тогтоомж, эрхзүйн актуудаар баталгаажуулан, зохицуулж байна. Мөн Иргэний хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Ариун цэврийн тухай хууль, Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай хууль зэрэг нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах

эрхзүйн орчинг бүрдүүлж байгаа бол хэрэглэгчийн эрхийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын түвшинд хамгаалж байна. Сүүлийн жилүүдэд хэрэглэгчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалахад чиглэсэн бодитой ажлууд хийгдэж байгаа хэдий ч төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.

Гадаадын зарим улсад хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрхзүйн орчин хангалттай хэмжээнд бүрдсэн гэж дүгнэж болохоор байна. Тухайлбал, АНУ-ын 35 дахь Ерөнхийлөгч Жонн Кеннеди улсынхаа үндэсний эрх ашгийг хамгаалах үүднээс энгийн америк иргэн-хэрэглэгчийн эрхийг тэнцвэржүүлэн баталгаажуулж америкийн хэрэглэгчийн үндсэн таван эрхийг тунхагласан нь эдүгээ Хэрэглэгчийн олон улсын байгууллага (The consumers international)-ыг үүсгэн байгуулах суурь болсон төдийгүй НҮБ-ын 1985 онд баталсан “Хэрэглэгчийг хамгаалах дүрэм”-ийн эхлэл болжээ. Олон улсад хэрэглэгчийн эрхийг хамгаалахаар 1960 онд үүсгэн байгуулагдсан Лондон хотод төвтэй “Хэрэглэгчийн



олон улсын байгууллага” болон 1972 онд байгуулагдсан Брюссель хотод төвтэй “Европын хэрэглэгчийн эрхийн байгууллага”-ууд нь идэвхтэй ажиллаж байна.

Хэрэглэгчийг хаанд өргөмжилдөг нь зүй ёсны асуудал, хэрэглэгчгүйгээр ямар ч бизнес явагдахгүй нь мэдээж. Тийм ч учраас хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль нь хэрэглэгчийн хүсэл сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой байдаг.

Гэтэл хэрэглэгчийн зүй бус үйлдэл буюу орос хэлнээ “потребительский экстремизм” хэмээх үзэгдэл нь сүүлийн жилүүдэд түгээмэл болжээ. Бид зөвхөн хэрэглэгчийн эрхийг хамгаалах гэж туйлшралгүйгээр үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн эрхийг хамгаалах тухай зэрэгцүүлэн зохицуулах шаардлага хэрэглэгчийн зүй бус үзэгдлээс урган гарч ирээд байна. Юуны түрүүнд нэгдүгээрт: Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч гэж хэн вэ? хоёрдугаарт: Хэрэглэгчийн зүй бус үйлдэл гэж юу вэ? гуравдугаарт: Бизнес хийж байгаа үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн эрхийг хэн, хэрхэн хамгаалах вэ? гэдэг асуудлыг зохицуулах эрхзүйн орчинг судлах, эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байна.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 3.1.2-д “Худалдагч гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран хэрэглэгчид бараагаа борлуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч болон хувь хүнийг хэлнэ”, 3.1.3-

д “Үйлдвэрлэгч гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран хэрэглэгчид борлуулах зорилгоор бараа үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч болон хувь хүнийг хэлнэ”, 3.1.4-д “Гүйцэтгэгч гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран хэрэглэгчид төлбөртэй болон төлбөргүй ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч болон хувь хүнийг хэлнэ” гэжээ.

Тэгвэл Хэрэглэгчийн зүй бус үйлдэл гэдгийг хоёр янзаар тодорхойлбол:

- Хэрэглэгчийн зүгээс эрх ашгаа хамгаалах бус, арга заль хэрэглэж, эд хөрөнгийн болон ашиг хонжоо, орлого олох зорилгоор хуулийг шударга бусаар ашиглаж буй үйлдэл,
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрхзүйн зохицуулалтыг зүй бусаар ашиглах замаар ашиг хонжоо, орлого олох зорилгоор хийгдэж буй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ хүртэж байгаа хэрэглэгчийн зан үйл гэж хэлж болох юм.

Хэрэглэгчийн зүй бус үйлдэл буюу “потребительский экстремизм” гэдэг нэр томъёо нь албан бус бөгөөд манай улсын холбогдох хуулиудад буюу дээр дурдсан хуулиудад хэрэглэгчийн зүй бус үйлдлийн талаар тусгаагүй, хэрэглэгчийн эрх хийгээд эрх нь зөрчигдсөн тохиолдолд эрхээ хэрхэн хамгаалуулах, гэм хороо хэрхэн нэхэмжлэх (Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (2003),

Иргэний хууль, 254, 512 дугаар зүйл (2002) болон худалдагч, үйлдвэрлэгч, гүйцэтгэгчийн үүргийн (Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн гуравдугаар бүлэг) заасан байдаг.

Гэвч Хэрэглэгчийн зүй бус үйлдэл буюу потребительский экстремизм гэх ойлголт нь ОХУ-д 1992 оноос эхлэн хэрэглэгдэж иржээ. Энэ нэр томъёо нь “Аяга кофений хэрэг” буюу 79 настай Стелла Либек McDonald's эсрэг 1992 оны шүүхийн хэрэгтэй холбоотойгоор гарч иржээ. Стелла Либек нь McDonald's хоолны газар халуун кофе ууж байхдаа зориудаар өөр дээрээ кофегаа асган өөрийгөө хохирогч болгон McDonald's-оос хохирлоо барагдуулахаар нэхэмжилсэн байна. Стелла Либекийн биеийх нь 16 хувь нь халуун кофенд түлэгдсэн байжээ. Эхэндээ компани нэхэмжилж буй төлбөрийг төлөхөөс татгалзсан ч эцэст нь түүнд 640 мянган америк доллар төлжээ.¹ McDonald's-ийн ийм төрлийн 700 гаруй гомдлоос зөвхөн Стелла Либек хохирлоо барагдуулж чадсан байна. Өөр нэгэн хэрэглэгчийн зүй бус үйлдэлтэй холбоотой жишээ дурдвал “Wendy's” сүлжээ зоогийн газар болон Anna Ayala-ийн хооронд үүссэн хэрэг. Anna Ayala 2005 оны 3 дугаар сарын 22-нд Wendy's түргэн хоолны сүлжээ зоогийн газраар үйлчлүүлэх үед түүний захиалсан чилитэй хоолонд нь хүний хуруу байсан гэдгийг баталснаар энэхүү хэрэг манджээ. “Good Morning America” гэх телевизийн нэвтрүүлгээр тэрээр 1.5 инчийн урттай хүний хуруу хазах үед хүний биеийн хэсэг миний аман

¹<http://www.dailymail.co.uk/news/article-2470792/Stella-Liebeck-hot-coffee-McDonalds-lawsuit-The-truth.html>



дотор байгаа гэдгийг мэдэх үнэхээр огиудас хүрмээр байсан. Энэ нь намайг дотроос нь яг л хувааж байгаа мэт сэтгэгдэл төрүүлсэн. Ямар нэг таагүй зүйлийг хазсаныхаа дараа түүнийгээ нулимж гаргаад менежерт нь гомдол гаргасан тухайгаа ярьжээ. Anna Ayala-ыг энэ нэвтрүүлэгт орсны дараа АНУ хэвлэл мэдээллээр энэ тухай шуугих болжээ. Түүний зохиосон хурууны түүхэнд хэрэгт шаардагдах бүхий л элементүүд байсан байна. Wendy's зоогийн газрын зүгээс энэ хэргийг эрс эсэргүүцэж хурууны тухай үнэн бодит мэдээлэл өгсөн хүнд 50000 ам.доллар амласан ба хожим нь шагналын сангаа 2 дахин нэмэгдүүлжээ. Гэхдээ энэ хэрэг Wendy зоогийн газрын талд шийдэгджээ. Калифорн мужийн Сан Хосе хотын цагдаагийн газраас хэргийг шалгаж Невада мужийн цагдаагийн газартай хамтран 4 сарын 8-нд Ayala-гийн гэрт нэгжлэг хийснээр түүнийг энэ хэргийг зохиомлоор бий болгосон тухай нь илрүүлсэн. Тэрээр чилиний аяганд Brain Paul Rossiter-ын тасарсанхурууг чанаж улмаар Wendy's-ийн хүнсний агуулахад түүнийгээ нуусан байжээ. Anna Ayala энэхүү хэргээ Sandy Allman гэх эмэгтэй рүү бар дайрснаас болж хуруу нь тасарсан гэх хэргээс санаа авсан тухайгаа мэдүүлэгтээ хэлжээ. Энэ нь түүний өөрийнх нь хуруу биш байсан, нөхөртэй нь хамт зам засварын компанид ажилладаг хүний хуруу байсан ба нөхрийх нь найз Brain Paul Rossiter ачааны машины буулгах механизмд гараа хавчуулж улмаар хуруугаа алдсан байхад нь хурууг нь өөрийн зальт санаандаа ашигласан тухай хэлсэн байна. Мөн тэрээр

хэлэхдээ “Wendy's -ийн хоолны жорын дагуу Невада мужийн Лас Вегас хот дахь гэртээ чилитэй хоолыг хийж хэдэн сар хадгалаад Калифорни мужийн Сан Хосе хот руу зөөж Wendy түргэн хоолны газрын хоолноос олсон мэт жүжиглэсэн” гэжээ. Ayala-гийн энэ үйлдэл нь анхны үйлдэл биш бөгөөд өмнө нь бас нэгэн хоолны сүлжээнээс (El Pollo Loco) охин нь хоолонд нь хордсон гэдгийг баталснаар 30000 доллар авсан байжээ. Ayala нь Wendy's-ийн хэрэгт 9 жилийн ял сонсч, 4 жилийг биеээр эдлэн 5 жилийг тэнсэн харгалзжээ. Тэрээр суллагдсаныхаа дараа КРИХ-д өгсөн ярилцлагадаа “Би маш их өөрчлөгдсөн, шорон хүнийг өөрчилдөг юм байна, би амьдралаа шинээр эхэлнэ, хийсэн үйлдэлдээ харамсаж байна. Би маш олон хүнийг өөрийнхөө тэнэг байдлаас болж гомдоосон. Гэр бүл, үр хүүхдүүдээ ч мөн адил” гэжээ. Түүний Wendy's-н тухай тараасан сөрөг мэдээллээс болж сүлжээ зоогийн газар 21 сая ам.долларын борлуулалтын орлого алдсан гэсэн тооцоо Сан Хосе хотын сонинд нийтэлсэн байна.²

Бас нэг жишээ дурдвал: Тоёотагийн хурдны системийн доголдлын улмаас хүний амь нас хохирч, гэмтэл учирлаа гэх хэрэг (2013 оны 10-р сарын 09) АНУ-ын Оклахама хот-Тоёота мотор корпорацийн үйлдвэрлэдэг Камри загварын суудлын авто машинд гарсан доголдлын талаар шүүхэд ханджээ. Ослын шалтгаан нь Камри машин гэнэт жолоодлогогүй болж, нэг эмэгтэйн амь нас хохирч, мөн нэг хүн гэмтсэн байна. Хэргийн

² <http://www.dailymail.co.uk/news/article-2282853/Woman-planted-severed-finger-Wendys-chili-caught-lying-police-son-shooting-foot.html>

тухайд Камри машины жолооч Jean Bookout (76 настай)-ийн өмгөөлөгч Jere L. Beasley-ийн хэлснээр 2007 оны есдүгээр сард Оклахама хотын хурдны зам дээр Bookout-ын 2005 онд үйлдвэрлэгдсэн камри машин нь гэнэт ямар ч жолоодлогогүй болсон ба тэрээр машинаа зогсоож чадахгүй байсаар осолдсон. Ослын үед Bookout өөрөө гэмтэж түүний найз 70 настай Barbara Schwarz нас барсан байна. Оклахама хотод болсон шүүх хурал эхлэх үед өмгөөлөгч Beasley “Тэд хурдны системийнхээ доголдолын талаар 2004 оноос хойш мэдэж байсан. Энд бид жолоочийн хариуцлагаас шалтгаалаагүй авто ослын талаар ярьж байна гэжээ. Энэ шүүх ажиллагаа Тоёотагийн машин гэнэт хурдалдаг гэж мужийн болон холбооны шүүхэд ирсэн хэдэн зуун хэргийн нэг боловч Bookout-ийн хэрэг нь электрон хурдны системийн удирлагын буруугаас шалтгаалсан гэх анхны нэхэмжлэл юм. Тоёотагийн өмгөөлөгч J. Randolph Bibb мягмар гарагт болсон шүүх хурал дээр хэлэхдээ “машиньг осолд оруулах ямар нэгэн гэмтэл согог байхгүй энэ осол нь манай компанийн техникийн ослоос шалтгаалаагүй, мэдэхгүй зам дээр буруу гарц сонгосныхаа дараа 76 настай Jean Bookout 2005 оны камри машиныхаа үйл ажиллагааг хянаж чадалгүй өөрөө алдаа гаргасан. Мөн тэрээр сандрахдаа тоормозны оронд хааз гишгэсэн байж болно” гэжээ. Тоёота корпораци 10 сая гаруй машинаа 2009-2010 оны хооронд эргүүлэн татсан байна. Анх 2009 онд 3.8 сая Тоёота болон Лексус машинуудаа хаазны гишгүүрийн согогтой



гэсэн шалтгаанаар эргүүлэн татаж эхэлжээ. Тээврийн хэрэгслээ буцаан татсанаар Тоёота корпорацийн машины нэр хүнд буурч, 1.6 тэрбум долларын хохирол учирсан байна. Мөн машинаас болж гэмтэж бэртсэн гэх маш олон нэхэмжлэл иржээ. Тухайлбал Нью-Йоркболон Филадельфиягийн хэргүүд, Мичиган муж болон Калифорния мужийн шүүхэд дуудагдсан хэргүүдийг дурдаж болно. Гэхдээ нэхэмжлэл бүрт Тоёота ялсан байна.

Дээрх Bookout-ийн хэрэг дөрөөний гишгүүр нь машин гэнэт хурдалсныг бүрэн тайлбарлаж чадахгүй байгаа бөгөөд энэ нь электрон тохируулгын системийн буруутай гэдгийг баталж чадахгүй байгаа. Bookout-ийн 2005 оны Камри машин нь буцаан татах машинуудад багтаагүй. Электрон тохируулгын систем гэдэг нь хурдны дөрөөг хэр хүчтэй гишгэж байгааг мэдэрч тохируулагчийг нээж хаадаг компьютерт дохио илгээдэг систем юм. Тоёота электрон тохируулгын системийн гэмтэл согогыг болон Bookout-ийн Камри машинд гарсан гэмтлийг үгүйсгэжээ. Удаа дараагийн бие биенээсээ хамааралтай бус үнэлгээнүүдээр маш олон машинд суулгасан электрон тохируулгын системийн аюулгүй байдлыг үнэлсэн ба энэ маш найдвартай систем юм гэж Тоёота корпорацийн хэвлэлийн албаны төлөөлөгч Carly Schaffner шүүх хурал болохоос өмнө хэлжээ. Тэрээр мөн гэнэт хурдалсны шалтгаан нь Тоёота электроникс гэдэг үндэслэлгүй худлаа зүйл бөгөөд гэнэтийн ослын тоормозны систем нь энэ гэнэтийн

ослоос урьдчилан сэргийлж чадахгүй байсан гэдэгт бүрэн итгэж байна гэжээ. Үндэсний Замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлагын төвөөс (The National Highway Traffic Safety Administration-NHTSA) Тоёотагийн загварууд дээр 10 сарын турш хийсэн судалгааны үр дүн 2011 оны 2-р сард гарч, гэнэт хурдалсан шалтгаан нь ямар нэгэн электроникийн нөлөөнөөс болоогүй гэсэн дүгнэлт гаргасан юм. Машинд электрон болон програм хангамжийн асуудлуудаас гадна нөлөөлж болох маш олон хүчин зүйл бий. Мөн энэ осол шууд машины электроникийн буруу ажиллагааны улмаас гарсан гэж дүгнэж болохгүй гэж Мичиган мужийн Анн Арбор хотын Автомотивын судалгааны (Center for Automotive Research) төвийн Үйлдвэрлэл, технологи, инженерийн албаны дэд захирал Brett Smith-ээс утсаар авсан ярилцлагын үеэр хэлжээ.³

Энэ мэтчилэн хэрэглэгчийн зүй бус үйлдлээс болж үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч нар хохирдог болох нь дээрх жишээнээс харагдаж байна. Эдгээр нь дэлхий нийтээр шуугиан тарьсан алдартай жишээнүүд, харин өдөт тутмын амьдралд энэ мэтчилэн хичнээн хэрэглэгч зүй бус авирлаж үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийг хохироож байгааг бид мэдэхгүй. Тухайлбал, саяхан ОХУ-д иргэн А нэгэн тавилгын үйлдвэрээс хоёр ширхэг номын тавиур худалдан авчээ. Түүний хүү нь нэлээн том биетэй нэгэн бөгөөд хананд бэхлэгдсэн номын тавиурт спортын хэрэгсэл өлгөж, түүнээс зүүгдэн дасгал

хийж байгаад тавиуруудыг эвдсэн байна. Гэтэл иргэн А тавилгын үйлдвэрийг чанар муутай тавиурууд хийж өглөө хэмээн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Яг үнэндээ номын зориулалттай тавиур нь хүнийг яаж даах вэ дээ! Ийнхүү нэхэмжлэлдээ үйлдвэрийн зардлаар шинээр номын тавиуруудыг хийж угсрах, элэгдэж, хуучирсан өрөөний хана, таазыг засварлах, энэ явдлаас болж эвдэрсэн зөөврийн компьютерийг богино хугацаанд засварлаж өгөх, түүнчлэн сэтгэл санаа нь хямарсан учраас эмчид үзүүлсэн төлбөр, фитнес клубт үйлчлүүлэх 12 сарын эрх, тайвшруулах эм худалдаж авсан зардлуудыг нэхэмжилжээ. Энэ нь мөн л хэрэглэгчийн буруу үйлдлээс болж худалдагчаас хохирлоо барагдуулахаар шаардсан тохиолдол байна.

Худалдан авагч хувцас, цахилгаан бараа гэх мэт барааг худалдан аваад хэд хоногийн дараа эсвэл маргааш нь дэлгүүрт нь буцаалт хийгээд, төлсөн мөнгөө эргүүлж авдаг үзэгдэл бусад орнуудад байдаг. Тухайлбал, гоёлын даашинзыг өндөр үнээр худалдан авч байхаар нэг үдэш цэвэрхэн өмсөөд дэлгүүрт нь буцааж өгөх нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй. Ийнхүү буцаахыг хэд хэдэн оронд хуулиар нь зөвшөөрсөн байдаг. Жишээ нь, ОХУ-ын “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль”-ийн 25-р зүйлд “Зохих чанарын шаардлага хангасан хүнсний бус бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгч солих эрхтэй. Хэрэв тухайн бараа бүтээгдэхүүн нь хэлбэр, овор, хэмжээ, хэв маяг, өнгө, размер болон иж бүрдэл нь нийцэхгүй байвал хэрэглэгч

³ <http://www.autonews.com/article/20131009/OEM11/131009855/toyota-speed-up-defect-caused-death-injury-lawyer-tells-jury>



14 хоногийн дотор солих эрхтэй. Гэхдээ тухайн бараа нь өмсөж хэрэглээгүй, шинэ байх, барааны шошго тэмдэг, лац ломбо, этикет, худалдаж авсныг гэрчлэх талон, чек зэрэг байх ёстой. Хэрэв хэрэглэгчид талон байхгүй бол гэрчийн мэдүүлгийг нотолгоо болгон авч үзэж болно” гэж заажээ.⁴ Энэ нь хэрэглэгчийн эрхийг хамгаалсан зүйл заалт боловч эсэргээрээ үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн эрхийг хамгаалах эрхзүйн зохицуулалт мөн л үгүйлэгдэж байна. Хэрэглэгчийн зүй бус үйлдлээс болж үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч нар хохирсоор л байна.

Харин манай улсын хувьд хууль зүйн талаасаа хэрэглэгчийн зүй бус үйлдэл нь эрхээ урвуулан ашиглах үйлдэл гэж үзэж болно. Хэрэглэгчийн зүй бус үйлдлийн улмаас худалдагч, үйлдвэрлэгч, гүйцэтгэгч хохирсон тохиолдолд тэдгээрийн гомдлыг үндэслэн цагдаа, шүүхийн байгууллага хуулийн этгээдийнх нь хувьд эрхийг нь хамгаална. Харин Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар Өрсөлдөөний тухай хуулийн дагуу өөрийн чиг үүрэгтээ хамааруулан эрхийг нь хамгаална. Мөн Иргэний хуулийн 13.1-д “Иргэний эрхзүйн харилцаанд оролцогч хууль буюу гэрээнд заасан эрх, үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлнэ”, мөн 13.3-д “Иргэний эрхзүйн харилцаанд оролцогч эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ бусдад гэм хор учруулсан, зах зээлийн харилцааны чөлөөт байдлыг үндэслэлгүйгээр хязгаарласан, хууль ёсны давуу байдлаа хууль бусаар ашигласан үйл ажиллагаа явуулж болохгүй бөгөөд хэрэв

зөрчвөл хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ”, Эрүүгийн хуулийн 148.1-д “бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”, Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлд “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхэд гэрч, хохирогч зориуд худал мэдүүлэг өгсөн, шинжээч зориуд худал дүгнэлт гаргасан, орчуулагч зориуд худал орчуулсан, хэлмэрч зориуд худал хэлмэрчилсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэсэн хэм хэмжээгээр зохицуулж байна. Мөн Захиргааны хариуцлагын тухай хуулийн 36-р зүйл болон Эрүүгийн хуулийн 148-р зүйлийг үндэслэн зохицуулж болох юм. Эндээс харахад, хэрэглэгчийн зүй бус үйлдлийг томьёолж, тодорхойлох, үйлдвэрлэгчийн эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагын эрхзүйн зохицуулалт дутмаг байгааг боловсронгуй болгох шаардлагатай нь харагдаж байна.

Дүгнэлт

Зүй бус үйлдэл гаргагч хэрэглэгчдийн нэг хэсэг нь тогтворгүй зан төлөвтэй субъектүүд, бэл бэнчинтэй аж ахуйн нэгжээс мөнгө

завших зорилготой байдаг. Олон нийтэд хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль болон холбогдох бусад эрхзүйн актыг тайлбарлаж, таниулах сургалт зохион байгуулах нь чухлаар тавигдаж байна. Нөгөөтэйгүүр, боловсрол мэдлэгтэй, хуулийг судалсан, хуулийн тодорхой бус томьёолсон зохицуулалтыг өөртөө ашиглах чадвартай нэг хэсэг хэрэглэгч ч бас байна. Иймээс үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн (цаашид “аж ахуй эрхлэгч” гэх) эрх, үүрэг, хэрэглэгч, зүй бус хэрэглэгчийн эрх, үүргийг (ашиг хонжоо хайгч, залилагч) ялгаж, хамгаалах нь чухал юм.

Хэрэв хэрэглэгчийн эрх зөрчигдсөн тохиолдолд аж ахуй эрхлэгчдэд, шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, мөн мэргэжлийн хяналтын газарт хандаж, аль болох шүүхийн бус журмаар асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэдэг. Харин хэрэглэгчийн зүй бус үйлдлийн улмаас аж ахуй эрхлэгчид хохирол учирсан бол цагдаа, шүүхийн байгууллагад хандах хуулийн зохицуулалттай байдаг. Энэ нь цаг хугацаа болон зардал мөнгөний хувьд хохиролтойн дээр аж ахуй эрхлэгчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг жишээг дээр дурдсан.

Хэрэглэгчийн зүй бус үйлдэл нь аж ахуй эрхлэгчийг хууль дүрмээ чанд мөрдөх, нийгэм дэх эрх зүйн соёлыг дээшлүүлэх, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд үйлчилгээний соёлыг улам чанаржуулах зэрэг давуу талыг бий болгоно. Харин сул тал нь үүргээ зохих ёсоор биелүүлдэг аж ахуй эрхлэгч нарын нэр хүндэд гэм хор учруулах, улмаар санхүүгийн алдагдалд

⁴<http://www.juridicainternational.u/?id=12553>



орох, үйлчлүүлэгчээ алдахад хүргэх, “хэзээд хэрэглэгчийн зөв”, хэрэглэгч дураар авирлах боломжийг олгодог байна. Тиймээс зөвхөн хэрэглэгчийн эрхийг хамгаалахад анхаарах бус, мөн аж ахуйн эрхлэгч нарын эрхийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэглэгчийн дураар авирлахыг хязгаарлах явдал нь зайлшгүй шаардлагатайг жишээнүүд харуулж байна. Дээрх жишээ баримт, дүгнэлтэд үндэслэн дараах санал, зөвлөмж дэвшүүлж байна.

Санал, зөвлөмж

1. Хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх, ёсзүйгүй, зүй бус

үйлдэл, хэрэглээний соёлын тухай сургалт зохион байгуулах,

2. Хэрэглэгчийн зүй бус үйлдлийг онолын хийгээд хуульзүйн талаас нь тодорхойлох, тайлбарлах,

3. Захиргааны хариуцлагын тухай хуульд хэрэглэгчийн зүй бус үйлдлийг захиргааны зөрчилд тооцож нэмж тусгах, тайлбар гаргах.

4. Зүй бус үйлдлийн улмаас нийлүүлэгч, үйлдвэрлэгчид учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжлэх эрхийг тайлбарлах, ойлголт өгөх.

5. Хэрэглэгчийн зүй бус үйлдлийг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг болгон

хуульчлах. Үүнд гэм буруугийн хувьд шууд санаатай, шунахай сэдэлтэй, идэвхтэй үйлдлээр илрэх ба объект нь аж ахуй нэгж, байгууллагын бизнесийн хэвийн үйл ажиллагаа байхаар хуульчлах.

6. Хэрэглэгчийн зүй бус үйлдлийн илрэх хэлбэр, түүнд ногдуулах хариуцлагыг аж ахуй нэгж, байгууллагад танилцуулж, үйлчилгээний газарт хэрэглэгчид анхааруулах зорилготой анхааруулгыг ил, нүдэнд харагдахуйц байрлуулах.

7. Гадаадын орны туршлагыг судалж, өөрийн орны онцлогт тохируулан эрхзүйн орчинг бүрдүүлэх зэрэг болно.



ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ,
ТҮҮНИЙ ХЭЛБЭР*Г.Бямбадорж**ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, цагдаагийн
эрх зүйн тэнхимийн багш, магистр*

Бидний өвөг дээдс хүүхдийг хүмүүжүүлж ирсэн арвин туршлагатай. Хүүхдийг хүмүүжүүлэх арга ухааны тухай бичигдсэн ном, сурах бичгийг судлан үзэхэд тэднийг хүчирхийлж байсан нэгээхэн ч баримт байгаагүйг энд дурдах нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.1-д “Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно”¹ гэж иргэний баталгаатай эдлэх эрхийг заасан нь хүүхдийг эрхийг хангах чухал заалт болсон.

Түүнчлэн, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэргүүдийг хуульчилж, хүчирхийлэл үйлдэгч нартай тэмцэх арга замыг бий болгож, хүчирхийлэл үйлдэгчдэд

хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтоож өгсөн.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 3 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”. 2 дугаар зүйлд “Хүн бүр энэхүү тунхаглалд заасан бүхийл эрх, эрх чөлөөг арьсны өнгө, үндэс угсаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой”² гэж заасан.

1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенцид “Энэхүү Конвенцид оролцогч улсууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмуудын дагуу нийгмийн бүх гишүүдийн угаас заяасан нэр төр, тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь дэлхий дахинд эрх чөлөө, шударга ёс, энх тайвныг хангах үндэс болно” гэж үздэг.

Нэгдсэн Үндэстний Байгууллага нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалд болон

² Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-ын Ерөнхий ассамблейн 217/A III тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр батлаж, түүний бүх заалтыг мөрдөхийг гишүүн улсаадад уриалжээ.

хүний эрхийн тухай олон улсын пактуудад заасан бүхий л эрх, эрх чөлөөг хүн бүр арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний хийгээд нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн болон бусад байдлыг үл харгалзан, аливаа ялгаваргүйгээр эдлэх эрхтэй гэж заасан нь энэхүү конвенцид нэгдэн орсон улс орнуудын хүүхдийг эрхийг хангах чухал заалт болсон юм.

Улмаар “Хүүхдийн Хөдөлмөрийн Тэвчишгүй Хэлбэрийг Устгах тухай” Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенц, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг зэрэг конвенциудад нэгдэн орж, соёрхон баталснаас гадна үндэсний 300 гаруй хууль, Засгийн газрын бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдэд хүүхдийн эрхийн зөрчлүүдээс хамгаалах тухай заалтууд тусгагдсан гэжүздэг ч хүүхдийн эрхийг хамгаалах тухай Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Боловсролын тухайхуулиудад л хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэсэн шууд заалтуудыг тусгасанбайдаг.

¹ Монгол Улсын Үндсэн Хууль, Төрийн мэдээлэл, УБ 1992. №1



Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдэг нь: Хэн нэг этгээд өөрийн хүч, эрх мэдэл, бие махбодийн болон бусад давуу байдлаа ашиглан хүүхдийн халдашгүй дархан байх эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсвэл учруулахаар завдсан, түүнийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл эс үйлдэхгүйг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэнэ³.

Харин манай зарим судлаачид хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдгийг дараах байдлаар тодорхойлжээ: Хүүхдийн эсрэг дарамт хүчирхийлэл гэж хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах, давамгайл байдал тогтоох, шийтгэх зорилгоор хэн нэгэн этгээд хүч, эрх мэдэл, давуу талаа ашиглан хүүхдийн халдашгүй дархан байх эрх чөлөөг зөрчсөн, гэм хор учруулсан эсвэл учруулахаар завдсан энэ байдлыг мэдсээр байж хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл эс үйлдэхгүйг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэнэ хэмээн тодорхойлсон байна⁴.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь үйлдэл, эс үйлдэхгүйгээр үйлдэгддэг ба санаатай үйлдэл нь хүүхэд рүү шууд чиглэгдсэн байна. Харин эс үйлдэхгүйгээр үйлдэгдсэн тохиолдолд шууд бус байдлаар чиглэсэн байдаг.

Өнөөгийн байдлаар хүүхдийн өсөн торниж буй орчинд бусдад айдас, түгшүүр төрүүлэх, хүүхдүүдээ цохиж зодох, шийтгэх, цээртэй үгээр харааж зүхэх, загнаж зандах, тэдний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдэх зэргээр хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдсээр байна.

³ Хүүхдийг хамгаалах тогтолцоо гарын авлага, УБ 2007. 33 дахь тал

⁴ Хүүхдийг хамгаалах тогтолцоо гарын авлага, УБ 2007. 34 дэх тал

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүүхэд онцгой халамж, тусалцаа авах эрхтэй гэж тунхагласан байдаг ч гэр бүл, түүний гишүүдийн, ялангуяа хүүхдийн өсөж бойжих, аж төрөх орчин, нийгмийн үндсэн нэгж болохын хувьд нийгэмд хүлээх хариуцлагыг бүрэн хэмжээгээр үүрүүлэхэд шаардлагатай хамгаалалт, тусалцаа хүртэх ёстойг ойлгож, аз жаргал, хайр, ойлголцол бүхий гэр бүлийн орчинд өсгөж бойжуулах, хүүхдийн өв тэгш хөгжлийг хангажхүүхдийг нийгэмд бие даан аж төрөхөд бүрэн бэлтгэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан төгс үзэл санаа, ялангуяа энх тайван, нэр төр, эрх чөлөө, тэгш эрх болон эв санааны нэгдэл бүхий үзэлтэйгээр өсгөн хүмүүжүүлэх шаардлагатай байна.

Хэдийгээр хүүхдийн эрхийн талаар олон улсын конвенцууд гарсан боловч хүүхдийн эрхийг зөрчих явдал байсаар байна. Хүүхэд ямар нэгэн алдаа гаргах, сахилгагүйтэх, томчуудын үгэнд ороогүйгээсээ тэдний хөгжил, өөрийгөө үзэх үзэлд сөрөг үр дагавар авчрах бие махбодь болон сэтгэл санааны шийтгэлийг амсаж байна.

Хүүхэд ямар нэгэн алдаа гаргах, сахилгагүйтэх, томчуудын үгэнд орохгүй байх зэрэг асуудлыг зохицуулахад эцэг, эхчүүдийн 64% нь, багш нарын 60% нь зодох загнах хүсэл мөрөөдлийг нь үгүйсгэх, хязгаарлах, хайхрамжгүй байдлаар хандах зэргээр шийтгэж байна.

Хүчирхийлэлд өртөж байгаа хүүхдийн эрхийг хамгаалахын тулд нийгмийн суурь үйлчилгээнээс ялгаатай

өөр төрлийн бодлого, хөтөлбөр, үйлчилгээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүүхэд хамгаалал бол нийгмийн хамгаалал биш. Нийгмийн хамгаалал нь амьдарлын наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа хүн амын бүлэгт учирч буюу эрсдэлийг даван туулахад нь туслах зорилгоор үзүүлэх бэлэн мөнгөний болон бусад хэлбэрийн халамж үйлчилгээ тусламж юм. Хүүхэд хамгаалалтай холбоотой өөр нэг асуудал нь үндэстэн хоорондын зэвсэгт мөргөлдөөн, хүүхдүүд бүх төрлийн хүчирхийлэл, бэлгийн мөлжилгөд өртөх зэргээр золиос болон хохирсоор байгаа нь хүүхдийн эрхийг цаг алдалгүй хамгаалах маш чухал асуудал болсныг харуулж байна.

Ер нь хүнийг гэмт хэрэгтэн болж төлөвшүүлэхгүйн тулд бага балчираас нь эхлэн сайн хүмүүжүүлж, нийгэмд байр суурьтай төлөвшсөн бие хүн болоход эцэг эхийн үүрэг оролцоо их.

Харин хүүхдийг хүмүүжүүлэх арга ухааны тухайд бусад улс орнуудын түүхтэй харьцуулахад монголчууд хүүхдээ хайрлан хүндлэж өсгөн хүмүүжүүлдэг байсан талаар хүүхэд хүмүүжүүлэх арга ухааны талаар өгүүлсэн судар бичгүүдэд тэмдэглэн үлдээсэн байдаг. Тухайлбал, Эцэг эх нь хүүхэдтэйгээ маш эелдэг сайхан харьцаж миний хүү, миний охин хэмээн дуудаж, ахмад хүний үг сургаалийг нь сонсож хүндэтгэн дээдлэх үзлээр хүмүүжүүлж, хүнийг элдэвээр хараан зүхэх, доромжлох, зодох зэргийг цээрлэдэг байжээ.

Хүүхдийн хүмүүжлийн талаар Тогтох төр ван



“хүүхдийг хэт эрхлүүлэхгүй, хэт ширүүлэхгүй, зодож жанчихгүй, учрыг нь ятган сэнхрүүлж өрх гэрээс эхлээд улс нийтийн ажил үйлсэд зүтгүүлэн хүмүүжүүлэх нь зүйтэй” гээд хүүхдийг зодож занчих нь дуулгавартай болно гэсэн ташаа ойлголтыг буруушаан зарим хүмүүс сургах гэж “нялх хүүхдээ занчина хэдий эцэг эх нь үр хүүхдээ сургах нь ёс мөн боловч тэр өвдсөндөө уйлахаас өөр юу ч мэдэхгүй балчирыг санавал үнэхээр их өр өвдөх мэт” бас хүүхдийг гомдоовоос өөрийн биед гомдол ирэх юуны магад иймийн тулд жанчиж түүнийг бүү гомдоо гэж сургаж байжээ⁵.

Түүнчлэн, алдаа гаргасан хүүхдэд ухааруулан ойлгуулах, хүндлэж хайрлах, зааж сургах, байдлаар хүмүүжүүлж байжээ. Үүнд:

- Гэмийг нь өөрт нь ухааруулах
- Анх удаа мэдээгүй мэт өнгөрч дахин давтал сөхөж сануулах
- Хамгийн хүнд гэмтэнд оноох ял бол өршөөл гэдгийг эрхэмлэн уучилж өршөөх

Гэмээ ухаартал нь сургаальунш, бүхний зангилаа тайлагдтал хэлж сурга гэх мэт. уламжлалт хүмүүжлийн аргуудыг хэрэглэж байсан нь үр дүнтэй.⁶

Мөн сайхан үг хүнийг ажил амьдралын замаа зөв сонгож, өсөн дэвжихэд тус дэм болдог бол, бодлогогүй хэлсэн болчимгүй үг нөхрийн санаа сэтгэлд хар толбо үлдээдэг болохыг харгалзан монголчууд сайн үгийг эмтэй, муу үгийг сумтай зүйрлэдэг. Тухайлбал,

⁵ Д.Нямдаваа. Уншихгүй байж болохгүй. УБ., 2007. 98 дахь тал

⁶ Монгол ёс заншил их тайлбар толь. УБ., 2007. 134 дэх тал

“Үг хатуу боловч амьдралд тустай”

“Эм гашуун боловч аминд тустай”

“Инээсэн бүхэн нөхөр биш”

“Уурласан бүхэн дайсан биш”

“Эргүү хүн магтуулах дуртай” иймээс “магтлаа гэж бүү баяс, мууллаа гэж бүү гунь” гэж хүүхэддээ сурган тэдний дэргэд өөрсдийг нь магтдаггүй, хатуу гараар биш, хатуу үгээр сургадаг байжээ.

Хүүхдийн эсрэг дарамт, шахалт үзүүлэх, зодох занчих, айлгах зэрэг хэлбэрээр үйлдэгдэж буй хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь хүний өөрийн үнэлэмжийг бууруулж, улмаар хүчирхийлэлд өртөгч хүүхэд хүчирхийллийн шалтгааныг өөрөөсөө хайн, эцэст нь амьдралынх нь хэвийн үзэгдэл болтлоо дасан зохицсон байдаг нь сэтгэл эмзэглүүштэй. Тухайлбал, Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд цагдаагийн байгууллагад хандахаас ичих, хүчирхийлэл үйлдэгчээс айсны улмаас зохих байгууллагад мэдэгдэлгүй орхих, тэвчиж өнгөрөөх тохиолдол түгээмэл байгаа бөгөөд хүчирхийллийн эсрэг төвийн хийсэн судалгаанаас үзэхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийн таван хүн тутмын нэг нь цагдаагийн байгууллагад ханддаг нь хүчирхийллийг нуугдмал байдалд оруулсаар байна⁷.

Гэр бүлийн таагүй байдлын улмаас гэр бүл салалт, түүнээс улбаалан хүүхдийн өнчрөлт, хараа хяналтгүй хүүхдийн тоо олшрох зэрэг нийгэмд олон сөрөг үр дагавар бий болгож

байна.

Мөн халамжийн болон асрамжийн газарт хүмүүжиж буй 2000 орчим хүүхдийн 60.5% нь ядуу зүдүү байдлаас, 22% нь эцэг эхийн дарамтаас, 11.8% нь гэр орон дахь архидалт, ажилгүйдлээс болж гэрээсээ дайжсан, ял эдэлж байгаа хүүхдүүдийн 42% нь үе тэнгийхний дарамтаас, 22% нь гэр бүлийн хүчирхийллээс, 10% нь сургууль дээрх таагүй харилцаанаас үүдэн гэмт хэрэгт холбогдсоны гол шалтгаан нь буюу эцэг эхийн дарамт, гэр бүлийн таагүй уур амьсгалаас болсон нь судалгаагаар нотлогд жээ.

Нөгөө талаар цагдаагийн байгууллагад хүчирхийлэлд өртсөн хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх болон хүчирхийлэлд өртөгсөдийг хамгаалах дүрэм журам байхгүйтэй холбоотой байж болох юм. Ихэнхи тохиолдолд цагдаагийн байгууллага нь хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ “Энэ бол гэр бүлийн дотор байдаг л асуудал” гэдэг шалтгаанаар шалгахгүй орхих, үл тоомсорлох, энэ бол миний хийх ёстой ажил биш, хүүхдийн байцаагч нарын хийх ажил гэх мэтээр өөрөөсөө зайлуулах байдлаар ханддагтай холбон үзэж болох юм.

Ийм учраас хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой нөхцөл байдал илэрсэн тохиолдолд авах арга хэмжээг тодорхой болгох энэ чиглэлээр цагдаагийн алба хаагч нарыг мэргэшүүлэх, хүчирхийлэлтэй холбоотой хэргийг шалгаж шийдвэрлэх ур чадвар эзэмшүүлэх зэрэг асуудал цагдаагийн байгууллагын өмнө

⁷ Г.Бямбадорж. Архидан согтуурах явдалтай тэмцэх үйл ажиллагаа. УБ., 2011. 170 дахь тал.



тулгамдаж байна.

Бидний үзэж байгаагаар, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд албадлагын шинжтэй, эрх хязгаарлах, гэр бүл цуцлах, захиргааны шийтгэл оногдуулах зэрэг арга хэмжээ авахаас илүүтэйгээр хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг засаж, хүүхдийг багаас нь төлөвшүүлэх уламжлалт аргуудыг хэрэглэж ирээдүйд үйлдэгдэх хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж болох юм.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн үйлдэл, хор уршиг төсөөтэй шинжээр нь дараах дөрвөн төрөлд хуваан үзсэн байдаг. Үүнд:

- Бие махбодийн хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Сэтгэл санааны хүчирхийлэл
- Үл хайхрах

Бие махбодийн хүчирхийлэл гэдэг нь: Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах зорилгоор хэн нэгэн этгээд хүч хэрэглэн хүүхдийн биед ямар нэгэн хэмжээгээр халдах, эсвэл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Бие махбодийн хүчирхийллийн илрэх хэлбэр: Хүүхдийг алдаа гаргасан буруу зүйл хийсэн, үгэнд ороогүй, сайн хүн болгох гэсэн зэрэг шалтгаанаар алгалан, чимхэх, цохих зэрэг хөнгөнөөс хүнд хэлбэрийн тарчлаан зовоох шинжтэй өндөрөөс шидэх, түлхэх, түлэх, гадаа зогсоох, зүсэх зэргээр хүүхдийн бие

махбодид олон тооны шарх сорви гэмтэл бэртэл үүсгэх байдлаар илэрдэг.

Бие махбодийн хүчирхийлэл үйлдэх нь үхэлд хүргэдэггүй юмаа гэхэд эрхтэн системийн архаг хууч өвчтэй, тахир дутуу болох, зан төрөхийн өөрчлөлттэй болдог нь судалгаагаар тогтоогджээ. Багадаа хүчирхийлэлд өртөж байсан эрчүүдийн 75% нь өөрөө хүчирхийлэгч болдог гэдгийг эрдэмтэд тогтоосон байна.

Сэтгэл санааны хүчирхийлэл гэдэг нь: Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах зорилгоор хэн нэгэн этгээд өөрийн давуу байдлаа ашиглан үг хэл үйл хөдөлгөөнөөрөө сэтгэл санааны дарамтанд оруулсныг, эсвэл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Сэтгэл санааны хүчирхийллийн илрэх хэлбэр: Сэтгэл санааны дарамт нь хүүхдийг дорд үзэн тохуурхах, нэр хоч өгөх, байнга шүүмжлэх, доромжлохоос эхлэн хараах, найз нөхдөөс нь салгах, ганцаардуулах, гадуурхах, шоовдорлох, хянаж цагдах зэргээр нийгмээс тусгаарлах, айлган сүрдүүлэх, заналхийлэх, гүтгэх, өөрийн үзэл бодлоо тулгах зэрэг сэтгэл зүйн хувьд тайван амгалан байх нөхцлийг үгүй хийх байдлаар илэрдэг.

Сэтгэл санааны хүчирхийллийг илрүүлэхэд маш бэрхшээлтэй хэцүү байдаг. Энэ нь ихэвчлэн хүчирхийллийн бусад хэлбэрүүдтэй давхар үйлдэгддэг бөгөөд зарим тохиолдолд дангаараа илэрдэг. Манай ард түмэн хэлж сургахдаа “Биеийн шарх эдгэрдэг харин

сэтгэлийн шарх эдгэрдэггүй, урмыг нь хугалхаар ууцыг нь хугал” гэх мэтээр бие биедээ сэтгэл санааны дарамт үзүүлэхийг цээрлэж ирсэн баялаг уламжлалтай ард түмэн билээ.

Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь: Хүүхдийн халдашгүй дархан байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн болон садар самууны шинжтэй бусад үйлдэл рүү татсан, шаардсан, эсвэл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл эс үйлдэхүйг хэлнэ.

Бэлгийн хүчирхийллийн илрэх хэлбэр: Энэхүү хүчирхийлэл бол хүүхдийн эсрэг онцгой хүнд хэлбэрийн хүчирхийлэл юм. Бэлгийн хүчирхийллийг ихэвчлэн насанд хүрсэн хүмүүс үйлдэх нь олон боловч зарим тохиолдолд үе тэнгийнхэн нь үйлддэг байна. Тэд өөрийн хүч чадал давуу байдлаа ашиглаж, хүч түрэмгийлж хууран мэхлэх, айлган сүрдүүлэх байдлаар илэрдэг.

Мөн хүчирхийлэлд өртсөн хүн бүр хууль хяналтын байгууллагад хандах нь ховор байдаг бөгөөд бэлгийн хүчирхийлэлд өртсөн 20 тохиолдол бүрийн 1 нь цагдаагийн байгууллагад ханддаг гэж зарим судлаачид үзсэн байдаг⁸.

Түүнчлэн хүчиндэх гэмт хэргийн 26,6% нь ураг төрлийн хүн нь хүчиндсэн нь судалгаагаар тогтоогдсон бөгөөд хохирогч нарын 60% нь 5-8 насны охид

⁸ Хүүхдийн эсрэг хүчирхийллийн сэдэвт сургалтын хөтөлбөр. УБ., 2005. 81 дэх тал



байна⁹.

Бэлгийн хүчирхийлэл дараах хоёр хэлбэрээр үйлдэгддэг байна. Үүнд:

- Хүрэлцэх
- Үл хүрэлцэх гэсэн хэлбэрээр үйлдэгддэг байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгч хүүхдийг дуугүй байлгадаг аргуудыг авч үзвэл: Хүчирхийлэгчид нь маш олон заль мэх, хууран мэхлэлт, арга барилыг ашиглан хүүхдийг хүчирхийлдэг ба тэдэнд “тэр надад зүгээр тоглоом гэж хэлсэн”, “энэ тухай хэлэх юм бол хэн нэг нь үхнэ”, “үүнийг хүүхэд бүр хийдэг” гэх зэргээр ятгаж ойлгуулсан байдаг.

Хүчирхийлэгчид нь хохирогчийг дуугүй байлгахын тулд түүнд хамаг бурууг тохож аргаа өөрчилдөг, хэрэв чи энэ тухай хэн нэгэнд ярьвал хэн ч чамд итгэхгүй, би бол нөлөөтэй том хүн, хүмүүс хүүхдэд биш надад л итгэнэ гэж хохирогчид байнга хэлж дарамталдаг. Мөн энэ тухай ээж чинь мэдвэл бид хоёр хоёулаа гэрээсээ хөгөөдөнө шүү ээж чинь чамайг нэг нүдээрээ ч үзэхгүй гэж дарамталдаг.

Энэ нь хүүхдэд маш том аюул юм. Хүүхэд өсч томрохын хэрээр хүчирхийлэгчийн арга барил нь нарийсч бодит байдлыг эрс гуйвуулдаг. Гэхдээ өөрт нь тохиолдсон зүйл жирийн бус явдал гэдгийг бага багаар ойлгож эхэлдэг.

Хүүхдүүд бэлгийн хүчирхийллээс гарч чаддагүй маш олон шалтгаан байдаг. Тэд маш ихээр төөрөгдөлд орсон байхын зэрэгцээ өөрийнхөө төлөө тэмцэх, бусдаас тусламж

гуйх, хэнд хандах гээд маш олон асуудалтай тулгарч, зарим тохиолдолд хүчирхийлэгчийг өөрийг нь хайрлаж байна гэж андуурах, ялангуяа ураг төрлийн хүчирхийлэлд өртсөн бол тэднийг зохих байгууллагад мэдэгдэж чаддаггүй байна.

Үл хайхрах хэлбэр гэж: Хэн нэгэн этгээд хүүхдийн бие махбодь, сэтгэл санаа, эрүүл мэнд, хөгжил боловсрол, хайр халамж, аюулгүй байдлыг хангах зэрэг суурь хэрэгцээг гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан болон учруулахаар завдсан, эсвэл энэхүү нөхцөл байдлыг нь мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй байхыг ойлгоно. Энэ нь сэтгэл санааны бие махбодийн, эрүүл мэндийн боловсролын хувьд үл хайхрах, аюулгүй байдлыг нь хангахгүй байх гэх зэргээр санаатай болон хайхрамжгүй байдлаар илэрнэ.

Үл хайхралтын хэлбэр нь: Хүүхдийг хоол хүнс орон байр, хайр халамж, гутал хувцасаар санаатай гачигдуулах, хэрээс хэтэрсэн үүрэг хүлээлгэж хүнд хүчир ажил хийлгэх, харж хандах хүнгүй ганцааранг нь үлдээх, эрүүл мэндэд нь санаа тавьж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхгүй байх зэрэг нь үл хайхрах хэлбэрийн илрэл юм.

Харин ядуурал, амьдралын гачигдлаас үүсэж байгаа үл хайхралтыг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж үзэхгүй. Энэ нь санаатай бус байдаг бөгөөд мөнгө санахүүгийн хувьд бололцоотой амьдралтай гэр бүлийн хувьд санаатайгаар хүүхдийг үл хайхрах нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл

болно.

Үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэл нь хүүхдийг бусдаар хайрлуулах, өөрийгөө бусдад хүндлүүлэх үнэ цэнэтэй эрхэм чанарыг үгүйсгэсэн үйлдэл юм.

Эцэст нь тэмдэглэн хэлэхэд ерөнхий боловсролын сургуулийн “Хүүхдийн эрхийг хамгаалах” дэд бүлгүүдийг байгуулж хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлийн үйл ажиллагаанд оролцуулж, тэдний оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь хамтарсан багийн хэлбэрээр зохион байгуулж хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл хүргэх, мэдээлэл солилцох, зохих байгууллагад мэдэгдэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн сургалт, сурталчилгааны ажилд хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн дэмжлэг тусалцаа авах зэргээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.


Дээрх бүхнээс үндэслэн дараах санал дэвшүүлж байна.

- Хүүхэд хүн худалдаалах болон хүний эд эрхтэнг хууль бусаар авах гэмт хэргийн хохирогч болох, бүх төрлийн хүчирхийлэл, хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгөд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах,
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах байрны тоог нэмэгдүүлэх, мөн хүчирхийлэл үйлдэгч нарыг шийтгэх, албадагын шинжтэй арга хэмжээ авахаас аль болох татгалзаж сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл заслын эмнэлгээ хийх

⁹ Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах төвөөс шүүх эмнэлгийн бүртгэлд хийсэн судалгаа. УБ 2007



- | | | |
|---|---|---|
| <p>➤ Хууль сахиулах байгууллагуудын ажилтан албан хаагч нарыг энэ чиглэлд ажиллах ажлын арга барил туршлагатай болгох</p> <p>➤ Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх</p> | <p>үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, алдаа дутагдлыг нь арилгуулах</p> <p>➤ Хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа бүх төрлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар хүүхдийн эрхийг хамгаалах</p> | <p>чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд нэгдсэн нэг цогц бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх зэрэг болно.</p> |
|---|---|---|



МОНГОЛ УЛС ДАХЬ ТАНХАЙРАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ



Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн тоо бүртгэлийн болон Улсын Дээд Шүүхийн статистик мэдээнээс үзвэл танхайрах гэмт хэрэг жил бүр өсчээ.

Танхайрах гэмт хэргийн тоон үзүүлэлтийг 2003-2012 оны байдлаар улсын хэмжээнд нэгтгэн судалгаа хийхэд насанд хүрээгүй хүүхэд архидаан согтуурсан үедээ гэмт хэрэгт холбогдох байдал нэмэгдэх хандлагатай байна.

2003-2012 онд улсын хэмжээнд танхайрах гэмт хэрэг нийт 16811 бүртгэгджээ. Энэ нь жилд дунджаар 1681, сард 140, өдөрт 5 гэмт хэрэг үйлдэгдэж байна гэсэн статистик үзүүлэлт болно.




Тухайн онд бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт танхайрах гэмт хэргийн эзлэх хувь:

Нутаг дэвсгэрийн байдлаар нь авч үзвэл: Сүүлийн 10 жилийн дунджаар 1678 танхайрах гэмт хэрэг бүртгэгдсэний 43.4 хувь нь орон нутагт, 56.6 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.



Аймгуудад¹:




Хэнтий, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт уг төрлийн

¹ ЦЕГ-ын МСТ, МУ-д 2003-2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт, УБ, 2013 он

гэмт хэргийн тоон үзүүлэлт өндөр байна.

Дархан-Уул, Сэлэнгэ аймгаар дамжин өнгөрөх иргэдийн тоо өсөн нэмэгдэж байгаа, амралт, зугаалга, аяллын чиглэл дайран өнгөрдөг газар зүйн онцлог, архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг дэлгүүр, бар, рестораны тоогоор улсын хэмжээнд харьцангуй өндөр зэрэг шалтгаанаар эдгээр аймагт танхайрах гэмт хэрэг буурахгүй байх нөхцлийг бүрдүүлэх магадлалтай юм.

Нийслэлд:




Бусад дүүрэгтэй харьцуулахад Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт танхайрах гэмт хэрэг илүү бүртгэгдсэн үзүүлэлттэй байна.

Орон нутгаас нийслэлд шилжин ирэгсдийн дийлэнх нь тус 2 дүүрэгт суурьшдаг, газар нутаг, хүн амын тоогоор



нийслэлдээ тэргүүлдэг нь гэмт хэрэг, зөрчил, ялангуяа танхайрах төрлийн гэмт хэрэг ихээр гарах үндэс болж байна гэж үзэх үндэслэл болж байна.

Нийслэлийн статистикийн газраас 2012 оны байдлаар гаргасан “Нийслэлийн аж ахуйн нэгж, байгууллага”-ын судалгаа мэдээнээс үзэхэд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг зоогийн газар, зочид буудлын тоогоор бусад дүүргээс их байна.



Нийт бүртгэгдсэн танхайрах гэмт хэргийн дийлэнх хувийг хүндэвтэр, хүнд ангиллын хэрэг эзэлж байна.




Танхайрах гэмт хэргийг ихэвчлэн архидаан согтуурсан үедээ, бүлэглэн үйлдсэнээс бусад хүнд болон хүндэвтэр гэмтэл учруулж байна.



Танхайрах гэмт хэрэг үйлдэгдсэн газрын байдлаас үзвэл иргэд бар, ресторан зэрэг үйлчилгээний газарт эсхүл


үйлчлүүлсний дараа гудамж талбайд, мөн оршин суугаа газартаа архидаан согтуурч тус гэмт хэргийг үйлдэж байна.

Тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн цагийг доорх графикаар үзүүлэв.



Иргэд ажлын цаг дууссанаас хойш үйлчилгээний байгууллага бар, ресторанд үйлчлүүлж, эсвэл оршин суугаа газартаа архидаан согтуурч танхайрах гэмт хэргийг үйлдэж байгаа нь тоон судалгаанаас харагдана.

Танхайрах төрлийн гэмт хэргийг үйлдэж буй иргэдийн онцлог байдлыг хэд хэдэн үзүүлэлтээр авч үзвэл:



18-35 насныхан буюу залуучууд архи, согтууруулах төрлийн ундаа хэрэглэсэн үедээ энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж байна.


Нийт холбогдогчдын 2.1 хувийг эмэгтэйчүүд эзэлжээ.



Танхайрах гэмт хэрэг үйлдэгчдийн боловсролын байдлыг үзвэл бүрэн болон бүрэн бус дунд боловсролтой

иргэд 21130 буюу 66.2 хувийг эзэлж байх бөгөөд нийгмийн байдлаар нь авч үзвэл ажилгүй, ажилчин, малчин иргэд ихэвчлэн үйлдэж байгаа нь дараах графикаас харагдана.


Бүх шатны боловсролын байгууллагад сурч буй нийт суралцагчдын 51,6 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг² бөгөөд энэ нь боловсролгүй, ажилгүй эрэгтэйчүүдийн тоо өсөх үндэс болж байна.



Танхайрах гэмт хэрэгт өртөж буй хохирогч иргэдийн онцлог байдлыг авч үзвэл:



Энэ төрлийн гэмт хэрэгт 18-35 насны хүмүүс илүүтэй өртөж байгаа нь тоон судалгаанаас харагдаж байна. Нийт хохирогч иргэдийн 22.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.



Хохирогчийн нийгмийн байдлыг үзвэл ажилгүй иргэд, оюутан сурагчдын эзлэх хувь өндөр байна.

² ҮСХ, Статистикийн бюллетень, 2012.12 сар



Танхайрах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудалд: Иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлж нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхэд цаашид дараах арга хэмжээг авах саналтай байна. Үүнд:

1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд Архидан согтуурахтай тэмцэх хуулийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй

болгох талаарх саналыг зохих байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх,

2. Цагдаагийн албаны тухай хуульд баталгаажуулагдсан Мэдээлэл нэгтгэн боловсруулах үүрэг бүхий төвийг олон улсын цагдаагийн байгууллагын жишиг туршлагын дагуу судлан байгуулах, түүний хууль эрх зүйн орчинг бүрдүүлэн үе шаттайгаар нэвтрүүлэх,

3. Иргэдийн амар тайван амьдралын баталгааг бүрдүүлэх зорилгоор олон улсын жишиг туршлага, тухайлбал, гэмт хэрэг, зөрчлийн цахим зураглалыг нэвтрүүлэн түүнтэй уялдуулан хууль сахиулах үйл ажиллагааг

зохион байгуулах,

4. Шинээр боловсруулагдаж байгаа Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд одоогийн Эрүүгийн хуульд заасан танхайрах гэмт хэргийг “нийтийн хэв журам зөрчих” гэмт хэрэг болгон өөрчилж байгаатай холбогдуулан энэхүү гэмт хэргийн шинж, түүнээс урьдчилан сэргийлэх, хууль сахиулах үйл ажиллагааны онцлогыг тодорхойлж сургалт, сурталчилгааг явуулан алба хаагчдын сэтгэлгээ, хандлагыг өөрчлөн төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг санлыг дэвшүүлж байна.



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ**ҮЙЛДВЭРЛЭЛ, ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ
АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ БҮХИЙ ЭРСДЭЛ***Л.Бат-Очир**ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх
зүй, криминологийн тэнхимийн ахлах багш,
цагдаагийн ахлах дэслэгч, докторант*

Үндэслэл бүхий эрсдэл нь шинжлэх ухаан техник технологийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах чухал хэрэгсэл юм.

Хүн төрөлхтөний түүхэнд үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаа, шинжлэх ухаан техник, технологийн салбарт шинэ нээлт, оновчтой санал, шинэ бүтээл гаргах зорилгоор аз туршсан, эрсдэл ихтэй явдлууд олон байжээ.

Олон улсын болон сансарын орон зай, цөмийн эрчим хүч ашиглах, био анагаахын туршилтууд, түүнээс гарах үр дагаврыг зохицуулах эрх зүйн орчинболовсронгуй бус байгаа өнөө үед онолын судалгааг шинэ түвшинд явуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

2002 онд Монгол Улсын Эрүүгийн хуульд гэмт хэргийн

нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг анх удаа бие даасан бүлэг болгон хуульчилсан нь цаг үеэ олсон дэвшилттэй алхам болсон боловч зарим төрөл болох¹ үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдлийн зохицуулалт нь онолын түвшинд судлагдаагүй, нэг мөр ойлголтонд хүрээгүй, практик байхгүй учир дэлхий нийтийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжилтэй уялдуулах, цаашид гүнзгийрүүлэн судалж боловсронгуй болгох, үндэслэл бүхий эрсдлийн онолын болон практик асуудлыг шийдвэрлэхийн тулд эрүүгийн эрх зүйд шинэ үзэл баримтлал хандлага бий болгох шаардлагатай байна. Иймээс эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны өмнө тулгарч буй зорилт нь үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдлийн мөн чанар, агуулга, эрүүгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, үр дагаврын онолын асуудлыг боловсруулахад оршино. Практикт үндэслэл бүхий эрсдлийн нөхцөлд хийгдэж буй

бодит байдлууд багагүй байгааг үгүйсгэх аргагүй ба гагцхүү түүнийг онол, практикийн түвшинд ойлгож хэрэглэх явдал чухал юм.

Эрсдэл гэдэг нь эртний грекийн *periculum* буюу туршилт, оролдлого, туршлага мөн аюул, эрсдэл гэсэн утгатай үг юм². Дэлхийн үүсэл, хөгжлийн тухай шашны сургааль ноёрхож байх түүхэн цаг үед бурхан хүний зан үйл, түүний үр дагаврыг урьдчилан зааж хувь заяаг нь шийдвэрлэдэг гэж үздэг байсан учраас эрсдлийн тухай асуудлыг судалдаггүй байжээ.

XVI-XVII зууны үеэс шинжлэх ухаан онолын түвшинд хөгжиж эхэлснээр “Эрсдэл” гэдэг нэр томъёо анх үүссэн гэж үздэг ба судлаачид Франц хэлний “*resque*” буюу “аюулд өртөх” Герман хэлний *risco* буюу заналхийлж буй аюул, Испани хэлний “*risco*”, түүнээс үүсэл гаралтай *arriesgar* буюу хаданд авирах, орос хэлний “*риск*” буюу эрсдэл гэсэн утгатай үг гэж үздэг.³

ОХУ-д эрүүгийн эрх зүй дэх үндэслэл бүхий эрсдэл гэсэн ойлголт XX зууны

² И.Х.Дворецкиг. Латинско-русский словарь. ок.50.000 слов.310 стр.

³ Ю.Барон. Система римского гражданского права. СПб.1910.Кн. 672 стр

¹ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 43 дугаар зүйл. Төрийн мэдээлэл. 2002.№5



50-д оны үед бий болсон бол Монгол Улсын хувьд 1973 онд доктор (Ph.D), профессор Г.Совд “Үйлдвэрлэлийн явцад учрах хохирлоос болгоомжлон шинжлэх ухаан, техникийн шинэ ололтыг турших ажлыг эхлүүлэх шаардлагатай”⁴ гэж бичиж байсан бол БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1976 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар “Эрдэм шинжилгээний болон туршилт, зохион бүтээх, ажлын төлөвлөлт, зохицуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 412 дугаар тогтоол баталжээ. Уг тогтоолд шинэ техник, технологи, бүтээгдэхүүн материалыг бий болгож үйлдвэрлэлд нэвтрүүлэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын туршилт, зохион бүтээх ажлыг төлөвлөх, хөдөлмөр зохион байгуулалтын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, хөрөнгө хүч цаг хугацаа хэмнэх, урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ⁵ зэргийг тусгаснаас үзэхэд аливаа үйлдвэрлэл, шинжилгээ судалгааны ажил нь шинжлэх ухааны үндэслэлтэй нарийн төлөвлөгдсөн, үйлдвэрлэлд нэвтрэхүйц үр ашигтай байх шаардлагыг тогтоосноос гадна эрдэм шинжилгээ, судалгааны ажил туршилтын явцад байгаль орчинд хохирол учруулахгүй байх, аливаа эрсдэл гаргахаас урьдчилан сэргийлэх талаар анхаарч ажиллахыг даалгаж байжээ.

Эрүүгийн эрх зүйд хууль ёсны үйл ажиллагааны явцад хохирол учруулах явдлыг эрүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж

⁴ С.Жанцан, Дурдсан бүтээл. УБ., 2009. 736 дахь тал

⁵ Хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл. УБ., 1976. 323 дахь тал

байсан уламжлал бий. Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаанд хохирол учруулсныг хууль бус үйлдэл гэж үзэх ба зарим тохиолдолд нийгмийн тодорхой харилцаанд хохирол учруулах боломжтойг урдаас тооцоолон төрийн зүгээс иргэдэд ийм эрхийг олгодог гэж ойлгож болно. Ийм нөхцөл байдлын тухай ойлголт хөгжихийн хэрээр гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг бие даасан институцийн хүрээнд судлах болсон. Харамсалтай нь энэ институцийг бүрэлдүүлэн тогтоох явдал удааширч аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын нөхцлийг нийгмийн аюулыг үгүйсгэн гэмт хэрэгт тооцдоггүй байв. Энэ талаар Академич С.Нарангэрэл “Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн хуучин тогтолцооны үед аж ахуйн үйл ажиллагаагаа үр өгөөжтэй болгож өөд татахын тулд бүх талын тооцоо судалгаа хийсний үндсэн дээр зохих мөнгө хөрөнгө зарцуулсан боловч тэр нь бүтэлгүй болж, алдагдалд орох тохиолдол цөөнгүй гарч байв. Ийм нөхцөлд тийм аж ахуйн удирдагчдыг албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, хэтрүүлсэн, албан үүрэгт ажилдаа цалгар назгай хандсан гэмт хэргээр эрүүгийн хариуцлагад татаж, ял шийтгэж байсан нь эцсийн дүндээ аж ахуйн удирдагчдыг зоримог бус, идэвхгүй, санаачлагагүй болгож улс орны эдийн засгийн хөгжлийг зогсонги байдалд оруулахад нөлөөлсөн хүчин зүйлийн нэг болсон”⁶, доктор (Sc.D), профессор С.Жанцан 2002 оныг хүртэл манай Эрүүгийн хуульд үйлдвэрлэл,

⁶ С.Нарангэрэл. Монгол Улсын эрүүгийн эрх зүй ерөнхий анги. УБ., 1999. 200 дахь тал

шинжилгээ судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдлийн тухай хэм хэмжээ хуульчлагдаагүй явж ирсэн нь үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаа, шинжлэх ухаан технологийн салбарт оновчтой санал, шинэ бүтээл гаргах, үр дүнг нь хүртэх замаар дэвшилттэй, нийгмийн хөгжилд ач холбогдолтой олон чухал шийдвэрийг хэрэгжүүлэхэд чөдөр тушаа болж, мэргэжлийн хүмүүсийн бүтээлч санаачлагыг боогдуулахад хүргэсэн сөрөг хүчин зүйл, эрх зүйн нэг ёсны хийдэл байлаа”⁷ гэж тус тус дүгнэжээ.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үндсэн зорилт нь уг тогтолцоог боловсронгуй болгох, хууль ёсны нөхцлүүдийг тодорхойлох, эдгээр нөхцөл байдлын практик хэрэглээ, зүйлчлэлийг, хувь хүний хууль ёсны зан үйл гэдэг үүднээс судлах шаардлагын үүднээс эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн зүй тогтолын дагуу шинэчлэн найруулсан 2002 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, гэмт хэрэгтнийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах, үйлдвэрлэл шинжилгээ судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл, тушаал захирамж биелүүлэх зэрэг нөхцөл байдлуудыг анх удаа гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын тогтолцоог бий болгож⁸ болгон бие даасан байдлаар хуульчилсан нь дээрх нөхцөл байдлуудыг онол, практикийн түвшинд судлах үндэс болсон. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 43.1-т “Нийгэмд

⁷ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. УБ. 2009. 737 дахь тал

⁸ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэг



ашигтай зорилгод хүрэхээр хийсэн үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэлийн⁹ үр дүнд энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй”, 43.1-т “Эрсдэл бүхий үйлдэл, эс үйлдэхүй хийхгүйгээр тухайн зорилгод хүрч чадахгүй байсан бөгөөд эрсдэл хийсэн этгээд энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулахгүйн тулд хангалттай арга хэмжээ авсан бол үндэслэл бүхий эрсдэлд тооцно” гэж тус тус заасан.

Шүүхийн практикт үндэслэл бүхий эрсдэлд хамаарах нөхцөл байдлуудыг мэргэжлийн үүргээ биелүүлэх, эсвэл болгоомжгүй үйлдэлд хамааруулан үзэх хандлага түгээмэл байдаг.

Үндэслэл бүхий эрсдлийн талаар судалсан анхны судлаач нь М.С.Гринберг¹⁰ энэ талаар нэг сэдэвт бүтээл туурвиж хэвлүүлжээ. Орчин үед “эрсдэл”-ийн тухай ойлголтыг эрдэмтэн, судлаачдын гаргасан тайлбар толиос харж болно. Тухайлбал, С.И.Ожегов энэ нэр томъёог 1-рт гарч болзошгүй аюул, 2-рт азтайгаар дуусна гэж найдаж аз сорих үйлдэл¹¹ гэж тайлбарлажээ. Орос хэлний 4 боть толь бичигт энэ ойлголтыг мөн дараах байдлаар тодорхойлжээ. Энэ нь “1-рт ямар нэгэн зүйл гарч болох аюул, 2-рт азтайгаар дуусна гэж найдан аз сорьсон, эр зориг, аймшиггүй байдлыг шаардсан үйлдэл” гэж

⁹ Я.Цэвэл. “Монгол хэлний товч тайлбар толь”-д “эрсдэх” гэдэг үгийг “хэлмэгдэх”, “нэрвэгдэх” хилс хэрэгт эрсдэх, “галын аюулд эрсдэх” гэж тайлбарласан. Дурдсан зохиол. 884 дэх тал

¹⁰ Гринберг М. С. Момент оправданного риска в производственном процессе и его уголовно-правовое значение // Сов. гос-во и право. - 1954. № 1

¹¹ С.И.Ожегов. Словарь русского языка. М. 1970. 672-стр

тайлбарлажээ.

Ю.В.Баулины тэмдэглэснээр эрсдэл нь тухайн этгээд өөрийн субъектив эрхээ хэрэгжүүлэх явдал юм. Нэг талаас тухайн нөхцөлд эрсдэл хийх эрхээ хэрэгжүүлэх эсэх нь зөвхөн субъектын хүсэл зоригоос хамаарна. Нөгөө талаас субъект хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу эрхээ хэрэгжүүлснээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө. Гэхдээ эрсдэлтэй үйлдэл хийх эрх нь эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг, сонирхолд ашигтай үйлдлийг л сонгох эрх байх ба илт хохирол учруулахуйц байж болохгүй”.¹²

Доктор (Sc.D), профессор Г.Совд “Энэ нь гадаад байдлаараа ихээхэн хохирол учруулсан гэмт хэрэг мэт боловч агуулгаараа нийгмийн хөгжилд ашигтай нөлөөлөх хүчин зүйлүүдийг эрж хайх, зүй ёсны шаардлагаар хийсэн байдаг учраас нийгэмд аюултай шинжгүй байдаг”¹³, Академич С.Нарангэрэл “Онолын хувьд үндэслэл бүхий эрсдэл бол нийгэмд ашигтай зорилгод хүрэхийн тулд үндэслэлтэй эрсдэлд хүрч Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт гэм хор учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй байх явдал мөн”¹⁴, доктор (Ph.D), профессор Ж.Авхиа, судлаач Б.Ганболд “Эрсдэл хийхгүйгээр улс орны хөгжил явагдах, шинэ зүйл, санаачлан гаргах, олот амжилт бий болгох бололцоо улам бүр хаагдах болно, иймд хориглох бус урамшуулах хэм хэмжээ үйлчлэх нь илүү оновчтой

¹² Баулин Ю. В. Обстоятельства, исключющие преступность деяния. Харьков, 1991

¹³ Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002. 58 дахь тал

¹⁴ С.Нарангэрэл. Дурдсан зохиол. УБ., 1999. 199 дэх тал

юм”¹⁵, доктор (Sc.D), профессор Ж.Болдбаатар, доктор (Ph.D) З.Төрмандах нар “Шинжлэх ухаан, техникийн эрчимтэй хөгжлийн өнөөгийн нөхцөлд шинэ технологи, үйлдвэрлэлийн ажиллагаа, эрдэм шинжилгээний туршилтын үед материаллаг болон бусад хор уршиг учрах зүй ёсны эрсдэл оршдог. Үндэслэл бүхий эрсдлийн гол мөн чанар нь аль болох бага эрсдэлтэй ажиллагаагаар их үр дүнд хүрэх явдал юм”¹⁶, судлаач Б.Намсрай “...үндэслэл бүхий эрсдэл нь нийгэмд ашигтай зүйлсийг бий болгохын тулд үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлыг хууль ёсоор хэрэгжүүлэх явцад нийгмийн тодорхой төрлийн ашиг сонирхолд гэм хор учруулсан үйлдэл, эс үйлдэхүй бусад нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал юм”¹⁷ гэж тус тус оновчтой тодорхойлжээ. Гэхдээ дээрх судлаачид үндэслэл бүхий эрсдлийг гаргах субъектын талаар дурдаагүй байна.

А.Шурдумова “Үндэслэлтэй эрсдэл гэж нийгэмд ашигтустай зорилгод хүрэх оролдлого хийх үедээ энэ зорилгод өөр аргаар хүрч болохгүй эсвэл эрсдэл гарсан этгээд хохирол учруулахаас урьдчилан сэрэмжлэх хангалттай арга хэмжээ авсан нөхцөлд хуулиар хамгаалсан ашиг сонирхолд хохирол учруулахыг хэлнэ”¹⁸, М.С.Гринберг “Үйлдлийн зөвтгөгдсөн эрсдэл гэж ердийн, эрсдэлгүй арга хэрэгслээр хүрч болохгүй нийгэмд ашиг тустай

¹⁵ Б.Ганболд. Эрүүгийн эрх зүйд нэвтэрхүй. УБ., 2012. 561, 562-р тал

¹⁶ Ж.Болдбаатар, З.Төрмандах. Эрүүгийн эрх зүй. Ерөнхий ба тусгай анги. УБ., 2008. 63-64 дэх тал

¹⁷ Б.Намсрай. Дурдсан бүтээл. УБ., 2003. 73 дахь тал

¹⁸ Шурдумов А. Обоснованный риск // Уголовное право. М. 2002. №3. 1970.



үр дүнд хүрэхийн тулд хууль ёсны аюул бий болохыг хэлнэ”¹⁹ гэж тус тус тодорхойлжээ.

Харин А.А.Пионтковский “Хэвийн үйлдвэрлэл-аж ахуйн эрсдэл гэж өөрийн мэргэжлийн үүргээ биелүүлэх явцад тодорхой хэмжээний хохирол учруулж болох боловч түүнээс урьдчилан сэрэмжлэх арга хэмжээг авч техникийн хөгжлийн өнөөгийн үе шатанд өөр арга хэрэгсэл ашиглан хүрч болохгүй ач холбогдол бүхий үйлдвэрлэлийн үр дүнд хүрэхийг эрмэлзсэн субъектын хийсэн үйлдлийг хэлнэ”²⁰ гэж тодорхойлжээ.

М.П.Карпушин эрсдлийг зохист үйлдлээс гарч болох таагүй үр дүн, гарах аюул гэж тодорхойлжээ. Н.Ш.Козаевын үзж буйгаар, үндэслэлтэй эрсдэл гэдэг нь “субъект Эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулах магадлалыг харгалзан зан үйлийн хувилбарыг сонгох боломжтойг ухамсарлан нийгэмд ашиг тустай зорилгод хүрэхийн тулд тодорхой бус нөхцөлд хийж буй үйлдлээр илэрдэг, эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнд тулгуурласан иргэдийн хууль ёсны зан үйлийн биеэ даасан төрөл юм”²¹. В.Мельникова “Мэргэжлийн үндэслэлтэй эрсдэл гэж нийгэмд ашигтай үр дүнд хүрэхийн тулд тухайн этгээд мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байхдаа төрийн, нийгмийн болон хувийн ашиг сонирхолд хохирол учруулах боломж”²² гэж

тодорхойлсноос үзэхэд, эрсдэл гаргагч этгээд нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байх үед л эрсдлийн нөхцөл үүснэ гэж үзэж болохоор байна.

А.Л.Савенок “Үйлдвэрлэлийн эрсдэл гэж хуулиар хамгаалсан ашиг сонирхлыг аюулд өртүүлэх замаар нийгэмд ашиг тустай зорилгод хүрэх эсвэл хорт үр дагавраас урьдчилан сэргийлэх гэсэн хүсэл тэмүүлэл”²³ гэж тодорхойлсон. Үйлдвэрлэл, шинжилгээ судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдлийн нэр томъёог хэл зүйн болон эрх толь бичгээс харахад дараах утгыг илэрхийлж байна. Үүнд:

- Үндэслэл-үндэс бүхий, иш баттай²⁴
- Шинжилгээ²⁵-аливаа юмны бүтцийг тодорхойлох
- Үйлдвэрлэл²⁶-материаллаг баялагийг бий болгох нийгмийн үйл явц
- Судалгаа²⁷-аливаа юмны зүй тогтолын учир шалтгааныг олж мэдэх ажиллагаа,

Судалгаа, шинжилгээ²⁸-хоршоо үг-судлан шинжлэх ажил, шинжлэх ухааны үндэстэй явуулах, аливаа юмны бүтэц байдлыг тодорхойлох гэсэн утгатай. Эрүүгийн эрх зүйн чухал зорилт нь юуны түрүүнд эрүүгийн эрх зүй дэх үндэслэл бүхий эрсдлийн ойлголтыг оновчтой тодорхойлох явдал юм

Үндэслэл бүхий эрсдэл (substantiated risk, обоснованный

риск) гэдэг нь явцуу утгаараа эрүүгийн эрх зүй дэх үйлдвэрлэл, шинжилгээ судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдлийн агуулга нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан тодорхой нийгмийн харилцаанд хохирол учруулах явдал бол өргөн утгаараа эрсдэл нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаанд хохирол учруулж болох бодит нөхцлийг бий болгосон субъектын өөрийн хүсэл зоригийн үндсэн дээр ухамсарлагдсан нийгэмд ашигтай зорилго бүхий үйлдэл, эс үйлдэхүй юм.

Гэвч хэрэг явдлын нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын онолын үндэс, бүрэн судлагдаагүй, практик хэрэглээний түвшинд нэгдсэн ойлголт байдаггүй учраас эрүүгийн эрх зүйн төдийгүй ЭБШЭЗ хувьд хүндрэл бэрхшээл гарахыг үгүйсгэх аргагүй. Эдгээр бэрхшээл нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны өмнө хэрэг явдлын нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын онолын суурь ойлголт, үзэл баримтлалыг дэвшүүлэн гаргах зүй ёсны шаардлага тулгарч байна. Одоогийн Эрүүгийн хуульд заасан хэрэг явдлын нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудад дүн шинжилгээ хийж үзэхэд, тэдгээрийн агуулга мөн чанар, хууль тогтоогчийн хүсэл зоригыг бүрэн илэрхийлэх хэмжээнд хуульчлаагүй байна. Энэ нь Эрүүгийн хуульд заасан нөхцөл байдлууд, түүний дотор үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэлд хамааралтай юм.

Үндэслэл бүхий эрсдлийн үндсэн шинж

Үндэслэл бүхий эрсдлийн агуулгыг тодорхойлохын тулд

¹⁹ Гринберг М. С. Проблема производственного риска в уголовном праве. М. 1963.

²⁰ Пионтковский А. А. Курс советского уголовного права. М. 1970.

²¹ Козаев Н. Ш. Обоснованный риск как обстоятельство, исключающее преступность деяния: учебное пособие. Ставрополь, 2001

²² Мельникова Ю. Б. Дифференциация ответственности и индивидуализация наказания. Красноярск, 1989.

²³ Савенок А.Л.Риск: социально-правовые аспекты: учебное пособие. Минск, 1999.

²⁴ Я.Цэвэл.Монгол хэлний товч тайлбар толь. УБ.1966. 622 дахь тал.

²⁵ Я.Цэвэл.Дурдсан бүтээл. УБ., 1966. 849 дэх тал

²⁶ Я.Цэвэл.Дурдсан бүтээл. УБ., 618 дахь тал

²⁷ Я.Цэвэл.Дурдсан бүтээл. УБ., 1966. 545 дахь тал

²⁸ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2008.355 дахь тал



түүний үндсэн шинжүүд, тэдгээрийн хоорондын харилцан уялдаа холбоог тусгаж өгөх шаардлагатай. Эд зүйлс болон аливаа үзэгдлийн харьцангуй тогтвортой, оршин тогтнох дотоод талыг үндэслэл бүхий эрсдлийн үндсэн шинж гэнэ.

Доктор (Sc.D), профессор С.Жанцан үндэслэл бүхий эрсдлийн үндсэн шинжид:

- Үндэслэл бүхий эрсдэл нь нийгэмд ашигтай зорилгод хүрэхээр хийгдсэн байна.
- Эрсдэлтэй үйлдэл хийхгүйгээр нийгэмд ашигтай зорилгод хүрч чадахгүй байсан.
- Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг, сонирхолд гэм хор учруулахгүйн тулд хангалттай арга хэмжээ авсан байх.
- Хууль ёсны байх зэргийг хамааруулсан²⁹.

Үндэслэл бүхий эрсдлийн үндсэн шинжийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

1.Төрөөс хүлээн зөвшөөрсөн нийгэмд ашигтай зорилгод чиглэсэн байх.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд³⁰ эрдэм шинжилгээ, судалгааны ажлын явцад үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил явуулахгүй байх зарчмыг баримтлахаар заасан байна. Түүнчлэн, төр болон бусад санхүүжүүлэгч иргэн, хуулийн этгээд эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үндэслэл бүхий эрсдэлийг хүлээн зөвшөөрөхөөр хуульчилсан нь эрсдлийн

хууль ёсны байх шинжийг баталгаажуулсан байна.

Эрсдэлтэй үйл ажиллагааны үр дүнд хүмүүсийн амь нас аврагдсан, үйлдвэрлэлийн ашиг эрс өссөн, зайлшгүй хэрэгцээнд зарцуулах эд хөрөнгө хэмнэгдсэн, шинжлэх ухааны нээлт хийсэн бол нийгэмд ашигтай зорилгод хүрсэн гэж үзнэ. Хэрэв тухайн этгээд өөрөө ашиг хонжоо олох, алдарших, албан тушаал ахих зорилгоор үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны эрсдэл бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлж бусдад гэм хор учруулсан нь тогтоогдвол нийтлэг үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Үндэслэл бүхий эрсдлийн нийгэмд ашигтай зорилгыг хэт өргөнөөр тодорхойлсноор бусад нөхцөл байдлын үед ч давхардаж болохыг үгүйсгэх аргагүй юм. Тухайлбал, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах явцад субъект нь гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэгтнийг хууль сахиулах байгууллагад хүргэх гэсэн нийгэмд ашигтай зорилгод хүрэхийн тулд олон хүн бөөгнөрсөн газар галт зэвсэг хэрэглэх, олон хүн барьцаалах явцад аргагүй хамгаалалтын нөхцөлд нийгэмд ашигтай зорилгод хүрэхийн тулд барьцаалагдсан хүмүүст хохирол учруулах гэх мэт. Тийм учраас нийгэмд ашигтай зорилгод хүрэх гэдгийг илүү оновчтой тодорхойлж бусад нөхцөл байдлуудаас ялгаж өгөх шаардлагатай. Энэ шинжийн гол мөн чанар нь субъектэд нийгэмд ашигтай зорилгод хүрэхийн тулд хууль тогтоомжоор тогтоосон хэм хэмжээнээс ухамсартайгаар зайлсхийх явдал юм.

2.Эрсдэл гаргагч субъект нь эрсдэлтэй үйл ажиллагаа

явуулж буй салбарт мэргэшсэн, дадлага туршлагатай этгээд байх.

Өөрөөр хэлбэл эрсдэл гаргагч этгээд нь тухайн салбарын мэдлэг, чадварт тулгуурласан байх ба шинжлэх ухаан технологийн тухай хуульд³¹ эрдэм шинжилгээ, судалгаа, зохион бүтээх туршилтын үйл ажиллагааны явцад тухайн ажлын онцлог байдал, цаашид хөгжүүлэх арга замыг сайтар мэддэг, энэ чиглэлээр мэдлэг, дадлага, туршлага хуримтлуулсан, шинэ бүтээл оновчтой саналууд гарган нэвтрүүлж байсан эсэх зэргийг харгалзан үзэхээр заажээ.

3.Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаанд хохирол учруулсан байх.

Үндэслэл бүхий эрсдэл гаргагч этгээд нь эрүүгийн хуулиар хамгаалагдсан хувь хүн, байгууллага, аж ахуй нэгж, төрийн амин чухал эрх ашиг сонирхол, буюу хууль тогтоогч тэргүүн ээлжинд хамгаалалтанд авахыг эрмэлзсэн тэр нийгмийн харилцаанд хохирол учруулсан байх явдал юм. Тухайлбал Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, гадаад аюулгүй байдал, хүний амь бие эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, нийгмийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгал орчин, эрх зүйн журам, энх тайван, хүн төрөлхтөний аюулгүй байдал зэрэг юм. Эрсдэл бүхий үйл ажиллагааны явцад удирдлага төлөвлөлт, зохион байгуулалт, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, горимын мөрдөлт, түүхий эд, түүний хадгалалт, хамгаалалт, байгал орчинд нөлөөлөх байдал, мэдээлэл хангахмж, тооцоо,

²⁹ С.Жанцан.Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ.2009.742-744 дэх тал

³⁰ Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн тухай хуулийн. 4.1.1

³¹ Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 13 дугаар зүйл



судалгаа зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзнэ.

4.Нийгэмд ашигтай зорилгод хүрэхэд чиглэсэн тодорхой үйлдэл, эс үйлдэхүй хийсэн байх.

Эрсдлийн аюул бий болгосон нөхцөлд зөвхөн нийгэмд ашиг тустай зорилгод хүрэх боломж бодитойгоор байх, субъект үүнийг ухамсарлаж, үнэлгээ өгсөн байх явдал юм. Эрсдэлийн талаарх эрүүгийн эрх зүйн зохицуулалтаас үзэхэд хандах гол хандлага нь ямар үр дагавар гарах нь тодорхойгүй, таагүй тохиолдолд сөрөг үр дагавар гарах магадлалатай зөвшөөрөгдөөгүй нөхцөлд эрсдэл гаргагч өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг удирдах, хянах сэтгэл зүйн асуудал чухал ба үүний чухал бүрэлдэхүүн хэсэг нь өөрийн үйлдлийг удирдах явцад эрсдэлийн хэмжээг тогтоох явдал юм. Өөрөөр хэлбэл эрсдлийн нөхцөл байдлыг зөвөөр үнэлж дүгнэсэн байх (сонголт хийж шийдвэр гаргах) гэсэн үг.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын явцад эрсдэл гаргагч нь өөрийн үйлдлийн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлахгүй явдал байж болох боловч тухайн этгээд өөрийн үйлдлийн улмаас хуулиар хамгаалагдсан эрх ашиг сонирхолд хохирол учирч болзошгүйг урьдчилан ухамсарлаж мэдсэн, ямар ч үндэслэлгүйгээр хохирол гаргахгүй урьдчилан сэргийлэнэ чадна гэж хөнгөмсөгөөр найдсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хөнгөмсөгөөр найдах нь тухайн нөхцөл байдлын шинж чанар, хэр хэмжээнээс хамаарч янз бүрийн түвшинд үнэлэгдэнэ. Жишээ нь: Цөмийн реактортой ажиллаж буй этгээдийн хөнгөмсөгөөр

найдсаныг, тээврийн хэрэгсэл жолоодож байгаа этгээдтэй харьцуулахад нийгмийн хор аюулын хэр хэмээгээрээ ихээхэн ялгаатай нь ойлгомжтой. Жолооч хориотой хэсэгт автомашин гүйцэж түрүүлэх үйлдэл хийхдээ өөрийн болон зорчигчдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахгүй байж чадна гэж найдаж байгаа учраас өөрийн үйлдлийн нийгэмд аюултай шинжийг ухамсарлаагүй байж болно. Цөмийн реакторын үйл ажиллагааг доголдуулж аюултай нөхцөл байдал үүсэх үед эрсдэл гаргагч хохирол учруулахгүй байж чадна гэж тооцоолж байсан ч өөрийн үйлдлийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээг заавал ухамсарласан байх ёстой. Гэхдээ дээрх тохиолдолд Эрүүгийн хуулиар гэм буруугийн болгоомжгүй хэлбэрийн нэг төрөл болох хөнгөмсөгөөр найдах нь гэмт хэргийг зүйлчлэхэд нөлөөлөхгүй эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Үндэслэл бүхий эрсдэлийн тухай ойлголтонд нийгмийн харилцаанд ямар нэгэн байдлаар хохирол учруулж болох бүхий л үйлдлүүд хамааруулж болохын зэрэгцээ судалгааны бүтээлүүдэд энэ талаар нэгдмэл ойлголт байхгүй, эрүүгийн эрх зүйн ач холбогдлыг тодорхойлоогүй байна.

5.Үндэслэл бүхий эрсдэл гаргагч нь өөр аргаар нийгэмд ашигтай зорилгод хүрэх боломжгүй байх.

Эрүүгийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэхийн тулд эрсдэл гаргагч хангалттай арга хэмжээ авсан байна. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц буюу үр дүнд байгаль орчин, хүн, мал, амьтны эрүүл

мэндэд хортой нөлөө үзүүлэхээр байдал илэрвэл мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, дүгнэлт гаргуулах, угбайдал тогтоогдвол ажлаа зогсоох, учирч болох сөрөг нөлөөлөл, хохирлын талаар мэдэгдэж хэрэв эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явцад гэрээнд заасан үр дүнд хүрэх бололцоогүй нь нотлогдсон, эсхүл давагдашгүй хүчин зүйл, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаасуг ажлыг цаашид хэрэгжүүлэх бололцоогүй болсон бол энэ тухайгаа захиалагчид даруй мэдэгдэх үүргийг хуулиар заасан байна.

Энэ шинжийг хэрэг явдлын нийгмийн аюулыг үгүйсгэх хэд хэдэн нөхцөл байдлын төрөл болох гарцаагүй байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах явцад гэм хор учруулах зэрэг нөхцөл байдалд хэрэглэж болно.

Үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын явцад буюу зохион бүтээх, төрөл бүрийн салбар дахь туршилтын үйл ажиллагааны явцад ихэвчлэн эрсдэл гардаг. Энэ талаар А.А.Пионтковский “Шинжлэх ухаан техникийн хөгжил нь шинэ туршилт хийхгүйгээр цааш нь хөгжих боломжгүй.”³² гэж тодорхойлсноос хойш судлаачид үндэслэл бүхий эрсдэл нь хэрэг явдлын нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын нэг бие даасан төрөл гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Туршилт гэдгийг хяналттай, удирдагддаг нөхцөлд туршилт, ажиглалт хийх маягаар шийдвэр гаргахыг ойлгоно.

Туршилтын үйл ажиллагааны үеийн эрсдэл гэдэгт эрсдэл гаргагч нь нийгэмд ашигтай үр

³² Гринберг М. С. Значение производственно-хозяйственного риска по советскому уголовному праву: автореф. дис. . канд. юрид. наук. М. 1957. 68 стр.



дүнд хүрэх зорилгоор тухайн үзэгдлийн явцад хяналт тавьж, олон дахин хийж болох нөхцөлд сайн дураар аюул бий болгохыг хэлнэ. Туршилтын талаар Польшийн ЭХ-ийн 27-р зүйлд “Танин мэдэхүй, эмнэлэг, техник эсвэл эдийн засгийн салбарт ашигтай үр дүнд хүрэх зорилгоор туршилт хийхдээ хууль ёсны байдал, орчин үеийн шинжлэх ухааны мэдлэгийн түвшинд үндэслэсэн арга хэрэглэсэн нөхцөлд гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасан байна.³³ Уг зүйлийн 2 дугаар хэсэгт туршилтыг хууль ёсны гэж үзэх нэмэлт шинжийг зааж өгчээ. “Хүлээж буй эерэг үр дүн гарах магадлал болон сөрөг үр дагавар, туршилтын аль ч шатанд татгалзах боломж, мөн туршилтыг захиалагчийн зөвшөөрөлгүйгээр хийхийг хориглоно” гэж заажээ.

Энэ нь анагаахын салбар дахь туршилтыг шинжлэх ухааны үндэслэлтэй, хуулиар зөвшөөрөгдсөн, шинжлэх ухааны хамгийн сүүлийн үеийн мэдлэг дээр тулгуурласан нөхцөлд хууль ёсны гэж үзнэ гэсэн үг юм. Зөвхөн энэ шаардлагыг хангасан эмч, эмнэлгийн байгууллага туршилт хийх эрхтэй. Туршилт хийх тухай шийдвэр нь эрх бүхий эмнэлгийн байгууллагын зөвшөөрөл, мэргэжлийн эмч нарын зөвлөгөөнөөс гарсан хамтарсан шийдвэр, өвчтний өөрийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зохих зөвшөөрөл байх ёстой.

Үндэслэл бүхий эрсдлийн ангилал төрлүүдэд дүн

³³ Уголовный, Уголовно процессуальный и Уголовно-исполнительный кодексы Польской Народной республика 1973.

шинжилгээхийх замаар эрсдлийн төрлийг дараах байдлаар хувааж болох юм. Тухайлбал, эрсдлийн зан үйлийн зорилгоор: хувийн болон нийгмийн эрсдэл, зохион байгуулалтын түвшингээр зохион байгуулалттай ба зохион байгуулалтгүй эрсдэл, нийгэмд үзүүлэх ач холбогдлоор: эерэг, нейтраль, сөрөг эрсдэл, эрсдэлтэй зан үйлийн түвшингээр зөвшөөрөгдсөн, зөвшөөрөгдөөгүй эрсдэл, хэмжээгээр хамгийн бага, хамгийн их хэмжээний эрсдэл, гарах салбараар нь улс төрийн, цэрэг, батлан хамгаалах үйл ажиллагааны, анагаахын, эдийн засгийн, цөмийн эрчим хүчний, худалдааны, аж ахуйн, соёл, урлаг, боловсролын, техникийн эрсдэл, тээврийн, галын аюулгүй байдлын, сансарын, цахим мэдээллийн, харилцаа холбоо, шуудангийн, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны, хууль сахиулах ажиллагааны, үйлдвэрлэлийн, шинжлэх ухааны эрсдэл гэх мэтээр ангилж болох юм. Эрүүгийн хуульд заасан үндэслэл бүхий эрсдлийн хэм хэмжээнээс үзэхэд 2 хэлбэрт хуваан үзэж болно. Үүнд:

- Үндэслэл бүхий эрсдэл
- Үндэслэлгүй эрсдэл

Үндэслэл бүхий эрсдэлд: үйлдвэрлэлийн эрсдэл, шинжилгээ, судалгааны ажлын эрсдэл хамаарна.

Үндэслэлгүй эрсдэлд: олон хүний амь насанд гэм хор учруулах, нийтийг хамарсан буюу байгалийн гамшигт үр дагаварт хүргэсэн эрсдлийг ойлгоно.

Үндэслэл бүхий эрсдлийн төрлийн талаар эрдэм шинжилгээний бүтээлүүдэд хүний үйл ажиллагааны бүхий л салбарт эрсдэл байдаг тул Эрүүгийн хуульд нарийвчлан заах шаардлагагүй гэж үздэг. Гэхдээ төрөлжүүлэн ангилж судалснаар эрсдлийн хэлбэрийн агуулгыг тодорхойлоход ач холбогдолтой.

Эрүүгийн эрх зүйд хэрэг явдлын нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын зохицуулалт боловсронгуй бус байгаа нь дараах хүчин зүйлсээс хамааралтай байна. Үүнд:

1. Хэрэг явдлын нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын талаар нэгдмэл ойлголтонд хүрээгүй, бүрэн судлагдаагүй, нийтэд ойлгомжтой бус,

2. Дийлэнх судлаачид зөвхөн аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд анхаарал хандуулж ирсэн

3. Хэрэг явдлын нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын талаар бүтээл судалгаа ховор байна.

4. Үндэслэл бүхий эрсдлийн агуулга нь хэрэг явдлын нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын бусад төрлөөс агуулга, мөн чанарын хувьд өргөн хүрээтэй учир агуулгыг бүрэн дүүрэн тодорхойлоогүй.

5. Манай орны хувьд үйлдвэрлэл, техник технологи өндөр түвшинд хөгжөөгүй зэрэг болно.



**ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН АЮУЛЫГ ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ
БАЙДЛЫН УЛАМЖЛАЛ, МОНГОЛЫН ЭРҮҮГИЙН
ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ОНЦЛОГ**

Б.Хишигтогтох

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх
ажиллагааны онол, тактикийн тэнхимийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа*



Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын ойлголт онол-арга зүйн үндэслэлийн уламжлалыг авч үзэхэд Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн үе шаттай зайлшгүй холбон тодорхойлох шаардлага урган гарч ирэх бөгөөд уг асуудлыг манай улсын эрдэмтэн, судлаачид өөрсдийн бүтээлдээ тусган тэмдэглэснийг дурдахгүй өнгөрөх аргагүй.

Монголын Эрүүгийн хууль тогтоомжийн уламжлалыг дараах үе шатанд хувааж үзэж болохоор байна. Үүнд:

1. Их эзэнт гүрний үе
 2. Түүнийг залгамжлагчдын үе
 3. Эзэнт гүрний бутралын үе
 4. Манжийн дарлалын үе
 5. Ардын хувьсгалын анхны жилүүдийн үе (1921-1926)
 6. Хувьсгалын үе (1926-1960)
 7. Социализмын үе (1961-1992)
 8. Өнөө үеийн (1992-2014)
- зэрэг болно.

Монгол Улс 1924 онд Анхдугаар Үндсэн хуулиа баталж, улмаар 1926 онд “Шүүх цаазын бичиг” нэртэйгээр өнөөгийн томъёоллоор Эрүүгийн хуулиа баталсан. Харин 1942 онд “Эрүүгийн хууль” хэмээн баталжээ. “Эрүү” гэдэг үгийг хэл зүйн үүднээс авч үзвэл, Орос хэлээр “Уголовный кодекс (закон)” гэж томъёолдог. Энэхүү “Уголовный” гэдэг үг нь “уголовье” буюу “толгойгүй” гэсэн үгийн агуулгыг илэрхийлдэг учир утгын хувьд “цааз” гэсэн агуулгыг өөртөө шингээсэн тул “уголовное право” буюу “эрүүгийн эрх зүй” гэдэг томъёолол үүсчээ гэж үзэх бүрэн магадлалтай. 1926 онд тухайн цаг үеийн их бичгийн судлаач-эрдэмтэд “эрүү” гэсэн агуулгыг нь “махчлан” орчуулалгүй чухамхүү “цааз” гэсэн үнэнхүү Монголын сурвалж бичиг, хууль, ном-судрын уламжлалыг хадгалж “Шүүх цаазын бичиг” хэмээн томъёолсон байж магад гэж миний хувьд бишрэн сүсэглэж явдаг билээ.

1926 оны “Шүүх цаазын бичиг”-ийн үеэс эхлэн гэмт хэргийн шинжийг үгүйсгэгч нөхцөл байдлуудыг хуулинд томъёолох эхлэлийг тавьсан байдаг. Энэ тухай доктор(Sc.D), профессор С.Жанцан “1926 оны

Шүүх цаазын бичгийн “Ял үл хэлэлцэх” хэмээх 3-р бүлгийн 21-р зүйлд “Аливаа хүн оноосон албан тушаалын буюу харьяат газрын эрх баригчдын тушаасан албан зүйлүүд нь хууль цаазын дор илтэд зөрчсөн бус бөгөөд ёсоор гүйцэтгэж шийтгэх дор гэмт учир явдал тохиолдвол түүн дор ял үл хэлэлцэнэ” гэжээ. Энэ нь дээд газрын тушаал биелүүлж хохирол учруулбал гэмт хэрэг биш болохыг илэрхийлж байна.

22 дугаар зүйлд “Өөрийн буюу бусдын амь ба биеийг буюу эрх чөлөөг хамгаалахын тулд үйлдсэн хэрэг нь хэр хэмжээнээс хэтрээгүй бөгөөс ял үл хэлэлцэнэ” гэж анх удаа аргагүй хамгаалалтыг хуульчилсан байна. Энэ заалт 1929 оны Шүүх цаазын бичгийн 23-р зүйлд өөрчлөлтгүйгээр хуульчлагдсан. 1934 оны Шүүх цаазын бичгийн 3-р бүлэг, 7-р зүйлийн 2 дахь хэсэгт “Ардын хувьсгалт засагт халдахаар завдсан ба эсхүл өөрийн ба бусдын амь бие, эд хөрөнгө, эрх чөлөөнд халдсныг эрх биш хамгаалахаар үйлдсэн хэрэг нь хэр хэмжээнээс хэтрээгүй бол ял үл хэлэлцэнэ” гэж аргагүй хамгаалалтыг томъёолохдоо халдлагын объектод Ардын хувьсгалт засгыг тусгайлан



хамааруулсан нь шинэ юм¹ гэжээ

Үүнээс үзвэл, Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжид анхнаасаа “Үйл явдлын аюулыг үгүйсгэгч нөхцөл байдал” гэж томъёолж ирсэн бөгөөд “үйл явдлын” гэсэн нь тухайн болсон хэргийн (гэмт хэргийн) дараах мөн чанаруудыг гол үндэслэл болгож байсан гэж үзэх талтай. Тухайлбал,

1. Үйл явдлыг бүхэлд авч үзсэнээрээ юуны өмнө түүний философи-социологи агуулгыг нь тодорхойлохыг эрмэлзэж байсан байна. Энэ завсар тэмдэглэхэд “социал” гэдэг үгийг манай судлаач-эрдэмтэд 1960 оноос эхлэн “нийгэм” гэж тун ч өрөөсгөл утгаар томъёолж ирсэн. Энэ тухай доктор С.Молор-Эрдэнэ: “Социологи гэсэн мэргэжлийн нэрлэгээг “амьдралын судалгаа” гэж орчуулан хэрэглэх боломжтой. Гэтэл “нийгмийн ухаан” гэж алдаатай орчуулснаар хамтран амьдрах бодит зүйлийг судалдаг салбарыг нийгэм гэж нэрлэжээ. Энэ орчуулгад бас ухаан гэж нэмж хэлснээр хэтэрхий абстракт болж амьдралаас хөндийрчээ” гэсэн байна.

Социологийн мэргэжлийн гол зорилго гэвэл хүмүүс хэрхэн “хамтдаа амьдарч” буйг судлах. Хамтдаа амьдарцгаахыг мэргэжлийн нэрлэгээгээр “социал” гэж нэрлэдэг. Хамтдаа амьдрах чадвартай хүмүүсийг “социал”, харин чадваргүй хүмүүсийг “асоциал” гэдэг. Социалын төлөө улс төрийг “социализм” гэж нэрлэдэг. Социолог гэдэг хамтын амьдрал хортой юу, эвтэй юу эсвэл хонзонтой юу, найрамдалтай

юу гэдгийг дүгнэж гаргалгаа гаргадаг “экспирийн” салбар юм. Улс оронд өнөөдрийг хүртэл хамтын амьдралыг социализмын 70 жилд хэрхэн явагдсан мөн сүүлийн 20 жилд хэрхэн явагдсан гэх мэт хүмүүс рүү чиглэсэн олон нийтийг ухааруулсан тийм мэргэжлийн хүмүүс дутагдсаар. Тиймээс социологийн мэргэжлийг дэлгэрүүлэх хугацаа нэгэнт болсон² гэжээ.

Үнэхээр аливаа юмс үзэгдлийн “социол” мөн чанарыг жинхэнэ шинжлэх ухаанны арга зүйн үүднээс нарийвчлан тодорхойлох шаардлага зүй ёсоор урган гарч ирж байна гэдэгтэй хэн ч маргахгүй гэдэг нь нэн ойлгомжтой. Ялангуяа нийгэмд амьдралын орчинд гарсан (гарч болох) “үйл явдал” хэрэг нь юуны өмнө амьдралаас урган гарч ирдэг үзэгдэл байдаг. Иймд “үйл явдал” гэж томъёолж ирсэн нь түүний амьдралд зайлшгүй байдаг гэсэн философи мөн чанарыг илэрхийлж байна.

2. Үйл явдал нь хүрээлэн буй орчинтойгоо ямагт түгээмэл хэлхээ холбоотой, динамик үзэгдэл учир тэр нь үнэхээр бодит мөн чанартай зүйл юм.

3. Иймд үйл явдлыг тодорхой нөхцөлт тохироонд гардаг бодитой тохиолдол гэж ямагт үздэг бөгөөд агуулгын хувьд зөвхөн тухайлан хэрэг зерчлийн хүрээнд биш харин илүү өргөн нөхцөлд оршиж байдаг гэдгийг онцгой анхаарах хэрэгтэй. Чухам ийм учраас 1942-1961 оны Эрүүгийн хуулиудад “Үйл явдлын аюулыг үгүйсгэх нөхцөл байдал” гэж томъёолон зааж иржээ.

Аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын эрүүгийн эрх зүйн мөн чанарыг доктор(Sc.D),

профессор Г.Совд Монгол орны хувьд бараг анх удаа нарийвчлан судалж тодорхойлсон гэж үзэх бүрэн үндэстэй. Энэ дашрамд товчхон тэмдэглэхэд 1942 оны Эрүүгийн хуулийн 3-р бүлэгт аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг буюу онцгойлон аргагүй хамгаалалтын шинжийг нилээд нарийвчлан заахыг анхлан оролдсон улмаар 1961 оны Эрүүгийн хуульд аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг илүү дэлгэрүүлэхийг хичээсэн байдаг. Энэ тухай доктор (Sc.D), профессор Г.Совд: “Манай эрүүгийн эрхээр гэмт явдлуудын нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын ойлголт нь тухайн үйл явдлын нийгмийн хор аюулыг зөвхөн үгүйсгэдэг төдийгүй харин тэр үйл явдлыг нийгэмд ашигтай байдлаар тайлбарладаг. Ямар нэгэн үйл явдлыг нийгэмд аюултай шинж тэмдгийг тодорхойлогч нь гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх элементийн нийлбэр байдаг. Харин ямар нэгэн үйл явдлын нийгэмд аюултай шинж нь үгүйсгэгдвэл тухайн үйл явдалд гэмт хэргийн бүрэлдэхүүн байж болохгүй” гэжээ.

Нийгмийн аюул нь үгүйсгэгдэх байдлаар илэрч байгаа үйл явдлууд нь манай нийгэм төрийн байгууламж болон эрүүгийн хуулиар хамгаалсан социалист нийгмийн бусад харилцаанд хор аюул хүргээгүй байдаг төдийгүй социалист нийгмийн эрх ашигт зайлшгүй хэрэгцээтэй ашигтай зүйл байдаг тул гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байдаг. Ийм учраас нийгмийн хол аюулыг үгүйсгэх нөхцөл байдлаар үйлдэгдсэн үйл явдлуудыг хууль ёсны үйл ажиллагаа гэж үздэг. Манай эрүүгийн эрхээр

¹ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009. 663 дахь тал. Д.Адьяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжил. УБ. 1998. 40 дэх тал

² С.Молор-Эрдэнэ. Ар Монголд орчин үе үгүйлэгдэнэ. УБ., 2011. 51 дэх тал



нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдалтай үйл явдал гэдэгт доорхи үйл явдлуудыг хамааруулан ойлгодог. Үүнд:

1. Аргагүй хамгаалалт
2. Гарцаагүй байдал
3. Мэргэжлийн болон албаны хувьд гүйцэтгэх үүргээ биелүүлэх
4. Хохирогчийн зөвшөөрөл
5. Хууль биелүүлэх
6. Заавал биелүүлэх даргын тушаал гүйцэтгэх
7. Өөрийн эрхээ биелүүлэх
8. Үйлдвэрлэлийн шаардлага биелүүлэх ажиллагаа эдгээр болно³ гэжээ.

Үүнээс гадна манай эрүүгийн эрх зүйн судлаач—зарим эрдэмтэд тухайлбал, Т.Дэндэв, Х.Түдэв, Д.Адъяабазар, Б.Намсрай нар аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын тулгуур ойлголтын талаар нэг сэдэвт бүтээл хэвлүүлжээ. Ялангуяа, судлаач Б.Намсрай “Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын тулгуур ойлголтууд”. УБ., 2003 бүтээлдээ аюулыг үгүйсгэх үндсэн нөхцөл байдал болох аргагүй хамгаалалт ба гарцаагүй байдлын тухай нилээд шинжлэх ухаанч арга зүйн үндэстэй тодорхойлон бичиж аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын бодит үндэслэл, шалгуурыг нарийвчлан тогтоох хэрэгтэй гэж үзсэнийг сайшаан дэмжиж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийг 1986-1987 онд өөрчилж “БНМАУ-ын шинэчлэн найруулсан эрүүгийн хууль” гэж нэрлэсэн. Энэ хууль нь эрүүгийн хууль тогтоомжийн шинэ үзэл бодол, зарчмыг зоригтой хуульчлан тодорхойлж эрүүгийн хуулиас а) Үзэл сурталжсан, б)

Улс төржсөн, в) Хэт намчирхсан зүйл ангиудыг хасч гэмт хэрэг ба эрүүгийн ялын бодлогод тэр цаг үеийн “өөрчлөн байгуулалт-олон ургаль” үзлийн үүднээс цоо шинэ гэж хэлж болохуйц бодитой өөрчлөлтүүдийг хийж чадсан. Энэ тухай А.Алтангэрэл: *“Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нь Эрүүгийн хуулийг боловсронгуй болгоход нэн чухал алхам болсон бөгөөд гэмт хэргийн анхны ангилалтыг хийж (6-р зүйл), онц аюултай рецидив гэмт хэрэгтний талаар тодорхойлж егч (23-р зүйл), ял тэнсэх (40-р зүйл), хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх (35, 36-р зүйл) зэрэг институтыг боловсронгуй болгожээ. Дээрх өөрчлөлтүүдийг хийснээрээ манай улсын эрүүгийн хууль тэр үеийн ЗХУ-ын Эрүүгийн хуулиас ялгагдах онцлогтой болж чадсан юм”*⁴ гэж тэмдэглэсэн байна.

Гэвч аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын үндсэн ойлголт бодит шалгууруудыг төдийлөн дорвитой өөрчилж чадаагүй байна. Энэ тухай доктор(Sc.D), профессор С.Жанцан: “1986 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 12 дугаар зүйлд 1961 оны онцын өөрчлөлтгүйгээр аргагүй хамгаалалтыг, мөн зүйлийн 3 дахь хэсэгт гэмт этгээдийг албадан саатуулахын тулд хохирогч буюу бусад хүмүүсээс энэ хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийсэн бол аргагүй хамгаалалттай адилтгаж үзнэ. Эрүүгийн хуулийн 13-р зүйлд гарцаагүй байдлыг 1961 оны Эрүүгийн хуулийн заалттай төсөөтэйгээр хуульчилжээ⁵ гэжээ.

⁴ А.Алтангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх гарцаагүй байдал, түүний эрүүгийн эрх зүйн зохицуулалт. УБ., 2012. 13-14 дэх тал

⁵ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ. 2009. 664 дэх тал

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан нь өргөн утгаараа Монгол Улсын бүх хуулийн тэр дундаа Эрүүгийн хуульд заасан аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын талаар тусгайлан заасан эрүүгийн хуулийн холбогдох бүлэг, зүйл нь Үндсэн хуулийн заалтыг амьдралд хэрэгжүүлэх хууль цаазын давхар баталгаа болж буйг харуулж байна.

2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуульд анх удаа аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг “Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдал” гэж шинэчлэн томъёолсоны дээр 1.Аргагүй хамгаалалт, 2.Гарцаагүй байдал, 3.Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах, 4.Үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл, 5.Тушаал, захирамж биелүүлэх гэсэн таван үндсэн төрлийг хуульчилсан.

Энэ хуульд аюулыг үгүйсгэх нөхцөл байдлыг ийнхүү томъёолон тодорхойлохын зэрэгцээ 8-р бүлэгт анх удаа гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлуудыг тусгайлан хуульчилж өгсөн нь онол-практикийн ач холбогдолтой, зүйл болж чадсан боловч гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын хууль цаазын ба эрүүгийн эрх зүйн мөн чанарын бодит үндэслэл, шалгуурыг төдийлөн бодитой зааж чадаагүй гэж үзэх үндэстэй юм. Энэ тухай С.Жанцан: “...олон

³ Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. УБ., 1974. 269-270 дахь тал



улсын практикт хүч хэрэглэсэн шунахай сэдэлттэй гэмт хэргүүд болох хүнийг санаатай алах, бие махбодид хүнд, хүндэвтэр гэмтэл санаатай учруулах, хүн барьцаалах, хүн хулгайлах, булаах, дээрэмдэх, танхайрах, уулгалан довтлох, террор үйлдэх зэрэг гэмт хэрэгтэй явуулах тэмцлийг хүчтэй, үр өгөөжтэй болгох шаардлага зүй ёсоор урган гарч байгааг “Хохирогчийн зөвшөөрөл”, “Биеийн болон сэтгэл зүйн халдлага”, албан үүргээ биелүүлэхтэй холбоотой, тухайлбал “Гүйцэтгэх ажлын арга хэмжээг хэрэгжүүлэх”, “Гэмт бүлэглэл, зохион байгуулалттай бүлгийн гэмт үйл ажиллагааг урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоохтой холбоотой тусгай арга хэмжээ зохион байгуулах” зэрэг өвөрмөц нөхцөл байдлуудыг гэмт хэргийн шинжийг үгүйсгэх нөхцөл байдлуудад хамааруулан хуульчилж болох юм⁶ гэсэн нь өнөөгийн манай нийгмийн сэтгэл зүйн онцлог нэн ялангуяа олон нийтийн бодитой айдас түгшүүрийг зөв мэдэрч холбогдох хууль тогтоомж, онцгойлон эрүүгийн хуулийг цаашид улам боловсронгуй болгох бодит шаардлага зүй ёсоор тулгарч байгааг бодитой илтгэн харуулж байна.

Энэ байдлыг эрүүгийн эрх зүйч-эрдэмтдийн явуулсан шинжлэх ухааны үндэслэл бүхий судалгаа бас давхар нотолж байна. Тухайлбал, “Бид орчин үеийн гэмт хэргийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын (цагдаа, тагнуул) үйл ажиллагааны талаар иргэдийн дунд тандалт судалгаа

хийсэн. Бидний судалгаанд хамрагдагсдын “84% нь гэмт халдлагад өртөхөөс байнга айж, түгшүүртэй байдаг, 66% нь төр иргэдийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг хамгаалах үүргээ хангалтгүй биелүүлдэг, 79% нь хууль цагдаагийн байгууллага тэдний эрхийг хамгаалахаар тодорхой арга хэмжээ авна гэдэгт итгэдэггүй, өөрт нь аюул тохиолдсон үед 10% нь цагдаад, 90% нь зөвхөн өөртөө л найдна” гэж хариулснаас харахад төр, түүнийг төлөөлсөн байгууллага болох цагдаагийн байгууллага иргэдийн аюулгүй байдал, эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах үүргээ хангалтгүй биелүүлж байгааг илтгэж байна. Энэ тохиолдолд иргэд гэмт халдлагаас өөрийгөө болон ойр дотны хүмүүсийнхээ эрх ашгийг хамгаалах явцдаа халдагч этгээдэд гэм хор учруулсан бүх тохиолдлыг аргагүй хамгаалалтын нөхцөлд хийсэн гэж үзэх нь зүйд нийцнэ”⁷ гэжээ.

Иймд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын хууль цаазын ба эрүүгийн эрх зүйн мөн чанар, нэн ялангуяа тэдгээр нөхцөл байдлын хэр хэмжээ, шалгууруудыг зөвхөн эрүүгийн эрх зүйн төдийгүй социологи, эдийн засаг, нийгэм-сэтгэл зүй тэр ч байтугай биологи, физиологи зэрэг холбогдох төрөл бүрийн шинжлэх ухааны үүднээс нарийвчлан судлан тодорхойлж улмаар эрүүгийн хууль болон холбогдох бусад төрлийн хууль дүрэмд бодитой тусган оруулах амьдралын бодит шаардлага тулж ирээд байгааг дахин тэмдэглэж байна. Болсон үйл явдлын аюулыг үгүйсгэх нөхцөл байдал илрэх тохиолдол нь зөвхөн гэмт хэрэгтэй

холбогдож гардаг зүйл биш бөгөөд цэрэг, хил хамгаалалт, гал түймэр, авран хамгаалах зэрэг янз бүрийн онцгой байдлуудтай ергөн холбогддог болох нь нэгэнтээ батлагдсан зүйл болох тул дурьдсан чиглэлийн холбогдох хууль тогтоомжид ч гэсэн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлыг бодитой тусгах тэгэхдээ түүний хууль-эрх зүйн үндэслэл нь зөвхөн эрүүгийн эрх зүй-эрүүгийн хууль байх учиртай.

Иймд аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын мөн чанарын тухай Г.Совд: “Үйл явдлын нийгэмд аюултай байдлыг үгүйсгэх нөхцөл байдлууд гэдэг бол зөвхөн уг этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөд нөлөөлөхдөө тухайн үйл явдалд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байгааг тодорхойлох аль нэг талын шинж тэмдэг биш өөрийнхөө мөн чанараараа нийгмийн эрх ашгийн шаардлагаас үндэслэсэн бөгөөд ашигтай зайлшгүй зүй ёсоор хийгдсэн зүйл байдаг учраас нийгэмд аюултай нөхцөл байдал байдаггүй билээ. Нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудтай үйл явдлууд нь үйлдлийнхээ гадаад хэлбэрээр гэмт хэрэгтэй төстэй боловч онолын нарийн судалгаа шаарддаг. Ийм учраас түүний дотоод агуулгын нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд нь туйлын нарийн нөхцөл болзлуудтай байдаг ажээ”⁸ гэж түүний хууль цааз-эрүүгийн эрх зүйн нарийн төвөгтэй үйл явц-нийгмийн үзэгдэл болохыг тодорхойлсон байдаг.

Монголын эрүүгийн эрх зүйн чиглэлийн эрдэмтэн, судлаачид аюулыг үгүйсгэх нөхцөл байдлыг

⁶ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ. 2009. 665 дахь тал

⁷ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ. 2009. 665 дахь тал

⁸ Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. УБ.1973. 270 дахь тал



янз бүрээр тодорхойлсон байдаг. Тухайлбал, доктор Б.Содовсүрэн “БНМАУ-ын эрүүгийн эрхээр гадаад хэлбэрээрээ эрүүгийн хуульд заасан аль нэг гэмт хэрэгтэй тохирох боловч хуульд тусгайлан заасан учир байдал бүхий үйл ажиллагааг нийгэмд аюулгүй эрхийн эсрэг бус үйлдэл гэж үздэг”⁹ гэсэн бол профессор Г.Совд “Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг мэт боловч үйлдэл хийгчийн санаа болон бодит агуулгаараа нийгэмд ашигтай үйл явдлыг гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал гэнэ”¹⁰, Академич С.Нарангэрэл “Тодорхой этгээдэд гэм хор учруулсан боловч нийгэмд аюултай хэрэг (гэмт хэрэг) хэмээн эрүүгийн хариуцлага хүлээлгэх онцлог нөхцөл байдлыг ойлгоно”¹¹, доктор, профессор Ж.Болдбаатар “Үйлдэл, эс үйлдэхийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал гэдэгт нийгмийн эрх ашиг, харилцаанд учруулж буй аюул заналхийллийг арилгахад чиглэгдсэн нийгэмд тустай ажиллагааг ойлговол зохино”¹² гэж тус тус тодорхойлжээ.

Ийнхүү дээрх судлаачдын томъёолол тодорхойлолтыг харьцуулан үзсэний үндсэн дээр доктор, профессор С.Жанцан: “Дэлхий нийтийн эрүүгийн эрх зүйн хөгжил чиг хандлагыг иш үндэс болгон эрүүгийн

хуульд “биеийн болон сэтгэл санааны албадлага”, “Хууль биелүүлэх”, “Мэргэжлийн болон албаны үүргээ биелүүлэх”, “Хохирогчийн зөвшөөрөл” зэрэг нөхцөл байдлуудыг Эрүүгийн хуульд тусгах шаардлагатай юм”¹³ гэж тэмдэглэснийг үнэхээр шинжлэх ухааны арга зүйн үндэстэй, онол-практикийн өгөөжтэй санал гэж үзэж сайшаан дэмжиж байна.

Гэвч дээрхи томъёолол, онол нь аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болох талаас нь тайлбарласан бөгөөд бидний үзэж буйгаар “аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд нь” эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл биш харин тухайн болсон хэрэг-явдлыг чухамхүү гэмт хэрэгт тооцохгүй байх онцгой үйл явдлууд гэж үзэх нь илүү эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үндэслэлтэй мэт санагдана.

Ийнхүү аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг 2002 оноос эхлэн “Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд” гэж шинээр томъёолж ирсэн боловч энэ нь юуны өмнө логикийн талаар учир дутагдалтай мэт санагддагыг гагцхүү өөрийн үзэл бодлын үүднээс чухам яагаад ингэж үзэж байгаагийнхаа зарим үндэслэлийн талаар товчхон тайлбарлахыг хүсч байна. Үүнд:

а) Тухайн болсон (болох байсан) үйл явдлыг эрүүгийн хуульд нэгэнтээ гэмт хэрэгт тооцож тодорхойлон заасан бол

түүнийг ямар ч үндэслэлээр гэмт хэрэгт тооцохгүй байх нь зүйд нийцэхгүй мэт санагддаг тул манай Монголын өмнөх Эрүүгийн хуульд ялангуяа 1961, 1987 оны хуульд “үйл явдлын” гэж томъёолж байсан нь илүү нийцтэй, агуулгын (логик) алдаагүй байсан байж болох талтай.

б) Орос хэлээр “Обстоятельство исключающее преступность деяние” гэсэн томъёололыг “гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдал” гэсэн нь дэндүү “махчилсан” орчуулга мэт санагдана. Учир нь “исключающее преступность деяние” гэдгийг гэмт хэргийг үгүйсгэх гэж шууд хамаатуулах нь “деяние” буюу “үйл явдлын” гэсэн бодит ерген агуулгыг нь тэр болгон багтаан илэрхийлэхгүй байна. Зүй нь “деяние” гэдэг нь чухамхүү бодитой үйл явдал тэр байтугай нарийн төвөгтэй үйл явц-ажиллагаа гэдгийг онцлон илэрхийлдэгийг анхаарвал зохилтой.

Монгол Улсын Хууль зүйн яамнаас боловсруулсан Гэмт хэргийн тухай хуулийн төслөөс үзэхэд 2009 онд УИХ-ын 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 95-р заалтыг хэрэгжүүлэх үйл явцыг эхлүүлж, эрүүгийн хууль тогтоомжийн нэр томъёог нэгтгэн судалж үзсэний үндсэн дээр Монгол Улсын Эрүүгийн хуулийг Гэмт хэргийн тухай хууль гэж томъёолохоор шийдвэрлэснийг сайшаан дэмжиж байна.

⁹ Б.Содовсүрэн. БНМАУ-ын эрүүгийн эрх зүй. УБ. 1964, БНМАУ-ын эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил. УБ 1971. 90-91 дэх тал

¹⁰ Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2002, 55 дахь тал

¹¹ С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/. УБ.,

¹² Ж.Болдбаатар. Эрүүгийн эрх зүй /ерөнхий ба тусгай анги/. УБ. 2008. 61 дэх тал

¹³ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ. 2009. 668 дахь тал

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН НОТЛОХ БАРИМТЫН ОЙЛГОЛТ, АНГИЛАЛЫН АСУУДАЛ

Ж.Болбаатар

*ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн
захирал, доктор (Sc.D), профессор, цагдаагийн хурандаа*



БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх 1963 оны хуулиас Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002 онд батлах хүртэл нотлох баримтын тухай ойлголтыг хэрхэн тодорхойлох талаар онолын маргаан хүчтэй дэгдсэн. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар гэмт хэргийн нөхцөл байдлын талаар энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан баримт сэлт, мэдээллийг нотлох баримт гэнэ. Гэхдээ хууль тогтоогч баримт сэлт, мэдээлэл гэж юу болохыг тайлбарлаагүй.

Энд онолын зарим эх сурвалжаас дурдъя. Профессор Б.Бат-Эрдэнэ: “Нотлох баримт нь гэмт хэргийн талаарх баримт сэлт, мэдээлэл, хуульд заасан үндэслэлийн дагуу олж авсан баримт сэлт, мэдээлэл, хуульд заасан журмын дагуу олж авсан баримт сэлт, мэдээлэл мөн”-

хэмээн нотлох баримтын онцлог шинжийг тодорхойлжээ¹.

Профессор Д.Баярсайхан: “Нотлох баримт гэдэг нь тухайн хууль зүйн факт гэмт хэрэг мөн эсэхийг эрх зүйн хэм хэмжээний дагуу процессын арга, хэрэгслээр бүх талаар батлах буюу няцаах замаар илрүүлж, хянан тогтоосон бүхий л мэдээлэл, тэдгээрийн баримтат эх сурвалжийн нийлбэр цогц мөн”²-гэжээ.

М.А.Чельцовын үзэж байгаагаар, баримт сэлт, мэдээлэл гэдэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж тэмдгийг зааж буй материаллаг ертөнцийн үзэгдэл, өөрөөр хэлбэл, бодитоор байсан нөхцөл байдал, үйл явдал мөн³. Харин М.С.Строгович нотлох баримтыг, нэгдүгээрт, гэмт хэрэг болон эрүүгийн хэрэгт нотолбол зохих баримт, хоёрдугаарт, эдгээр мэдээллийн эх сурвалж хэмээн үзсэн байдаг⁴.

Хэдий тийм боловч бусад эрдэмтэн дээрх тодорхойлолтыг дэмжээгүй.

Нэгдүгээрт, ерөнхийд нь авч үзвэл, бодит нөхцөл байдал мөрдөн байцаалт, шүүх ажиллагааг хэрэгжүүлж буй хүнээс огт шалтгаалахгүйгээр оршиж байдаг. Тодорхой баримтыг нотолгоонд ашиглахад түүнийг хэн нэгэн хүн танин мэдэн, ухамсартаа тусгасан байх шаардлагатай. Гэмт хэргийг бүрдүүлж буй баримтыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч мэдэрч чадах уу? Үгүй. Учир нь гэмт хэрэг нотолгооны үед болж өнгөрсөн үйл явдал болсон байдаг. Хэрэв мөрдөн байцаагч гэмт хэрэг үйлдэгдэхийг харсан бол гэрч болж, түүнийг татгалзах үндэслэл бий болно. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэмт хэргийн материаллаг байдлаар үлдсэн ул мөр (цус, тээврийн хэрэгслийн мөр, баримт бичиг г.м), аль эсвэл хүмүүсийн оюун санаанд хадгалагдсан төсөөллийг л шууд хүртэж мэдэрдэг онцлогтой. Эдгээр нь баримт бус, харин тэдгээрийн тухай мэдээлэл юм⁵.

В.Я. Дороховын үзэж байгаагаар, нотолгооны зүйлд хамаарах баримт болон бусад баримтыг нотлох баримт гэж

¹ Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2004. 128 дахь тал.

² Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. УБ., 2014. 137 дахь тал.

³ Чельцов М.А. Советский уголовный процесс. М., 1962. С.132-135.

⁴ Строгович М.С. Курс советского уголовного процесса. М., Т.1. С.288-289

⁵ Карнеева Л.М. Доказательства в советском уголовном процессе. // Советский уголовный процесс. М., 1982. С.119-120



ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

үзэж болохгүй. Хүний оюун ухаанд эд зүйл биш, түүний тухай ойлголт, төсөөлөл, мэдээлэл оршиж байдаг⁶.

Хоёрдугаарт, бодит ертөнц дэх баримтыг өөрийг нь таньж мэдэх, нотлох шаардлагатай байдаг тул түүнийг нотлох баримт гэж үзэх боломжгүй.

Гуравдугаарт, материаллаг ертөнц дэх баримт нь бодитой оршин байдаг тул үнэн, аль эсвэл худал байдаггүй. Харин түүний тухай мэдээлэл үнэн, эсвэл худал байх боломжтой.

Сэжигтэн, яллагдагч гол төлөв худал мэдүүлэг өгдөг. Гэрч, хохирогч хүртэл төрөөлдөж, санаатай гажуудуулж худал мэдүүлэг өгөх явдал заримдаа гардаг.

Тэгэхээр “баримт сэлт, мэдээлэл” гэсэн нэр томъёог “баримтын тухай мэдээлэл” гэж ойлгож болохоор байна. Баримт сэлт, мэдээлэл нь эрүүгийн процессын хувьд олон төрлийн учир холбогдолтой: а/эрүүгийн процессын нотлох баримт, б/ нотолгооны хэрэгсэл, в/нотлох баримтын бүтцийн элемент, г/ баримтын тухай мэдээлэл, д/ бодит баримт.

Мэдээллийг хуульд заасан эх сурвалжаас олж авсан нөхцөлд л тэр нь нотлох баримтын хуулийн хүчин чадалтай болно гэдгийг анхаарвал зохино. Эдгээрт сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, хохирогч, гэрчийн мэдүүлэг, шинжээч, мэргэжилтний дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, мөрдөх болон шүүх ажиллагааны тэмдэглэл болон бусад баримт бичиг хамаарна.

Нотлох баримтын тодорхойлолтоос үзэхэд,

мэдээллийг хуулиар тогтоосон журмын дагуу цуглуулж, ашиглах шаардлагатай. Энэ нь нотлох баримтыг хуульд заасан аргаар тогтоосон журмын дагуу олж авч, бэхжүүлнэ гэсэн үг. Үүнээс гадна, нотлох баримтын бас нэгэн чухал чанар бол түүний тусламжтайгаар эрүүгийн хэргийг мөрдөх явцад нотолбол зохих нөхцөл байгаа эсэх, хэрэгт ач холбогдол бүхий өөр бусад нөхцөл байдал байгаа эсэхийг тогтоодог.

Ийм байдлаар, нотлох баримтын дараах шинжийг онцлох боломжтой:

1/Мөрдөж буй гэмт хэрэгтэй холбоо бүхий баримтын тухай мэдээлэл;

2/Эдгээр мэдээллийг хуульд заасан эх сурвалжаас авсан байх шаардлагатай;

3/Эдгээр мэдээллийг процессын журмын дагуу олж авч, бэхжүүлсэн байвал зохино;

4/Эдгээр мэдээлэл нь эрүүгийн хэрэгт нотолбол зохих нөхцөл байдлын талаар байх ёстой.

Дээр дурдсаныг үндэслэн дараах тодорхойлолтыг томъёолж болохоор байна:

Нотлох баримт гэдэг бол эрүүгийн хэрэгт нотолбол зохих, хуульд заасан эх сурвалжаас, тогтоосон журмын дагуу олж авсан нөхцөл байдлын талаарх аливаа мэдээлэл мөн. Эдгээр мэдээллийг үндэслэн мөрдөн байцаагч болон шүүгч хууль зүйн учир холбогдолтой баримтыг олж илрүүлэн, эрүүгийн хэргийн талаар үнэн зөв шийдвэр гаргах үүрэгтэй.

Нотлох баримтын тодорхойлолтыг үргэлжлүүлээд, мэдээлэл болон түүний эх сурвалжийн харилцан холбоог авч үзэх хэрэгтэй. Учир нь

нотлох баримтыг үнэлэхдээ түүний эх сурвалжийг давхар үнэлдэг.

Нэг талаас, нотлох баримт болон эх сурвалжийн нийлээд нэг цул эх сурвалжийг бүрдүүлдэг бөгөөд нотлох баримтыг процессын тодорхой эх сурвалжаас ангид авч үзэх боломжгүй. Энэхүү нэгдэл нь хэлбэр ба агуулгаар илэрхийлэгдэх бөгөөд эх сурвалжийг хэлбэр, харин нотлох баримтыг агуулга гэж тооцож болно. Жишээлбэл, хэргийн газрын үзлэгийн тэмдэглэлд хэрэг гарсан нөхцөл байдал, ул мөр, эд мөрийн баримт тусгагддаг. Уг тохиолдолд хэргийн газрын үзлэгийн тэмдэглэл нотлох баримтын эх сурвалж (хэлбэр), харин түүнд тусгагдсан мэдээлэл нотлох баримт (агуулга) болно. Үүнтэй мөн адил шинжээчийн дүгнэлт өөрөө-эх сурвалж, түүнд тусгасан мэдээлэл, тусгай мэдлэг бүхий хүний дүгнэлт-нотлох баримт байна. Эд мөрийн баримтын тухайд бол тухайн объект-эх сурвалж, түүн дээр байгаа ул мөр, шинж тэмдэг-нотлох баримтын үүрэг гүйцэтгэнэ.

Нөгөө талаас, нотлох баримт болон эх сурвалжийг хооронд нь зааглавал зохино. Учир нь нотолгооны үр дүнд хүрэхийн тулд мэдээллийг шалгаж, шинжлэн судалж, үнэлэх хэрэгтэй болдог. Нэг баримтын тухай мэдээлэл хэд хэдэн эх сурвалжид, эсвэл эсрэгээрээ нэг эх сурвалжид хэд хэдэн баримтын тухай мэдээлэл агуулагдаж байх боломжтой. Мэдээж хэрэг, хэд хэдэн эх сурвалжаас олж авсан нэг баримтын тухай багтай мэдлэг илүү чанартай байх нь ойлгомжтой.

⁶ Дорохов В.Я. Понятие доказательств// Теория доказательств в советском уголовном процессе. М., 1973. С. 207-211



Тэгэхээр нотлох баримт болон түүний эх сурвалж нэгдмэл хэдий ч тус тусдаа бие даасан эрх зүйн ойлголт юм.

Гэсэн хэдий ч Эрүүгийн байцаан шийтгэх хуульд уг ялгааг зааглаагүй: нотлох баримт болон эх сурвалжийг бүхэлд нь нотлох баримт гэж томъёолсон. ЭБШХ-ийн 79.2-т: Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээлэл нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны тэмдэглэл болон бусад баримтаар тогтоогдоно-гэж заасан байна.

Эндээс нотлох баримт гэдэг нь “мэдээлэл” юмуу, аль эсвэл уг мэдээллийг агуулсан процессын хэлбэр юмуу? гэсэн зүй ёсны асуулт урган гарна. Эрх зүйн өөр өөр ойлголтыг “нотлох баримт” гэсэн нэр томъёогоор илэрхийлсэнийг арга зүйн хувьд зөв гэвэл учир дутагдалтай. Тэгэхээр нотлох баримтын тодорхойлолт нэг л байвал зохино.

Уг зөрчлийг арилгахын тулд ЭБШХ-ийн 79.1-д заасан нотлох баримтын тодорхойлолтыг тэр хэвээр нь үлдээгээд 79.2-т: “...бусад баримтаар...” гэсний оронд: “...бусад эх сурвалжаар...” гэж оруулбал нотлох баримт агуулга болж, эх сурвалж процессын хэлбэр болон, дээрх 2 ойлголт өөр өөрийн байр суурийг эзлэх боломжтой болно.

Нотлох баримтын ангилал нь түүний шинж чанар, нотолгооны явцад ашиглах онцлогийг нь нээн гаргахад ач холбогдолтой. Нотлох баримтыг тусад нь болон эх сурвалжтай нь хамт ангилж болно.

1. Яллах ажиллагаатай холбоотойгоор яллах нотлох баримт ба цагаатгах нотлох баримт гэж хувааж болно.

Яллах нотлох баримт нь сэжигтэн, яллагдагчийг гэмт хэрэг үйлдсэнд нь илчилж, ял хүндрүүлэх нөхцөл байдлыг тогтоодог. Жишээлбэл, хулгайн хэргийн газраас илрүүлсэн гарын мөр сэжигтнийх мөн гэсэн шинжээчийн дүгнэлт. Энэ нь яллах нотлох баримт мөн. Түүнчлэн, 3 хүн дээрмийн халдлага үйлдсэн тухай хохирогчийн мэдүүлэг нь ял хүндрүүлэх нөхцөл байдлын тухай мэдээлэл болно. Цагаатгах нотлох баримт нь яллагдагчийг цагаатгах юмуу ял хөнгөрүүлэх нөхцөл байдлыг тогтооно. Жишээлбэл, таньж олуулах ажиллагаа явуулахад хохирогч урьд нь мэдүүлэгтээ дурдсан хүн байхгүй байна гэж мэдэгдэх. Ял хөнгөрүүлэх нөхцөл байдал гэвэл 14-18 насны хүн, өөрөөр хэлбэл насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдсэн гэдгийг тогтоосон байж болно.

2. Нотолгооны зүйлд хамааруулан нотлох баримтыг шууд нотлох баримт ба шууд бус нотлох баримт гэж ангилж болно.

Нотолбол зохих нөхцөл байдлыг шууд тогтоож буй нотлох баримтыг шууд нотлох баримт гэнэ. Тухайлбал, ослын актад тээврийн хэрэгслийн гэмтэл, засварлах өртөг зэрэг нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээг тодорхойлно /ЭБШХ-ийн 80.1.5/. Гэмт хэрэг гарсан байдлын талаарх хохирогчийн мэдүүлэг мөн шууд нотлох баримтад хамаарна. (ЭБШХ-ийн 80.1.1)

Шууд бус нотлох баримтад ЭБШХ-ийн 80-р зүйлд заасан нөхцөл байдлыг шууд бусаар тогтооход хэрэгтэй мэдээлэл орно. Шууд бус нотлох баримт нь тогтоосон үйл явдлын өмнө болж өнгөрсөн, аль эсвэл дагалдаж бий болсон баримтын тухай мэдээллийг агуулж байдаг бөгөөд тэдгээрийг үндэслэн, гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, тухайн яллагдагч гэм буруутай эсэх талаар дүгнэлт хийдэг. Жишээлбэл, хүн алах хэргийг мөрдөх явцад шууд бус нотлох баримтыг /яллагдагчийн хутгаар хүн алсан, хэргийн газарт түүний гутлын мөр олдсон, яллагдагч хохирогчтой эв түнжингүй байсан зэрэг/ үндэслэн, тухайн яллагдагч уг хэргийг үйлдсэн эсэх талаар дүгнэлт хийнэ. Зөвхөн шууд бус нотлох баримтаар нөхцөл байдлыг тогтоох нь шууд нотлох баримтыг бодвол нэлээд төвөгтэй.

3. Үүсэн бий болсон шинж байдлаас хамаарч нотлох баримт болон түүний эх сурвалжийг анхдагч ба дамжмал гэж хуваана.

Анхдагч эх сурвалжаас үүссэн нотлох баримтыг анхдагч нотлох баримт гэнэ. Тэдгээрт боловсролын баримт бичгийн эхэд буй мэдээлэл, нүдээр харсан гэрчийн мэдүүлэг, эд мөрийн баримт хамаарна. Дамжмал нотлох баримт гэдэг нь хоёрдогч эх сурвалжаас олж авсан мэдээлэл юм. Энэ нь дээд боловсролын дипломын хуулбар, нүдээр харсан гэрчээс гэмт хэргийн талаар мэдэж авсан гэрчийн мэдүүлэг байж болно.

4. Мэдээллийн эх сурвалжаас шалтгаалан нотлох баримтыг хувийн нотлох баримт ба эдийн мөрийн баримт гэж ангилна. Хувь хүнээс эхтэй нотлох



ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

баримтыг хувийн нотлох баримт гэнэ. Үүнд хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагч, шинжээч, мэргэжилтний мэдүүлэг, шинжээч, мэргэжилтний дүгнэлт хамаарна. Материаллаг эд зүйл эх сурвалж нь болдог нотлох баримтыг эд мөрийн баримт гэдэг. Гэмт хэргийн багаж зэвсэг, ул мөр бүхий эд зүйл, халдлагын зүйл, хэргийн нөхцөл байдлыг тодруулахад хэрэгсэл болж

болох бусад эд юм, баримт бичиг үүнд орно.

5. Мэдээлэл хадгалах, дамжуулах аргаас хамааруулан нотлох баримтыг тэмдэгт нотлох баримт ба тэмдэгт бус нотлох баримт хэмээн ангилж болох талтай. Мэдүүлэг, тэмдэглэл, баримт бичиг болон амаар болон бичгээр илэрхийлэгдэх ердийн болон зохиомол хэл /математик, кибернетик, логикийн томъёо/

ашигласан мэдээллийг тэмдэгт нотлох баримтад хамаарна.

Тэмдэгт бус нотлох баримт /материаллаг/ гэдэгт эд мөрийн баримт болон харьцуулах шинжилгээний загвар орно. Үүнд гар бичмэлийн чөлөөт болон туршилтын загвар, гарын хээний дардас, цус, шүлсний сорьц, сумны хошуу, хонгио, хөрсний сорьц гэх мэт хамаарна.



НИЙГМЭЭС ТУСГААРЛАХ АЛБАДЛАГА

Г.Амаржаргал

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх ажиллагааны онол, тактикийн тэнхимийн дэд профессор, магистр, цагдаагийн ахмад



Хүний эрх бол хүнээс салшгүй, заяамал бөгөөд хүн төрөлхтөний үнэт зүйл болох хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хангах явдал юм.

Эрх зүйн онолын хувьд хүний эрх, эрх чөлөө нь ямарч тохиолдолд хэмжээ хязгааргүй дур зоргыг илэрхийлдэггүй¹ бөгөөд Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах, үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалт²-нд л захирагдана³” гэжээ.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний байгууллагын гишүүн орон болохын хувьд хэд хэдэн хүний эрхийн асуудлаарх

олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон байна. Үүний нэг болох Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй, хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэхийг хориглоно, хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй, хүн бүр тунхаглалд харилах аливаа үйлдэл, ялгаварлан гадуурхах явдал, тэгээж ялгаварлан гадуурхах аливаа турхиралтаас хамгаалуулах эрхтэй⁴” гэсэн бол Монгол Улсын Үндсэн хуульд “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно⁵” заажээ.

Дэлхий нийтээр даяаршин буй энэ цаг үед Монгол улсын гадаад нэр хүнд, байр суурийг тодорхойлох шалгуурын нэг нь хүний эрхийг хангахад чиглэсэн улс төр, нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг хэрхэн бүрдүүлж буй явдал юм. Энэ баталгааг хангах явдал нь

Монгол улсад хийгдэж буй хууль зүйн салбарын шинэчлэл, түүний үр дүнгээс шалтгаалах нь амьдралд үйлдэгдсэн гэмт хэрэг, түүнийг шалгах, шийдвэрлэх ажиллагаанаас илэрхий ажиглагдаж байна. 2000 оны эхээр Монгол улсад эхэлсэн эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээний агуулагад үндэсний хууль тогтоомжийн хэм хэмжээг нийцүүлэн хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тогтолцоо бүрдүүлэх талаар чухал алхам хийсэн боловч цаашид боловсронгуй болгох асуудал байсаар байна.

Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг үндэсний хууль тогтоомжоор хангахаас гадна нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцэд зааснаар хэрэгжүүлнэ. Иймээс төрөөс чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа төрийн албадлага хэрэглэх замаар хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж болох бөгөөд гагцхүү энэ нь олон улсын хийгээд үндэсний хууль тогтоомжид заасан хязгаарлах нөхцөл бүрдсэн байхыг шаарддаг.

Үндсэн хууль болон олон улсын гэрээ, конвенцоор хамгаалагдсан хүний халдашгүй байх, эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрлөх,

¹ Х.Эрдэнэбат. Хүний халдашгүй эрх, УБ., 2002. 37 дахь тал

² Хүний эрхэд хязгаарлалт хийх гэж нийгэм, улс орон, хүний эрх, эрх чөлөө, хууль зүйн дэг журмыг хамгаалах, сахиулахын тулд тодорхой хязгаарлалт хийж болно.

³ Хүний эрх, ОУ-ын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл, НҮБ, УБ., 1992, 8 дугаар тал

⁴ Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948, 3. 5, 7 дугаар зүйл,

⁵ Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992, Төрийн мэдээлэл №1



ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

чөлөөтэй зорчих, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг эрх нь хязгаарлагддаг албадлага бол яах аргагүй цагдан хорих албадлага билээ. Энэхүү албадлагыг хэрэглэж буй өнөөгийн байдал, үндэслэл, журмын талаарх зарим асуудлыг хөндөх нь энэхүү илтгэлийн гол агуулга юм. Бид энэ чиглэлээр илтгэл бичих болсон шалтгаанаа дараах тоо баримтаар илэрхийлж байна. (График № 1)

Монгол улсад сүүлийн 5 жилийн байдлаар 106846 гэмт хэрэг бүртгэгдсэн байх бөгөөд нийт 96325 хүнийг холбогдуулан шалгажээ⁶. (График № 2)

Улсын Дээд Шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлангаас авч үзвэл сүүлийн 5 жилд нийт **3940** сэжигтэнд баривчлах, **24006** сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид цагдан хорих нийт **27946** буюу гэмт хэрэгт сэрдэгдэгсдийн **29 хувь** буюу **4 хүн тутмын нэгд** нь энэ төрлийн албадлага хэрэглэсэн гэсэн баримт байна⁷. (График № 3)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тайлан мэдээ⁸-нээс үзвэл жилд дунджаар 6600 орчим ялтан хорих ял эдлэж байна⁹. (График № 4)

Бидний тохиолдлоор авч судалсан цагдан хорих тухай 69 захирамжийн 17 нь онц хүнд, 20 нь хүнд, 31 хүндэвтэр, 1 хөнгөн гэмт хэрэгт хамаарч байна. (График № 5)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тайлан мэдээ¹⁰-

нээс үзвэл ял эдлэгсдийн дийлэнх нь хүнд, онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэн болох нь ажиглагдаж байна.

Судалгааны явцад цуглуулсан тоон үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийвэл:

1. Монгол улсад жилд дунджаар

- 21000 гэмт хэрэг бүртгэгдэж

- 19000 хүн холбогдон шалгагдаж

- 5600 хүнд баривчлах, цагдан хорих албадлага хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл практикт эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж буй 4 хүн тутмын 1 нь эрх чөлөөгөө хязгаарлуулж, нийгмээс тусгаарлагддаг байна.

2. Монгол улсад жилд дунджаар¹¹

- 6600 ялтан ял эдэлж,

- 2800 яллагдагч хорих ял шийтгүүлж, түүнийг биеэрээ эдэлж

- 2581 ялтан суллагдаж байна.

3. Монгол улсад жилд дунджаар

- Ял эдлэгсдийн 17.6 хувь нь хүндэвтэр гэмт хэрэгт ял шийтгэгдсэн байгаа бол нийгмээс тусгаарлах албадлага авагдсан этгээдүүдийн 44.5 хувь нь хүндэвтэр гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байна.

Дүгнэвэл: Эдгээр тоонууд юу илэрхийлж вэ? Дүгнэлт хийж үзвэл ял эдэлж байгаа 6600 хүнээс тухайн жилдээ суллагдаж байгаа 2500 ялтныг хасч, үлдэгдэл дээр нь хорих ялаар шийтгүүлж байгаа 2800 хүнийг нэмбэл дараагийн жилд шоронд 6900 ялтантай байх магадлалтай байна. Гэтэл бүртгэгдсэн гэмт

¹¹ 2009 онд 3074, 2010 онд 2543, 2011 онд 2781, 2012 онд 2940, 2013 онд 2522 хүн хорих ялыг биечлэн эдлэхээр шийтгэгджээ. УДШ-ийн 2009-2013 оны шүүн таслах ажиллагааны тайлан мэдээ

хэрэгт шалгагдаж байгаа 19000 хүнээс 5600 хүнд нийгмээс тусгаарлах албадлага хэрэглэсэн байгаа нь эдгээр хүмүүсийн хэд нь хорих ял шийтгэгдэж, хэд нь ХӨТЯ шийтгэгдсэн, хэдийнх нь хэрэг хэрэгсэхгүй болсон бэ? гэдэг нь бидний анхаарлыг зүй ёсоор татаж байна. Тэгэхээр бид үүнд нарийн задлан шинжилгээ хийх шаардлагатай.

Асуудал юунд байна вэ?

1. Монгол улсын ЭБШ хуулийн 58-р зүйлийн 58.1-т зааснаар сэжигтнийг "...хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа ... бол" баривчилж нийгмээс 72 цаг хүртэл хугацаагаар тусгаарлахаар хуульчилсан байна. Ийнхүү хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдсэн хүн бүрийг баривчлахыг үүрэг болгосон заалт нь үйлдсэн хэргийн нөхцөл байдал, хүний хувийн байдал зэргийг харгалзан баривчлахгүй байх хувилбарыг үгүйсгэж, үүний улмаас хүний эрх зөрчигдөх, төрийн албан тушаалтны зүгээс эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах нөхцөлийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл энэ нь явдал нь сэжигтний хувьд ЭБШ ажиллагаа хэвийн явагдах нөхцөлд саад учруулах ямар нэгэн санаа сэдэлт бий болоогүй үед ч албадлага хэрэглэх боломжийг эрх бүхий албан тушаалтнуудад олгож байна.

Дээр дурьдсан үндэслэл нь зөвхөн сэжигтнээр тооцох үндэслэл болох байтал түүнийг баривчлах эрх олгосон хуулийн зохицуулалт нь ЭБШ ажиллагааны явцад хүний халдашгүй байх эрхийг хангах, гэм буруугүйд тооцох зарчмын агуулгатай зөрчилдөж, сэжигтэнд өөрийнхөө эсрэг мэдүүлэг гаргуулахаар шахалт

⁶ ЦЕГ, Мэдээлэл судалгааны төв, Монгол улсад 2009-2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн судалгаа

⁷ УДШ-ийн 2009-2013 оны шүүн таслах ажиллагааны тайлан мэдээ

⁸ ШШГЕГ-ын 2009-2013 оны үйл ажиллагааны тайлан

⁹ Хорих байгууллагад ял эдлэж буй нийт хүмүүсийн албан ёсны тоо нь нууцлалын зэрэгтэй гэх учир тоймчлон авсан болно.

¹⁰ ШШГЕГ-ын 2009-2013 оны үйл ажиллагааны тайлан

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ. 2014. № 4 (50)




График № 1

График № 2



График № 4




График № 3





График № 5





ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

үзүүлэн, хүч хэрэглэж байгаа эрүүдэн шүүх нэг хэлбэр¹² болж байна.

Мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5-д “хойшлуулшгүй тохиолдол”-д хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг шууд баривчилж 24 цагийн дотор тогтоолыг прокурор шүүхэд хүргүүлнэ” гэсэн заалтаас сэжигтнийг баривчлах албадлагын арга хэмжээг прокурорт танилцуулалгүй, шүүгчийн захирамжгүйгээр баривчлах байранд хүргэх ажиллагааг хуульчилжээ.

Гэтэл Улсын дээд шүүхийн 2004 оны 7 тоот тогтоолоор хойшлуулшгүй тохиолдлыг хэрхэн ойлгох талаар тайлбарласан боловч энэхүү тайлбар нь сэжигтнийг баривчлах бус сэжигтнээр тооцох үндэслэл болсон байна. Түүнчлэн өөрийн үйл ажиллагааг удирдан жолоодох чадваргүй болтлоо мансуурсан, согтуурсан сэжигтнийг эрүүлжүүлэх арга хэмжээг тайлбарласан нь сэжигтний эрх зүйн байдлыг дордуулан улмаар сэжигтнээр тооцох үндэслэл байгаа тохиолдолд гэмт хэргийн ангилал харгалзахгүйгээр шүүгчийн захирамжгүйгээр шууд баривчлан эрх чөлөөг нь хязгаарлах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Санал 1: Шинээр боловсруулж буй гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөлд сэжигтнийг баривчлах албадлагыг хасах. Ингэснээр сэжигтнийг баривчлах ажиллагааг тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлох баримтаар тогтоогдож, түүнийг

мөндөх ажиллагаа явуулж буй байгууллагад хүргэх агуулгаар нь томъёолох.

2. ЭБШ хуулийн 68 дугаар зүйлд зааснаас үзвэл гэмт хэргийн ангилал харгалзахгүйгээр цагдан хорих албадлага хэрэглэх зохицуулалт тусгагдсан нь практикт хүндэвтэр гэмт хэрэгт цагдан хорих албадлагыг ихээр хэрэглэх нөхцлийг бүрдүүлж байна гэж үзэж байна.

Жишээ №1: Хүний эрхийн үндэсний комиссоос 2011 онд хөдөө, орон нутгийн баривчлах, цагдан хорих байранд хийсэн шалгалтын тайлан мэдээнд “Аймгуудын Цагдан хорих байранд цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагчийн 70 орчим хувь нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт холбогдсон хүмүүс байгаа нь ихээхэн анхаарал татлаа. Тус гэмт хэрэг нь гэмт хэргийн ангиллын хувьд хүндэвтэр гэмт хэрэгт хамаарах тул тийм гэмт хэрэгт холбогдсон хүмүүст аль болох цагдан хорихоос өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авч байх боломжтой боловч хууль тогтоогчоос хорьж болох үндэслэлийг нээлттэй байдлаар ерөнхий тодорхойлсноос болж хүндэвтэр гэмт хэрэгт холбогдсон хүмүүс ихээр хоригдох байдал харагдаж байна. Нөхцөл байдлыг газар дээр нь танилцаж явах үеэр прокуроруудаас тодруулахад “Наад хүн чинь урьд нь гэмт хэрэг үйлдэж байсан, оргочих гээд байдаг юм, гаргахаар хулгай хийчихээд байдаг юм” гэсэн тайлбарыг өгч байна гэжээ¹³.

Жишээ №2: Түүнчлэн бидний

хийсэн судалгаа¹⁴-ны объект болох 69 шүүгчийн захирамжаас үзвэл онц хүнд гэмт хэрэгт 17, хүнд гэмт хэрэгт 20, хүндэвтэр гэмт хэрэгт 31, хөнгөн гэмт хэрэгт 1 хүнд цагдан хорих ТСАХ хэрэглэжээ.

Хууль тогтоогчоос хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн тухайд өмнө авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн үндэслэл байвал цагдан хорихоор заасан. Гэтэл өмнө авсан ТСАХ-г зөрчсөн болон оргон зайлж болзошгүй гэдэгт чухам ямар үйлдлийг хамааруулах нь ойлгомжгүй мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс хэтэрхий субъектив үнэлэмжээр хандах бололцоог олгосон байна гэж үзэж байна.

Жишээ №3: Бидэнд байгаа хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчид цагдан хорих албадлага хэрэглэх тухай шүүгчийн 17 захирамжаас үзвэл “...хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, мөрдөн байцаалтаас оргон зайлж болзошгүй үндэслэлтэй байх тул сэжигтнээр цагдан хорьсугай” гэжээ.

Гэтэл эдгээр шүүгчийн захирамжийн алинд нь ч “мөрдөн байцаалтаас оргон зайлж болзошгүй үйлдэл гаргасан, түүнийг нь нотлох баримтаар тогтоосон талаар ямар нэгэн үг, өгүүлбэр тусгагдаагүй байна. ЭБШ ажиллагааны явцад үйлдэгдэж байгаа шийдвэрийг тусгасан бичиг баримт¹⁵-ын тодорхойлох

¹² Д.Зүмбэрэлхам, Монгол Улсын ЭБШ эрх зүй дэх гэм буруугүйн презумпци, УБ., 2005. 99 дэх тал

¹³ Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх удаагийн тайлан, УБ., 2012.

¹⁴ Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай түүвэрлэн авсан нийт 69 захирамжинд хийсэн дүн шинжилгээ

¹⁵ Шийдвэрийг тусгасан бичиг баримтанд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч,



хэсэгт ямар шийдвэр гаргах гэж байгаа талаар болон тухайн шийдвэрийг гаргахад нөлөөлж буй нотлох баримтын эх сурвалжийг заавал дурьдсан байхыг шаарддаг хууль зүйн шаардлага хангагдаагүй байна. Үүнээс үзвэл практикт мөрдөн байцаагч, прокурор, шүүгч субъектив үнэлэмжээр цагдан хорих албадлага хэрэглэдэг байж болох нь ажиглагдаж байна.

Санал 2: ЭБШ хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт заасан хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг зөвхөн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн” үндэслэлээр цагдан хорих албадлага хэрэглэхээр зохицуулалт хийх. Цаашлаад хууль сахиулах үйл ажиллагааны тухай, гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай, таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хуулийн төслүүдэд аль болох хүндэвтэр гэмт хэрэгт цагдан хорих албадлага хэрэглэхгүй байх бодлого барих нь зүйтэй байна.

3. ЭБШ хуулийн 68 дугаар зүйлийн 68.9 дэх хэсэгт “хөнгөн гэмт хэрэгт сэрдэгдсэн буюу хүнд өвчтэй этгээд, жирэмсэн эмэгтэй, хөхүүл хүүхэдтэй эмэгтэйн хувьд энэ хуулийн 68.2-т заасан үндэслэл байхгүй бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэхийг хориглоно” гэж заасан. Гэтэл Нэгдсэн Үндэстний Байгууллагын олон баримт бичигт, тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Токиогийн дүрэмд тодорхой хэргийг мөрдөх хийгээд нийгэм, хохирогчийг хамгаалах

зорилгоор шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулах явдлыг ЭБШ ажиллагааны онцгой арга хэмжээ болгон хүнд хэлбэрийн эрүүгийн хэрэгт хэрэглэх ёстой гэдгийг онцгойлон заасан байна¹⁶. Гэтэл манай улс нэгдэн орсон гэрээ, конвенциор хүлээсэн үүргээ үл биелүүлэн өнөөг хүртэл хөнгөн гэмт хэрэгт цагдан хорих албадлага хэрэглэх зохицуулалттай явж байгаа нь зүйд нийцэхгүй байна.

Санал 3: ЭБШ хуулийн 68 дугаар зүйлийн 68.9 дэх хэсгээс “хөнгөн гэмт хэрэгт сэрдэгдсэн буюу” гэх хэсгийг хасч, хүнд өвчтэй этгээд, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй, жирэмсэн эмэгтэйн тухайд хөнгөн гэмт хэргээс бусад ангилалын хэрэгт цагдан хорьж болохоор өөрчлөх, ингэхдээ санал 2-т дурьдсан агуулгыг харгалзах

4. Судалгааны явцад ажиглагдсан нэг зүйл бол иргэдийн эрх зүйн боловсрол. Хүний халдашгүй эрхийг бодитойгоор хамгаалдаг улс орнуудад сэжигтэнг баривчилж, цагдан хорихдоо иргэнд тодорхой эрхийг нь мэдэгдэж, өмгөөлөгчид нь урьдчилан хэлсний дагуу цагдан хорьдог. Мөн өөрийг нь ямар асуудлаар хорьж байгааг хэлж тодорхой үндэслэлийн дагуу цагдан хорьдог жишиг олон улсад мөрдөгддөг. Гэвч манай процесст бодит байдал дээр хуульд заагаагүй үндэслэлээр хүнийг цагдан хорих, хуульд заасан эрхүүдийг нь тайлбарлаж өгөхгүйгээр цагдан хорьж, мөрдөн байцаалтын тодорхой арга болгож хэрэглэж ирсэн зүй бус хандлага хэвээр байна. Өөрөөр хэлбэл хэрэг бүртгэгч,

мөрдөн байцаагч нь ЭБШ хуулийн 187 дугаар зүйлийн 187.1 дэх хэсэгт зааснаар ЭБШ ажиллагааны оролцогчдод эрх, үүргийг нь заавал тайлбарлан өгнө гэж байгаа боловч практикт энэ нь ёс төдий хийгддэг, өөрөөр хэлбэл сэжигтэн, яллагдагчийн эрх, үүргийг өөрөөр нь уншуулах, эсхүл уншиж өгөх гэхээсээ илүүтэй хэвлэмэл байдлаар гаргаж, түүнийгээ танилцуулдаг журам тогтсон нь сэжигтэн, яллагдагчаас ойлгоогүй зүйлээ асуух, ямар үйлдлийн улмаас ямар үр дагаварт хүрч болох тухай ямар нэгэн ойлголтгүй хэвээр байсаар байна. Ийм нөхцөл байдлын улмаас тухайн сэжигтэн, яллагдагч оргон зайлж болзошгүй эсхүл оргон зайлсан гэх үйлдэлд орж, эрхээ хязгаарлуулах, нийгмээс тусгаарлуулах явдал байсаар байна.

Жишээ №4: Анхан шатны ... дугаар шүүхийн шүүгчийн 123 дугаар захирамжинд “... шүүгдэгч Ц.Ч нь урьд оршин суух газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авсан боловч шүүхийн дуудсан цагт ирэх үүргээ биелүүлээгүй тул түүнд урьд авсан ТСАХ-г өөрчилж, цагдан хорих ТСАХ-г авсугай” гэжээ.

Санал 4: Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэсэн төрийн чиг үүргээс үүрэлцэж, хэрэгжүүлэх зорилгоор иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хэрхэн хамгаалж болох талаар тодорхой мэдлэгтэй болгох

¹⁶ Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх удаагийн тайлан, УБ., 2012.



ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

чиглэлд анхаарч ажиллах.

Дээрх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчээс албадлага хэрэглэхдээ алдаа гаргаж байгааг дараах шалтгаантай байна гэж үзлээ.

Үүнд:

- Эрх зүйн зохицуулалт муу
- Мэргэжлийн санаатай болон болгоомжгүй алдаа гаргадаг
- Хувийн субъектив хандлага, үнэлэмж

- Хүн ам зүйн проблем / хаягтай, хаяггүй байдал гэх мэт/

- Улс төрийн нөлөөлөл гэх мэт.

Иймээс цаашид хүний халдашгүй байх эрхийг хязгаарлаж явагддаг нийгмээс тусгаарлах албадлагыг хэрэглэх процедур, эрх зүйн үндэслэлийг тодорхой болгохын тулд дээр дурьдсанаас гадна дараах арга хэмжээг авах нь хүний эрхийг баталгаатай эдлүүлэх боломжийг бий болгоно гэж үзэж байна.

Санал 5: Шүүхээс нийгмээс тусгаарлах албадлагын арга хэмжээг авах, сунгах хүсэлтийг шийдвэрлэхдээ прокурор, өмгөөлөгчийн тайлбар, хүсэлтийг сонсох, мэтгэлцэх нөхцөлөөр хангах, холбогдох нотлох баримтыг шинжлэн судлах, хууль ёсны нотлох баримтын хүрээнд хуульд заасан үндэслэлээр шийдвэр гаргах ингэхдээ ямар нотлох баримтын эх сурвалжаар энэ төрлийн албадлага хэрэглэж байгааг заавал дурьдах зэрэг болно.



КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ**ЦУСАНД УГААРЫН ХИЙ ТОДОРХОЙЛОХ
ШҮҮХ-ХИМИЙН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АСУУДАЛ***Б.Аюушбаатар**ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Шинжлэн
магадлахуйн тэнхимийн ахлах багш*

Монгол орон цаг уурыннөхцлийн хувьд эрс тэс уур амьсгалтай бөгөөд энэхүү онцлогоос шалтгаалан сүүлийн жилүүдэд зарим төрлийн гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь цөөн хүн амтай манай орны хувьд тулгамдсан асуудал болоод байна.

Анх 1776 онд Lассон цинкийн оксид буюу модны нүүрсийг шатааж угаарын хийг гаргаж авсан.

1857-онд Bernard цусанд угаарын хий нэгддэг болохыг нээсэн. Оросод 1864 онд П.Р.Покровский, 1866-онд И.П.Главацкий, 1880 онд П.И.Грязнов нар хүмүүсийн угаарын хийн хордлогыг судалжээ.

Г.Ф.Ланг 1939 онд анх цусны тогтолцоо гэдэг ойлголтыг дэвшүүлсэн. Цус нь хүнийг тэжээн тэнхрүүлэгч хамгийн гол шингэн юм. Цус нь тухайн амьд биеийг мэдрэлийн болон дотоод шүүрлийн булчирхайн тогтолцоогоор бодисын солилцоо явуулах нөхцлийг бүрдүүлдэг.

Солилцооны үр дүнд үүссэн энгийн нийлмэл бодисыг өөртөө агуулж бие махбодийг тэжээгч болдог. Цус нь хүний бие махбодид бодисын солилцоо эрчимтэй явагддаг тул 37-40°C-н температуртай байдаг.

Цусны эритроцитын /улаан эсийн/ найрлага дахь гемоглобин уураг уушигнаас хүчилтөрөгчийг /O₂/ нэгдүүлэн оксигемоглобин хэлбэрээр цусаар дамжуулан эд, эсэд хүргэж исэлдэн ангижрах урвалын үр дүнд үүссэн нүүрсхүчлийн хийг /CO₂/ нэгдүүлэн карбоксигемоглобин хэлбэрээр цусаар дамжуулан уушгинд хүргэж тэр нь амьсгалын замаар гадагшилдаг. Өөрөөр хэлбэл энэ 2 хийн солбицон зөөгдөх үйл явцыг амьсгалах гэнэ.

Цус хоол боловсруулах эрхтнүүдийн ханаар шимэгдэн аминхүчил, нуклеотид, витамин, эрдэс бодисууд, глюкоз, өөх тос зэрэг бодисыг эд, эсэд зөөвөрлөн хүргэснээрээ тэжээлийн үүрэг гүйцэтгэдэг.

Цус нь эрхтэн, эд эсэд үүссэн исэлдэн ангижрах биоурвалын эцсийн бүтээгдэхүүн болдог. Эцсийн бүтээгдэхүүнийг уушиг, бөөр арьс, бүдүүн гэдсэнд хүргэн ялгаруулах үүрэг гүйцэтгэдэг.

Цусны дүрст элементүүд, сийвэнд агуулагдах уургууд бие махбодийг хамгаалах янз

бүрийн урвалд оролцоно. Цусны цагаан эсүүд нь олон төрлийн нян вирусыг устгах, тэдгээрийн антиген шинж чанартай уургуудыг саартагжуулах зэрэг бие махбодийн өвөрмөц ба өвөрмөц бус урвалд дархлалын урвалд оролцдог. Цусны урсгал нь төв мэдрэлийн тогтолцооны удирдлагад ажиллаж эд, эс, эрхтэн хооронд солилцоог зохицуулдаг.

1937 онд Гизелиус электрофорезийн аргаар цусны ийлдсэнд агуулагдах уургийн бүлгийн анх ялгасан. Гемоглобин гэдэг нь цусанд агуулагдах нь уураг юм.

Цусны өнгө нь улаан эсийн дотор агуулагдах гемоглобинтой холбоотой байдаг. Улаан эсийн хий тээвэрлэх үүргийг гемоглобин гүйцэтгэдэг.

Гемоглобин нь төмөр агуулсан гема ба глобин уургаас тогтсон хромопротеин юм. Хүчилтөрөгчтэй нэгдсэн гемоглобиныг оксигетоглобин /HbO₂/, хүчилтөрөгчөөсөө салсан гемоглобиныг ангижрсан гемоглобин, CO₂-той нэгдсэн гемоглобиныг карбогемоглобин /HHbCO₂/ гэж нэрлэдэг.

Гемоглобин нь угаарын хий /CO₂/-той маш амархан нэгддэг. Энэ нэгдлийг Карбоксигемоглобин /HHbCO₂/ гэж нэрлэх ба маш бат нэгдэл юм. Карбоксигемоглобин нь бие



КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

махбодид ихээр үүсэхэд хүний бие махбодь хүчитөрөгчийн дутагдал үүсч үхэлд хүргэх аюултай юм. Цусан дахь гетоглобин 60-70% угаарын хийтэй холбогдвол үхэлд хүргэх аюултай. Эмэгтэй хүн болон 2 нас хүртэлх хүүхэд насанд хүрсэн эрэгтэй хүнийг бодвол илүү тэсвэрлэдэг.

Угаарын хийн хордлогын хэд хэдэн хэлбэр байдаг. Цусан дахь карбоксигетоглобины хэмжээ 80%-иас дээш бол цахилгаан хэлбэр бөгөөд энэ үед шууд ухаан алдаж, булчингийн ширхэгүүд таталдаж, хурдан хугацаанд амьсгал зогсоно. Удааширсан хэлбэр нь хөнгөнөөс хүндрэх замаар явагддаг. Энэ үед булчин сулрах, ялангуяа хөл сулрах, толгой эргэх, чих шуугих, огих, бөөлжих, нойрмог болох, барижаагаа алдах хэлбэрээр илэрнэ. Ингээд хордлого нэмэгдэхийн хэрээр хөдөлгөөний тэнцвэр алдагдах, ухаан алдах таталт өгөх, солилдох хий юм үзэх амьсгалын төв саажсанаас үхэлд хүргэдэг. Амьсгал зогссоноос хойш 2-8 минутын дараа зүрх зогсдог. Хурц хордлогоор нас барсан үед арьс салст нь хурц ягаан өнгөтэй болсон байдаг. Дотор эрхтнүүд, булчин, хүүрийн толбо ч ийт өнгөтэй байдаг. Төв мэдрэлийн системд ихээхэн өөрчлөлт илрэх ба үүнд тархины эд ба зөөлөн бүрхүүл хавантай, цус дүүрэлттэй, тархины бор гадаргын эс хувиралтай болсон байдаг. Зүрх болон бусад дотор эрхтэнд цус харвана.

Сүүлийн жилүүдэд гэртээ болон автомашин, граждаа угаартах, бусдыг санаатай алах гэмт хэргийн галдан шатаах, угаартуулах аргаар үйлдэх тохиолдол нэмэгдэх хандлагатай

байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн химийн лабораторид угаарын хий тодорхойлох шинжилгээг хуулийн эрх бүхий байгуулгын тогтоол, шийдвэр, шинжээч эмчийн дагалдах бичгээр дүгнэлт гаргаж байна.

Угаарын хий / %/-р гаргадаг. Энэ төрлийн карбоксигемоглобин/ нь шинжилгээг улсын хэмжээнд харьцангуй тогтвортой, зөвхөн манай лабораторид диссоциад муу ордог янз хийгддэг.

бүрийн химийн нэгдэлтэй урвалд орохгүй, цусны өнгө хувирдаггүй чанарыг үндэслэн цусан дахь химийн чанарыг үндэслэн цусан дахь угаарын хийг чанарын сорилуудаар илэрвэл UNICO-7200 спектрофотометрийн багажаар тоон хэмжээг тодорхойлж гаргадаг. Энэ төрлийн шинжилгээг улсын хэмжээнд зөвхөн манай лабораторид хийгддэг.

Угаарын хийн хордлогын шинжийг дараах хүснэгтээр харуулвал

Угаарын хийн процент	Хордлогын шинж
0-10	Ямар ч өөрчлөлт шинж өгөхгүй.
10-20	Толгой судасны лугшилт мэдрэгдэж толгой бага зэрэг өвдөнө, арьсан дээр судас өргөсөж тодорно.
20-30	Толгой өвдөнө. Чамархайд судасны цохилт мэдрэгдэнэ.
30-40	Толгой хүчтэй өвдөнө, бие суларна, толгой эргэнэ, нүдний урдуур манан тана, огих, бөөлжих шинж тэмдэг өгнө.
40-50	ухаан балартана, Амьсгал, судасны цохилт нэмэгдэнэ.
50-60	Амьсгал, судасны цохилт бүр нэмэгдэнэ. Комд орно. Давтамжтайгаар таталт өгнө.
60-70	Амьсгал судасны цохилт сулрана. Амьсгал зогсоно. Үхэлд хүрнэ.

Дээрх шинжилгээ нь манай химийн лабораторийн 10-15 % эзэлдэг. Сүүлийн 5 жилд хийгдсэн шинжилгээний тоог харуулбал:

2009-2013 онуудад химийн лабораторид угаарын хий / карбоксигемоглобин/ тодорхойлох шинжилгээнүүдийг хүснэгтээр харуулвал

Он	2009	2010	2011	2012	2013
Шинжилгээний тоо	50	65	29	65	50

2009-2013 онуудад хийгдсэн угаарын хий / карбоксигемоглобин /-д хордсон хүмүүсийг насаар нь хүснэгтээр харуулвал

Он	2009	2010	2011	2012	2013
0-16	11	11	4	16	6
17-35	20	32	11	25	15
36-50	11	14	9	14	20
50-с дээш	8	8	4	10	9
Нийт	50	65	28	65	50



2009-2013 онуудад хийгдсэн угаарын хийд хордож нас барсан хүмүүсийг хүйсээр хүснэгтээр харуулвал

Он	2009	2010	2011	2012	2013
Эрэгтэй	31	39	18	45	37
Эмэгтэй	19	26	11	20	13
Нийт	50	65	28	65	50

2009-2013 онуудад хийгдсэн угаарын хийд хордож нас барсан хүмүүсийг хэргийн болсон байдлаар хүснэгтээр харуулвал

Он	2009	2010	2011	2012	2013
Гэртээ	41	51	25	49	40
Ажил дээрээ	0	5	0	2	3
Машиндаа	3	5	0	9	6
Граждаа	3	3	1	2	1
Траншейнд	0	1	1	2	0
Хог дээр	2	0	0	1	0
Худаг	1	0	0	0	0
буудалд	0	0	0	0	0
Нийт	50	65	28	65	50

2009-2013-онуудад согтуугаар угаартаж нас барсан байдлыг харьцуулж хүснэгтээр харуулвал

ОН	2009	2010	2011	2012	2013
НИЙТ	50	65	28	65	50
Гэртээ	19	20	16	20	16
Ажил дээрээ	0	0	0	0	1
Машиндаа	3	0	0	2	4
Граждаа	0	1	1	2	0
Траншейнд	0	1	1	2	0
Хог дээр	0	0	0	1	0
Худаг	1	0	0	0	0
Буудалд	0	0	1	0	0
Согтууруулах ундаахэрэглэсэн Нийт, хувиар	23 46%	22 33.8 %	19 67%	27 41%	21 42%

Энэхүү судалгааны үр дүнд Монгол хүний угаарын хийд хордох буюу түүний улмаас амь насаа алдах тоон үзүүлэлт анх удаа тогтоогдох боломжтой болж байна. Тухайлбал, химийн лабораторид хийгдсэн нийт шинжилгээний тоог сүүлийн 5 жилээр гаргаж харьцуулж, болсон хэргийн байдал, нас, хүйс, архи согтууруулах ундаа хэрэглэсэн байдал зэргээр судалгаанд тусгаж оруулав.

Цаашид орчин үеийн шинжилгээний арга аргачлал, өндөр мэдрэмжит техник хэрэгсэл зэргийг нэвтрүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна.



ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ГАЛТ ЗЭВСЭГ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ЭРХ
ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Ш.Чулуун

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн ахлах багш, цагдаагийн хошууч

Цагдаагийн байгууллага нь түүхэн хөгжлийнхөө явцад өөрийн үндсэн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолдалбаны зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэн ирсэн бөгөөд тухайн цаг үеийнхээ нийгмийн нөхцөл байдалтай уялдан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж шинэчлэгдэн улам боловсронгуй болж ирсэн байна.

Үүнийгээ дагаад цагдаагийн байгууллага, албан хаагчаас албаны зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх эрх зүйн зохицуулалт, үндэслэл журам өөрчлөгдөн шинэчлэгдэж олон улсын жишигт нийцсэн зэвсэг, тусгай хэрэгслийг цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Цагдаагийн байгууллагаас галт зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх талаарх хууль

тогтоомжид дор дурдсан байдлаар шинэчлэгдэн боловсронгуй болж ирсэн.

Зэвсэг, тусгай хэрэгслийг Чингис хааны үед Их монгол улсын нийгмийн хэв журам сахиулах, харуул хамгаалалтын үүргийг гүйцэтгэж байсан торгон цэрэг, хорчин цэрэг ашиглаж байжээ. Энэ тухай “Монголын нууц товчоо”-д бичигдэн үлдсэн байна. Тухайлбал, “Чингисийн алтан ургаас бүрдсэн түүний хамгаалалтын алба зэр зэвсгээ агсан өдрийг өдөр гэлгүй шөнийг шөнө гэлгүй хараа цавчилгүй хамгаалж байв”¹ гэжээ.

Монголын цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа зэвсэг, тусгай хэрэгсэл ашиглаж байсан талаар бусад түүхийн дурсгалт бичгүүдэд олонтой бичигджээ.

Монгол Улс манжийн эзэмшлээс чөлөөлөгдсөн үеэс эхлэн цэрэг, цагдаагийн үндэсний албатай болж тухайн үед төрийн цагдаагийн байгууллага зэвсэг, тусгай хэрэгсэл хэрхэн хэрэглэж байсан, ялангуяа цагдаагийн шинэ түүх эхэлсэн 1921 оны ардын хувьсгал ялснаар манай улсын нийгэм, улс төрийн тогтолцоо шинэчлэгдэж

¹ Монголын нууц товчоо. УБ., 2004.198 дахь тал

төрийн цагдаагийн байгууллага байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн үеийн цагдаагийн байгууллагаас эхлэн өнөөг хүртэл цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх асуудал нь цагдаагийн захиргааны үйл ажиллагааны арга, хэлбэрт хамаарч хөгжиж ирсэн талаарх түүхийн баримт материалуудыг судалсан.

Монгол Улсын олноо өргөгдөсний 6 дугаар оны 12 дугаар сарын 30-нд /1916 он/ Богд хаан лүндэн буулгаж төрийн цагдаагийн алба байгуулан «Нийслэл хүрээний тойрон газруудыг цагдан сэргийлэх дүрэм хэмжээ»-г батлан гаргасан бөгөөд уг дүрмийн 3 дугаар зүйлд: “Нийслэл хүрээг цагдан сэргийлэх газрын алба хаагчдад өөр өөрийн тусгай албаны хувцас өмсөж, зэвсэг бариулан цагдан сэргийлнэ”, мөн 12 дугаар зүйлд: “Цагдан сэргийлэгчид Нийслэл хүрээний газраа ... цуглагсдын дотор цаазласнаас зөрчиж хэрэлдэн шуугилдах ... муу самуун гэм гаргахад хүргэх аваас ... дарангуйлан зогсоосугай”² гэсэн нь үйл ажиллагаандаа зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэж

² Д.Таванжин. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт. УБ., 2000. 12 дахь тал



байсныг харуулж байна.

Ардын хувьсгал ялснаас хойшхи үеийн цагдаагийн байгууллагын зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалт нь дор дурдсан эрх зүйн актуудад дараах байдлаар тусгагдан иржээ. Үүнд:

1921 оны 07 дугаар сарын 19-нд Засгийн газрын 6 дугаар хурлаар цагдаагийн асуудлыг хэлэлцэж, Цагдан сэргийлэх байгууллагыг Цэргийн яамны бүрэлдэхүүнд “Сэргийлэх цэрэг” нэртэйгээр байгуулж зэвсэг хэрэглэх, жагсаал ёслолын цэрэгжүүлсэн сургууль хийлгэж байсан талаар баримт байгаа нь цагдаагийн байгууллагыг байгуулсан цагаас зэвсэг, тусгай хэрэгсэл хамт хөгжиж ирсний жишээ баримт юм.

1923 оны 6 дугаар сард батлагдсан “Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хорооны дүрэм хэмжээ”-ний 21 дүгээр зүйлд: Өдөр шөнийн цаг дор аливаа хүн учир явдал сэжиглэлтэйгээр явах буюу эсвэл буу зэвсэг ба сэжиг бүхий юм зүйлийг авч явахыг сайтар хянан байцааваас зохимой.

22 дугаар зүйлд: Аливаа харилцан хэрэлдэн шуугилдагчид буй аваас даруй ятган тарваас зохимой. Хэрэв хэрэгсэхгүй ноцолдон жанчилдахуй дор хүрвээс даруй барьж, цагдан сэргийлэх хороон дор хүргүүлэн хянан шийтгүүлвээс зохимой.

31 дүгээр зүйлд: Харьат хорооноос морьт явган цагдаа, цэргүүд манаа харуулын зэрэг ноогдсон албыг сайнаар гүйцэтгэж буй үгүйг цаг бүр хянан байцааваас зохимой гэж заажээ. Энэ нь цагдаагийн зэвсэг хэрэгсэл хэрэглэх заалтад хамаарахгүй ч зэвсгийн талаар заасан анхны заалт юм.

БНМАУ-ын 1926 оны 1 сарын 15-ны өдөр батлагдсан **«Цагдан сэргийлэх газрын дүрэм»**... зэвсэг бүхий этгээд хууль цаазыг зөрчих, манаж буй объект уруу халдан довтлох үед өөр аргагүй бол цагдан сэргийлэхийн ажилтан зэвсэг хэрэглэхийг зөвшөөрөх” гэх мэт урд дүрэмд байхгүй заалтууд шинэ зүйл болон орсон байна.³ Мөн уг дүрмийн 9-р бүлгийн 70-р зүйлд зааснаар: Цагдан сэргийлэгчид аливаа цагдан сэргийлэх явдлыг гүйцэтгэхдээ буу зэвсэг хөдөлгөн хэрэглэх боловч юуны өмнө зэвсэг хөдөлгөхгүйг ихэд бодолцвоос зохих тул хэрэв хэрхэх аргагүй онц чухал хэрэг учир тохиолдох аваас буу зэвсэг хэрэглэж болох үндэслэлүүдийг тусгайлан заажээ.⁴

1928 оны 1 сарын 28-ны өдөр батлагдсан “Цагдан сэргийлэх газрын дагаж явах дүрэм”⁵-ийн 16 дугаар зүйлд: Харьат цагдаа, цэргийн албыг хаагчид дор винтов ба гар буу, сэлэм зэргийг Цэргийн явдлын яамнаа мэдүүлэн ойлгуулж хэрэглүүлбээс зохимой. **Үүнд нэмэн тэмдэглэх нь:**

Харьяат цагдаа цэргүүд албаны ил буу зэвсэг, хувцас хунар зүйлийг цаг үргэлж арчиж цэвэрлэх ба маш хямгатайгаар хэрэглэх явдлыг цэргийн дүрмийн ёсоор явуулмаас зохимой.

17 дугаар зүйлд: Харьат цагдаа цэргүүд дор улсын суртал ба цэргийн сургууль хийгээд мөн цэргийн хүмүүсийн сахин дагах дүрэм журам зэргийг эрх биш таниулан боловсруулбаас зохих учираа харьяат эрхлэгчдээс эрхлэн удирдах сургаж боловсруулсаар байваас зохимой гэж заасан нь зэвсэг,

тусгай хэрэгслийн талаар анхлан дүрэмд орсон чухал заалтуудын нэг юм.

Мөн энэ дүрмийн 9 дүгээр бүлэгт⁶ “Буу зэвсэг хэрхэн хэрэглэх тухай”

52 дугаар зүйлд: Цагдан сэргийлэгчид аливаа цагдан сэргийлэх явдлыг гүйцэтгэх дор буу зэвсгийг хөдөлгөхгүйг ихэд болгоомжилвоос зохихын тул хэрэв хэрхэх аргагүйн онц чухал хэрэг учир тохиолдох аваас буу зэвсэг хэрэглэж болох зүйлүүдийг жагсаасан нь:

Нэг. Аливаа буу зэвсэг бүхий хулгайч, дээрэмчин лүгээ тулалдаж барих,

Хоёр. Аливаа буу зэвсэггүй боловч олноор эсхүл ганц хүн хүчирхэн эсэргүүцэж хэрхэвчээр зогсоох аргагүй хүний амь бие дор аюул хорлол хүргэх этгээд тохиолдох

Гурав. Гяндангаас оргосон буюу хүнд ялтныг барихуй дор тэд нар эсэргүүцэх буюу гүйцэхгүй дор хүргэх

Дөрөв. Олон хүн бүлэглэж, улсын хууль цаазыг зөрчих бөгөөд буу зэвсэг хэрэглэж эсэргүүцэх

Тав. Аливаа хүмүүс гянданд хоригдож буй ялтныг суллаж гаргахыг хичээж, албаны манаач, цагдаа цэргүүд дор шууд тулж орох

53 дугаар зүйлд: Цагдан сэргийлэгчид үүнээс дээш заасан зүйлүүд дор буу зэвсэг хэрэглэхүй дор хэргийн байдлыг сайтар хянаж завдан бүхий дор урьдаар мэдээ болгон дээгүүр буудах ба шууд алахгүйгээр хүчин мөхөөхийг хичээвээс зохимой гэж заасан байна.

БНМАУ-ын 1934 оны 2 дугаар сарын 2-ны өдөр баталсан **“Цагдан сэргийлэхийн тухай дүрэм”-ийн 23-р зүйлд:**

⁶ Мөн тэнд 57 дахь тал

³ Мөн тэнд 36 дахь тал

⁴ Мөн тэнд 45 дахь тал

⁵ Мөн тэнд 52 дугаар тал



Цагдан сэргийлэхийн гүйцэтгэх жагсаалын ба захирах тушаах хийгээд аж ахуйн ажилчид нь албан ажлыг цагийг албан тушаалын ялгаврын тэмдэг бүхий тогтмол жагсаалын хувцсыг өмсөхөөс гадна өөр өөрийн тушаал дор ноогдуулсан буу зэвсгийг зүүж явбаас зохино гэсэн нь тухайн үед албан хаагчид зэвсгийг албан үүргээ гүйцэтгэх үедээ ашиглаж байсан байна.

1955 оны 03-р сарын 29-ны өдөр батлагдсан БНМАУ-ын Дотоод явдлын яамны харъяа «Улсын цагдан сэргийлэхийн дүрэм»-ийн 16-р зүйлд: Улсын цагдан сэргийлэхийг зэвсэг, хувцас, эд хэрэглэгдэхүүн, шинжлэх ухаан техникийн хэрэгсэл зэрэг бусад эд хогшлоор хангах явдлыг Дотоод явдлын яамнаас төвлөрсөн журмаар гүйцэтгэнэ. Морь ба албаны нохойн тоо, тээврийн хэрэгсэл мөн зэвсэг техникийн болон бусад эд хогшлын жагсаалтыг Дотоод явдлын яамны сайдаас тогтооно.⁷ гэж тусгасан байна.

1963 оны 10-р сарын 25-нд батлагдсан БНМАУ-ын «Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм»-ийн 15-р зүйлд: Цагдаагийн алба хаагчийн зэвсэг хэрэглэх үндэслэл журмыг тодорхой заасан байна.⁸ Үүнд:

- Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан нарын албан үүргээ гүйцэтгэж байгаа үед нь бусдаас бүлэглэх буюу буу зэвсэг, бусад хэрэгслийг ашиглан, илтээр халдан довтолж, амь насанд аюул учруулахад хүрвэл

- Нэг этгээдийн гэмт үйлдэл нөгөө этгээдийн амь насанд нь аюул учруулж байгаа бол
- Баривчлагдсан /насанд хүрсэн/ этгээд харуул хамгаалалтаас оргож зугтаавал тус тус хэрэглэж болно гэжээ.

Тайлбар: Дээр дурдсан бүх тохиолдолд зэвсэг хэрэглэх нь гэмт үйлдлийг гаргахгүй байлгах талаар бусад бүх бололцоот арга хэмжээг урьдчилан авсны дараа сая хэрэглэж болно. Халдан довтолж аюул нэгэнт өнгөрсөн буюу хэлмэгдэгч этгээдийн амь насанд бодит аюул болж чадахгүй болсны дараа, эсвэл халдан довтолсны хорт уршиг /үхэл/ тохиолдсоны дараа зэвсэг хэрэглэж болохгүй.

«Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм»-ийн 16-р зүйлд: Гэмт хэрэг үйлдсэн буюу нийтийн хэв журам зөрчсөн этгээд засгийн төлөөлөгч болон нийтийн хэв журам сахиулагч хүмүүсийн шаардлагыг биелүүлэхгүй харин онцгой догшин авирлаж, танхай балмад зан гарган аашилбал хуулийг үндэслэн номхотгох цамц, гав, бусад номхотгох аргыг хэрэглэж болно. Улсын цагдан сэргийлэн байгууллага нь мөнгөн хөрөнгө, орон сууц, хувцас хунар, буу зэвсэг, галт хэрэгсэл, холбооны ба тээврийн хэрэгслээр Нийгмийн аюулаас хамгаалах яамнаас төвлөрсөн журмаар хангагдана гэж заагдсан байна.

1985 оны 03-р сарын 29-нд батлагдсан БНМАУ-ын «Цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай» БНМАУ-ын

АИХ-ын тэргүүлэгчдийн зарлиг гарч түүнд цагдан сэргийлэх байгууллага, алба хаагч зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх талаар томоохон заалт орсон байна. Тодруулбал: БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн **1985 оны 96 дугаар зарлигийн 8-р зүйлд:** Зөвхөн албадан саатуулж, цагдан хоригдож байгаа буюу захиргааны журмаар баривчлагдсан этгээд хэрцгий догшин авирлах, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнийг барих, хуяглан хүргэх, гэмт хэрэгтэн оргохыг завдах зэрэг онцгой тохиолдолд гав, номхотгох бусад хэрэгсэл хэрэглэх эрх эдэлнэ гэж заажээ.⁹

Энэ нь зэвсэг, тусгай хэрэгслийг онц чухал үед хэрэглэх тухай нарийн дэг журам, эрх зүйн зохицуулалттай байсныг гэрчилж байна. Номхотгох хэрэгслийн жагсаалт, тэдгээрийн хэрэглэх нөхцлийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс тодорхойлсон журмын дагуу тогтооно гэжээ.

Мөн **1985 оны 96 дугаар зарлигийн 10-р зүйлд:** Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан нь улс, нийгмийн хууль ёсны ашиг сонирхол, нийгмийн хэв журам, социалист өмч, иргэдийн амь бие, эрхийг гэмт халдлагаас хамгаалах албан үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай дор дурдсан онцгой тохиолдолд эцсийн арга хэмжээ болгож зэвсэг хэрэглэх эрхийг тодорхой тусгасан байна.¹⁰ Үүнд:

- Иргэдийн амь бие буюу эрүүл мэндэд шууд заналхийлсэн довтолгооноос түүнийг өөр арга хэрэгслээр хамгаалах боломжгүй бол

⁷ Мөн тэнд 82 дахь тал

⁸ Д.Таванжин. Монголын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан эрх зүйг зохицуулалт түүний хөгжилт. УБ., 2000. 92 дахь тал

⁹ Мөн тэнд 105 дахь тал

¹⁰ Мөн тэнд 105 дахь тал



- Онц чухал, бусад чухал объектод халдсан зэвсэгт довтолгоог таслан зогсоох
- Цагдан сэргийлэх байгууллагын ажилтны амь биед шууд аюул учруулсан, түүнчлэн цагдан сэргийлэх байгууллагын хуяглан хамгаалалтад халдсан довтолгоог өөр аргаар таслан зогсоох боломжгүй бол
- Зэвсэг хэрэглэн эсэргүүцэж байгаа буюу онц аюултай гэмт хэрэг үйлдсэн, мөн урьдчилсан мөрдөн байцаалт, шүүх, хорих газраас оргосон /эмэгтэй болон насанд хүрээгүй хүнээс бусад/ гэмт хэрэгтнийг өөр арга хэрэгслээр барих боломжгүй бол

Зэвсэг хэрэглэсэн тухай бүр протокол үйлдэж прокурорт нэн даруй мэдэгдэнэ. Зэвсэг хэрэглэх журмыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс тодорхойлсон журмын дагуу тогтооно.

1985 оны 04-р сарын 26-нд батлагдсан БНМАУ-ын «Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм»-ийн 19-р зүйлд: Албадан саатуулагдаж, цагдан хоригдож байгаа буюу захиргааны журмаар баривчлагдсан этгээд хэрцгий догшин авирлах, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнийг барих, хуяглан хүргэх, гэмт хэрэгтэн оргохыг завдах зэрэг онцгой тохиолдолд номхотгох тусгай хэрэгсэл хэрэглэнэ. Номхотгох тусгай хэрэгслийн жагсаалт, тэдгээрийг хэрэглэх журмыг Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайд, Улсын прокурорын зөвшөөрснөөр батална гэж заажээ.¹¹

¹¹ Мөн тэнд 119 дүгээр тал

Мөн БНМАУ-ын “Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм”-ийн 20-р зүйлд: Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан нь улс, нийгмийн хууль ёсны ашиг сонирхол, нийгмийн хэв журам, социалист өмч, иргэдийн амь бие, эрхийг гэмт этгээдийн халдлагаас хамгаалах албан үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай дор дурдсан онцгой тохиолдолд эцсийн арга хэмжээ болгож зэвсэг хэрэглэх эрхийг хуульчлан заасан байна.¹² Үүнд:

- Иргэдийн амь бие буюу эрүүл мэндэд шууд заналхийлсэн довтолгооноос түүнийг өөр арга хэрэгслээр хамгаалах боломжгүй бол
- Сайд нарын Зөвлөлөөс баталсан жагсаалтад заасан онц чухал, бусад чухал объектод халдсан зэвсэгт довтолгоог таслан зогсоох
- Цагдан сэргийлэх байгууллагын ажилтны амь биед шууд аюул учруулсан, түүнчлэн цагдан сэргийлэх байгууллагын хуяглан хамгаалалтад халдсан довтолгоог өөр аргаар таслан зогсоох боломжгүй бол
- Зэвсэг хэрэглэн эсэргүүцэж байгаа буюу онц аюултай гэмт хэрэг үйлдсэн, мөн урьдчилсан мөрдөн байцаалт, шүүх, хорих газраас оргосон /эмэгтэй болон насанд хүрээгүй хүнээс бусад/ гэмт хэрэгтнийг өөр арга хэрэгслээр барих боломжгүй бол

Зэвсэг хэрэглэх журмыг Нийгмийг аюулаас хамгаалах

¹² Мөн тэнд 121 дүгээр тал

яамны сайд, Улсын прокурорын зөвшөөрснөөр тодорхойлон батална гэжээ.

1990 оны 10 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан гарсан БНМАУ-ын “Цагдан сэргийлэх, Засан хүмүүжүүлэх, хөдөлмөрийн байгууллагын ажилтны үүргээ биелүүлэх баталгааны тухай хууль”-ийн 3 дугаар зүйлд: Цагдан сэргийлэх засан хүмүүжүүлэх, хөдөлмөрийн байгууллагын ажилтан гэмт хэргийг зогсоох, иргэдийн болон өөрийн амь нас эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалахын тулд бороохой, гав, хүлэг, усан хөөрөг, нулимс асгаруулагч зэрэг тусгай хэрэгсэл түүнчлэн зэвсэггүйгээр бие хамгаалах мэх хэрэглэх эрхтэй гэж заасан байна.¹³

Цагдан сэргийлэх засан хүмүүжүүлэх, хөдөлмөрийн байгууллагын ажилтан үүргээ гүйцэтгэхдээ хэрэглэх тусгай хэрэгслийн жагсаалт, зааврыг БНМАУ-ын Ерөнхий прокурорын зөвшөөрснөөр УЦСЕГ-ын дарга баталж мөрдүүлнэ. Мөн Цагдан сэргийлэх засан хүмүүжүүлэх, хөдөлмөрийн байгууллага тэдгээрийн ажилтнаас бусдад тусгай хэрэгсэл, мэхийг үндэслэлгүй буюу буруу хэрэглэсэн тухай гомдол мэдүүлгийг прокурор, цагдан сэргийлэх байгууллагад гаргана гэсэн нь цагдаагийн алба хаагчийн эдлэх эрхийг нь тодорхой зааж өгснөөс гадна үүрэг, хүлээх хариуцлагын арга хэмжээг тусгасан хууль дүрмийн заалт, хэм хэмжээнүүд байсан байна.

Дээрхи хууль тогтоомжуудад цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэж ирсэн талаар үечлэн тусгасан нь

¹³ Мөн тэнд 119 дүгээр тал



цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтын хөгжлийн баталгаа болж байна.

1992 онд Монгол Улсын Үндсэн хууль батлагдаж түүнд нийцүүлэн «Монгол улсын цагдаагийн байгууллагын тухай хууль» шинээр баталсан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болоод зогсохгүй эрх зүйн шинэчлэлтийн чухал алхам болсон.

Энэ хууль нь орчин үеийн цагдаагийн байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим, зорилго, зорилт, үндсэн үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн арга хэлбэрийг тодорхойлсон анхны төрөлжсөн хууль болсон бөгөөд цагдаагийн байгууллагын зэвсэг, тусгай хэрэгслийн талаар урьд өмнөх хууль тогтоомжуудад байгаагүй тусгай бүлэг, зүйлүүд тусгагдсан нь цагдаагийн байгууллага, алба хаагчаас зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх талаар шинэлэг эрх зүйн акт болж чадсан юм. Тухайлбал, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар бүлэгт цагдаагийн байгууллага, алба хаагчийн зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх, тусгай хэрэгслийн төрөл, хэрэглэх үндэслэл журмын талаар дараах байдлаар тусгайлан зохицуулсан байна. Үүнд:

➤ 39 дүгээр зүйл.

Ц а г д а а г и й н байгууллагын зэвсэг

- 40 дүгээр зүйл. Галт зэвсэг хэрэглэх
- 41 дүгээр зүйл. Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх
- 42 дугаар зүйл. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл
- 43 дугаар зүйл. Нэг бүрийн тусгай хэрэгсэл

- 44 дүгээр зүйл. Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл
- 45 дугаар зүйл. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг батлах
- 46 дугаар зүйл. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглох тохиолдлуудыг тус тус нарийвчлан тусгасан байна.

Мөн энэ хуулийн 45.1-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн “Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар”-ыг батална гэжээ.¹⁴

Энэхүү зааврын гол агуулга, үзэл баримтлал нь хуулинд заасан галт зэвсэг, тусгай хэрэгслийг алба хаагч нь хуулинд заасан үндэслэл журмын дагуу хэрхэн ямар арга аргачлал, хэм хэмжээг баримталж хэрэглэхийг нарийвчлан тусгаж өгсөн байдгаараа онцлог ач холбогдолтой юм.

Өөрөөр хэлбэл тухайн алба хаагчаас тусгай хэрэгслийг зөв хуулийн хүрээнд хэрэглэх, эрхээ хэтрүүлэхгүй байлгах зорилгоор албаны галт зэвсэг, тусгай хэрэгслийг хэрхэн яаж хэрэглэх аргачлал, юун дээр анхаарах ёстойг нь заавраар зохицуулж өгсөн байна.

Тус баталсан зааврыг цагдаагийн байгууллага нь албандаа тасралтгүй 16 жил мөрдлөг болгож ажилласан бөгөөд энэ нь нийгмийн тогтолцоо, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж зайлшгүй шинэчлэгдэх шаардлага

¹⁴ ЦЕГ-ын даргын 1994.03.31-ний өдрийн 75 дугаар тушаал

тулгарласан юм.

Энэхүү ажлын хүрээнд цагдаагийн албанд мөрдөгдөх журам /стандарт/-ыг боловсронгуй болгох зорилгоор тус зааврыг улмаар хүчингүй болгож, 2010 онд Цагдаагийн ерөнхий газрын дарга, Монгол Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан 173 тоот тушаал¹⁵-ыг баталж цагдаагийн байгууллага, алба хаагч нь албаны үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан байна.

Тус 173 тоот тушаалд албаны зэвсэг, тусгай хэрэгслийг төрөлжүүлэн ангилж дараах байдлаар тусгайлан код /заавар/ болгож зохицуулалт хийгдсэн байна. Үүнд:

- Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар /ЦБҮАЖ код- 233/
- Галт зэвсэг хэрэглэх заавар /ЦБҮАЖ код- 234/
- Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх заавар / ЦБҮАЖ код- 235/
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх заавар /ЦБҮАЖ код- 236/
- Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх заавар / ЦБҮАЖ код- 237/
- Зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх заавар / ЦБҮАЖ код- 238/
- Албаны нохой хэрэглэх заавар /ЦБҮАЖ код -239/

2013 онд Цагдаагийн байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулж Цагдаагийн албаны тухай¹⁶ хууль батлагдсан бөгөөд тус хуульд нийцүүлэн цагдаагийн байгууллага нь чиг

¹⁵ ЦЕГ-ын даргын 2010.04.02-ны өдөр 173 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

¹⁶ Цагдаагийн албаны тухай хууль 2013 оны 07-р сарын 05-нд батлагдсан 9 бүлэг, 42 зүйлтэй хууль юм. Энэ хууль 2014 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн.



үүргээ хэрэгжүүлэн ажилллаж байна.

Тус хуулинд галт зэвсэг, тусгай хэрэгслийн талаар дараах байдлаар зохицуулалт хийгдэж тусгагдсан байна. Тухайлбал, Цагдаагийн байгууллага, алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хуульд заасан үндэслэл журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэнэ¹⁷, Алба хаагч үүрэг гүйцэтгэх үедээ гав, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, холбооны хэрэгсэл, гар чийдэн, дүрс, дуу бичлэгийн хэрэгсэл зэрэг иж бүрдэл бүхий агсамжаар хангагдах бөгөөд хууль тогтоомжид заасны дагуу хэрэглэнэ¹⁸, Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэх алба хаагчид галт зэвсэг олгох, алба хаагч нь галт зэвсгийг биедээ авч явах эрхтэй¹⁹ гэж тус тус заажээ.

Цагдаагийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулж Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль²⁰ батлагдан гарсан юм. Тус хуулинд хууль сахиулагч албан үүргээ гүйцэтгэх үедээ биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх харилцааг зохицуулах холбогдох хууль

батлагдаж, хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд цагдаагийн байгууллага, алба хаагч Цагдаагийн албаны тухай хуулийн 33.6-д заасан биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхдээ энэ хуулийн 17-21 дүгээр зүйлд заасныг баримтална²¹ гэжээ.

Өөрөөр хэлбэл галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүчийг хэрэглэхдээ тус хуулийн 17-21 дүгээр зүйлд заасан үндэслэл журмыг алба хаагч баримтлан ажиллахыг зүйл заалт бүрээр нарийвчлан тодотгож оруулсан байна.

Цагдаагийн албаны тухай хуулийг цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагаандаа баримтлан ажилласантай холбогдуулан 2010 оны Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан “Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар нь хүчингүй болсон бөгөөд улмаар Хууль зүйн сайд, Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан 2014 оны А/126 тоот тушаал²²-ыг мөрдөн ажиллаж байна.

Тус тушаалын хавсралтаар батлагдсан зааварт цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах албаны галт зэвсэг, тусгай хэрэгслийн жагсаалт болон тэдгээрийг алба хаагч нь хэрхэн яаж ямар аргачлалаар хэрэглэхийг тусгайлан заасан ба цагдаагийн албаны тухай болон цагдаагийн албаны

тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн галт зэвсэг, тусгай хэрэгслийн заалтын үзэл баримтлалд нийцүүлсэн байна.

Дүгнэлт:

Түүхэн хөгжлийнхөө хугацаанд цагдаагийн байгууллага нь өөрийн үндсэн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжид заасан галт зэвсэг, тусгай хэрэгслийг хууль тогтоомжинд заасан үндэслэл журмын дагуу хэрэглэж ирсэн байх бөгөөд энэхүү үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалт нь тухайн цаг үеийн улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан өөрчлөгдөн шинэчлэгдэн сайжирч улам боловсронгуй болж ирсэн байна.

Мөн албаны зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх нь гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй шууд холбоотой арга хэмжээг өөр арга, хэрэгслээр зогсоох боломжгүй үед хийгддэг хүний эрх, эрх чөлөөг ихээр хөнддөг онцгой албадлагын арга хэмжээ юм.

Иймд цагдаагийн албан хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг гүйцэтгэхдээ албаны зэвсэглэмжид хүлээн авч бүртгэсэн галт зэвсэг, тусгай хэрэгслийг үндэслэл бүхий нөхцөл нэгэнт бий болсон тохиолдолд ашиглах ингэхдээ тохирсон хүчийг зөв сонгож хэрэглэх нь эрхээ хэтрүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлж байдгаараа чухал ач холбогдолтой.

¹⁷ Цагдаагийн албаны тухай хуулийн 33-р зүйлийн 33.6 дахь заалт

¹⁸ Цагдаагийн албаны тухай хуулийн 28-р зүйлийн 28.1 дэх заалт

¹⁹ Цагдаагийн албаны тухай хуулийн 28-р зүйлийн 28.3 дахь заалт

²⁰ Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь 2014 оны 01-р сарын 16-нд батлагдсан.

²¹ Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 16-р зүйл

²² ХЗС-ын 2014 оны 07-р сарын 10-ны өдөр баталсан “Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ОЛОН УЛСЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН БА
МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.Нармандах

*Үндэсний тагнуулын академийн Эрх зүйн
тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд хурандаа*

1. Оршил

Улс орныг улс төр, эдийн засгийн хөгжил дэвшлийг нь биш аюулгүй байдал, хүний хөгжил, хүний эрхийг хангаж хамгаалж байгаа байдлаар нь үнэлж дүгнэх болсон өнөө үед хүний аюулгүй байдлын тухай асуудал нь төр улсын төдийгүй олон улсын анхаарах татсан асуудал болж өргөжиж байна. Энэ нь 2000 онд НҮБ-ын гишүүн орнуудын төр, засгийн тэргүүнүүд чуулж, “Хөгжил”, “Аюулгүй байдал”, “Хүний эрх”-д суурилсан **“Их эрх чөлөө”-г** хүн төрөлхтөний 3 дахь мянганд баримтлах тунхаглал хэмээн санал нэгтгэж баталсантай холбоотой бөгөөд үүнийг хүн төрөлхтөн хамтын хүчээр хангахаар уриалсан нь төр улсуудын хөгжлийн тэргүүлэх чиглэл болсон байна.

Хүний аюулгүй байдлын асуудал нь анх аюулд өртсөн нэгнийг дэмжин туслах, тэдэнд зөвлөх хэн нэг хувь хүн, түүнийг дэмжигчдийн сайн дурын үйл

хэрэг мэт ойлгогдож ирсэн бол өнөөдөр уг нь улс гүрний аюулгүй байдлын нэг үндэс мөн бөгөөд 1990-ээд оноос эхлэн олон улсын түвшинд яригдаж ирсэн онол, практикийн хувьд шинэ тутам судлагдаж буй салбар гэж хэлж болохоор байна. Хүний аюулгүй байдал хэмээх нэр томъёог анх 1994 оны НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн тайланд¹ “Хүн дарангуйлал, хэлмэгдүүлэлт, өвчин эмгэг, өлсгөлөн зэрэг аюулаас хамгаалагдсан байх явдал мөн. Түүнчлэн орон гэр, ажлын байр, нийгэмд алинд ч байсан хүний өдөр тутмын амьдралын хэв маягт гэнэтийн болон ноцтой сүйрлээс хамгаалагдсан байхыг хэлнэ.” хэмээн заажээ. Оксфордын их сургуулийн эрдэмтэн Alan Collins-ийн тодорхойлсончлон “Төр төвтэй нийгэмд аюулгүй байдлын заналхийллийг гадаад орчноос үүдэлтэй цэрэг, дайны болон улс төрийн түрэмгийлэл хэмээн үздэг бол хүн төвт нийгэмд аюул заналхийлэл нь дотоод орчноос үүсэлтэй” гэж үздэг байна.²

Бид энэ удаад хүний аюулгүй байдал, цаашлаад үндэсний

аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох олон улсын шилжилт хөдөлгөөний асуудлыг хөндөн авч үзэж байна.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалаар тунхагласан хүний эрх, эрх эрх чөлөөний нэг нь хүний чөлөөтэй оршинын **13 дугаар зүйлд** “Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй.” гэж заасан байх бөгөөд тунхаглалын энэ заалтыг амьдрал болгодог үзэгдэл нь нэг улсаас нөгөө улс руу шилжин амьдрах хөдөлгөөн буюу цагаачлал билээ. Цагаачлалын үйл явц нь дэлхийн 2 дугаар дайнаас хойш цэцэглэсэн гэж хэлж болох юм. Өнгөрсөн зууны сүүлийн хагасаас өндөр хөгжил, амьдралын төвшнөөрөө илүүрхэж байгаа Баруун Европ болон хойд Америкийн хөгжилтэй орнуудыг чиглэсэн цагаачлалын урсгал тасралтгүй өргөжсөөр хагас зууныг өнгөрөөгөөд байна.

Шилжих хөдөлгөөн нь нийгмийн үйл явцтай харилцан шүтэлцээтэй үзэгдэл мөн бөгөөд өнөөдөр олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагын судалгаагаар дэлхий дээр 214 сая хүн төрөлх эх орноосоо ангид амьдарч байгааг харуулсан

¹ UNDP, Human development report, 1994

² Alan Collins, Contemporary security studies, 2010, pg 122-123, Oxford University Press.



бөгөөд энэ нь дэлхийн хүн амын 3,1 хувьтай тэнцэж байна.

Олон улсын шилжилт хөдөлгөөн нь:

- Ажиллах хүчний болон ажил эрхлэх зорилготой шилжих хөдөлгөөн
- Хөгжлөөс үүсэх шилжих хөдөлгөөн
- Улс төрийн шалтгаантай шилжих хөдөлгөөн /цагаачлах, дүрвэх, орогнох/
- Байгалийн аюул гамшгаас болж цагаачлах хөдөлгөөн
- Гэрлэлтээс үүсэх шилжих хөдөлгөөн
- Хөгжингүй газраас хөгжиж байгаа нутаг руу мэргэжилтэй боловсон хүчнүүдийн шилжих хөдөлгөөн гэсэн төрлүүдтэй байна.

Эдгээр шилжилт хөдөлгөөн нь дараах хүчин зүйлсийн нөлөөгөөр үүсч байгааг олон улсын шилжилт хөдөлгөөний тайланд³ дурджээ. Үүнд:

- Эдийн засгийн хүчин зүйлүүд: амьжиргааны ялгаа улс орнуудын эдийн засгийн өсөлт, ажил эрхлэх боломж г.м.
- Засаглал, олон нийтийн үйлчилгээ: Муу засаглал, авлига, чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ г.м.
- Хүн ам зүйн тэнцвэргүй байдал: Эдгээр нь янз бүрийн хэлбэртэй байж болно. Жишээ нь, төрөлтийн түвшиний бууралт, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, х ө д ө л м ө р и й н нийлүүлэлтийн тэнцэл

алдагдахаас сэргийлэх, хувь нэмэр оруулах замаар хөдөлмөр эрхлэх гадаад ажилчдыг шилжүүлэн авах г.м.

- Зөрчил: Угсаатны болон байгаль шашны үзлийн зөрчилдөөн, эдийн засгийн тэгш бус байдал, байгалийн нөөцийн төлөөх өрсөлдөөн, арьсны өнгө дээр суурилсан ялгаварлан гадуурхалт г.м
- Байгаль орчны хүчин зүйлс нь: газар хөдлөлт, үйлдвэрлэлийн осол, үер зэрэг байгаль орчны хүчин зүйл, уур амьсгалтай холбоотой байж болох хөрс/эргийн элэгдэл, ган гачиг зэрэг хүчин зүйлсийн улмаас үүсэх шилжилт хөдөлгөөн. Гэхдээ энэ нь ихэнхдээ дотоод байх хандлагатай байдаг.

- Үндэстэн дамнасан сүлжээ: Аж үйлдвэржсэн орнууд улс орон, нийгэм, соёлын “татах хүчин зүйл” болж, цагаач иргэдийн сүлжээг бий болгож байгаа зэргийг дурджээ.

Шилжих хөдөлгөөний үр нөлөөг эдийн засгийн хөгжил талаас нь харж миграцийн нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүдийг тайлбарладаг Зипфийн буцах зайн хууль, Стуфферийн халдах боломжийн онол, Лигийн татах түлхэх онол⁴, Бодерийн хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтын онол зэргээр тайлбарлаж ирсэн бол өнөөдөр харин эсрэгээрээ, шилжих хөдөлгөөн нь хүний хөгжилд хэрхэн нөлөөлж буйд анхаарал хандуулж, энэ үзүүлэлтээр

тайлан мэдээг гаргахыг илүүтэйгээр зорих болжээ.

1986 оны хөгжлийн эрхийн тухай тунхаглалд “Хүн төлөлхтөний сайн сайхан амьдралын үндэс нь хувь хүний хөгжил мөн” гэж заасанчлан шилжилт хөдөлгөөн ч мөн адил хувь хүний сайн сайхны төлөө байх нь зүйн хэрэг.

Шилжин суурьших нь хувь хүний сайн сайхан байдалд эерэг болон сөрөг нөлөөллийг үзүүлдэг талаар олон улсын шилжилт хөдөлгөөний тайлангуудад тусгаад шилжин суурьшигчдын эрх зүйн байдлыг судлах, шилжилт хөдөлгөөний хөтөлбөрийг боловсруулах, шилжин суурьшиж байгаа хүмүүсийн эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор хамтран ажиллаж, санал солилцоход дэлхийн улсууд ихээхэн анхаарах болжээ.

2. Гадаад шилжих хөдөлгөөн буюу цагаачлалтай холбоотой олон улсын хандлага

Дэлхийн шилжилт хөдөлгөөний тайланд олон улсын шилжилт хөдөлгөөний замыг

- Өмнөдөөс Умард 45%
- Өмнөдөөс Өмнөд (35%),
- Умардаас Умард (17%)
- Харин Умардаас Өмнөдөд (3%) шилжилт хөдөлгөөн хийгдэж байгаа талаар тусгажээ.

Энэ нь гадаад шилжилт хөдөлгөөн буюу цагаачлалын асуудалд дэлхийн улс орнууд харилцан адилгүй байр суурь баримталдагтай холбоотой байна. Энэ талаар дэлхий нийтийн анхаарал татдаг зарим орны цагаачлал, шилжилт хөдөлгөөний нөхцөл байдлын талаар товчхон авч үзвэл:

³ IOM World Migration Report 2013: Migrant Well-being and Development. <http://www.unric.org/en/latest-un-buzz/28685-iom-world-migration-report-2013-migrant-well-being-and-development>

⁴ Б.Нандинцэцэг. Ажиллах хүч ба шилжих хөдөлгөөн, УБ., 2012



Япон улсын тухайд цагаачлалын асуудалд нэлээд хатуу бодлогыг баримталдаг бөгөөд 127 сая хүн амтай тус улсад сүүлийн жилүүдэд төрөлт 1/3 хувиар буурч, хүн амын өсөлт удааширч, хүн амын ¼ хувийг 65-аас дээш настай хүмүүс эзлэх болсоноор хөгшин улсын тоонд орох болсон. Ингэснээр энэ бүхнийг дагаад ажиллах хүчний хомсдолд орж, эдийн засгийн үсрэнгүй өсөлт нь ч буурч жилд дөнгөж 2%-иар тооцогддог болсон байна.

Дэлхийн эдийн засагч, CNN-ийн сэтгүүлч Robert Guest “Хил хязгааргүй эдийн засаг”⁵ номондоо Япон улс энэ бүх бэрхшээлийг цагаачлалаар нөхөх боломж байгаа ч цагаачлалын хатуу бодлого нь ихээхэн саад болж байгаа талаар тэмдэглэжээ. Япон улсад хүн амын дөнгөж 2%-ийг л гадаадын иргэд эзэлж байгаа бөгөөд энэ нь АНУ-тай харьцуулахад 6 дахин бага байгаа ажээ. Мөн дэлхийн хэмжээний цагаачлалын тоо баримтаас харахад гадаад улсын иргэншил олж авсан байдлыг харьцуулан үзвэл 10 000 хүн тутамд Япон улсын иргэншлийг 1 хүн, Герман улсын иргэншлийг 12 хүн, АНУ-ын иргэншлийг 20 хүн олж авдаг статистик байна.

Европт эсрэгээрээ цагаачлалын буюу гадаад шилжилт хөдөлгөөний асуудалд харьцангуй нээлттэй бодлого баримталдаг байна. Тиймээс ч зарим судлаачид Европын холбоо бол цагаачлалын туршилтын талбар мөн гэж үздэг байна. Европын холбооны нутаг дэвгэр дээр 0,5 тэр бум хүн ам чөлөөтэй зорчих болсон нь ажиллах хүчний хомсдол, эдийн засгийн уналт, хүн амын

тэнцвэртэй бус байдал зэрэг сөрөг байдлыг үүсгээгүй сайн талтай гэж үзэж болохоор байна.

Гэхдээ Европын холбооны зарим улсуудад тухайлбал, Грек, Недерланд, Франц зэрэг улсуудад цагаачлалын энэ нээлттэй бодлогыг эсэргүүцэх явдал цөөнгүй гарч цагаачлагчдын аюулгүй байдалд заналхийлэл учруулах явдал цөөнгүй гарах болсон нь улс төрчдийг ч энэ нээлттэй бодлогыг хязгаарлах бодлого баримтлахад хүргэх болсон байна.

Канад улсын тухайд амьдралын түвшин, аюулгүй байдал, хууль эрх зүйн орчин сайтай бөгөөд цагаачлалын асуудлаар нэн таатай бодлого хэрэгжүүлдэг нь хүн ам цөөн, төрөлт бага тус улсын тухайд хүн ам, эдийн засгаа дэмжих үндэс болдог байна. Канад улс сүүлийн 3 жилд байнга оршин суух зөвшөөрлийн 1/3 хувийг нь эдийн засгийн зорилгоор, 22%-д нь гэр бүлийн зорилгоор олгосон байдаг байна.

АНУ-ын тухайд эсрэгээрээ 2/3 хувийг нь гэр бүлийн зорилгоор, 13%-д нь эдийн засгийн зорилгоор цагаачлалын зөвшөөрөл олгосон байдаг байна. АНУ цагаачлалын буюу гадаад шилжилт хөдөлгөөний асуудалд харьцангуй нээлттэй бодлого баримталдаг ч 11,5 сая хууль бус цагаач байгаа бөгөөд үүний 86% нь 7-оос дээш жил оршин суусан байдаг байна. Энэ бүх хууль бус цагаачдын асуудал АНУ төдийгүй тэдгээрийг харьяалагч улсуудын анхаарал татсан асуудал мөн ажээ.⁶

Эндээс олон улсад цагаачлалыг үр ашигтай гэж үздэг дараах үндэслэлүүд

байна. Тухайлбал 2030 он гэхэд ХБНГУ-ын ахмад настны тоо залуу иргэдийн тооноос хоёр дахин их болох статистикийг шинжээчид гаргажээ. Тэгвэл тус улсын хөрш Францад мөн энэ хугацаанд хүн амын тэн хагас нь тэтгэврийнхэн болж өтлөх юм байна. Японы хувьд байдал бүр ч хэцүү. Одоогоос 20 жилийн дараа гэхэд л Японы хүн амын дийлэнх хэсэг нь 60-аас дээш настнууд болох нь тодорхой байгаа юм.

Энэ бүхнийг тооцож үзэхэд 20-30 жилийн дараа дээрхи хөгжилттэй орнуудын ажиллах хүчний нөөц эрс багасч хөдөлмөрийн фронт гээд байх зүйл бараг үгүй болох юм. Чухам энэ хомсдлыг л давахад нөгөө цагаачдын урсгал ёстой л амь тариа болж өгөх учиртай гэнэ. Өнөөдөр баруун руу голцуу цагаачилж байгаа харийн иргэдийн дундаж нас 26-30 байгаа нь тухайн орнуудын аж үйлдвэрийн болон үйлчилгээний салбарын ажиллагсдын дутагдлыг нөхөх гол нөөц болох боломж байна.

Нөгөө талаар энэхүү цагаачлал буюу олон улсын шилжилт хөдөлгөөнийг дагаад шударга хөдөлмөрөө ахиухан үнэлүүлэх зорилготой цагаачдын дунд өөр зорилго бодолтой хүмүүс халхлагдан гарч, орох нь элбэгшиж харьд очсон цагаачдын дунд гэмт хэрэг гарах тоо хэмжээ улам бүр нэмэгдэх болсныг Их наймд багтдаг хөгжилтэй орнууд бүгд тэмдэглэх болжээ.⁷ Мөн буурай орны иргэдийн цагаачлах хүсэл тэмүүллийг ашиглан хүний наймаа хийх гэмт хэргийн хүрээ ч улам өргөжих болж байна. Хар тамхины наймаа,

⁵ Robert Guest “Borderless Economic” NY, 2013

⁶ Eagle TV/CNN, Дэлхийн сургамжууд, цуврал нэвтрүүлэг. Цагаачдад зориулсан GPS газрын зураг.

⁷ <http://edition.cnn.com/2013/11/06/us/immigration-statistics-fast-facts/>



бэлгийн замбараагүй амьдрал, хүчирхийлэл гэх мэт нийгмийн сүүдрийг улам томсгоход цагаач нар чамгүй хувь нэмэр оруулсаар байгаа нь аль аль талдаа ашиггүй зүйл болж байгаа юм. Цагаачдын нэрээр хүүхэд охидыг хил давуулан наймаалах, хүнийг эд эрхтний наймааны олз болгон худалдах гээд олон асуудал Өрнөдийн хууль сахиулагч нарт дарамт болсоор удаж байна.

Цагаачлалыг даган экспортлогдож байгаа бас нэгэн сөрөг зүйл нь шашин хоорондын болон үндэстэн хоорондын сөргөлдөөн юм. Бас нэг сөрөг тал нь цагаачдын урсгалыг дагаж тухайн оронд ажилгүйдэл өсөж боловсролын төвшин буурах үзэгдэл байнга ажиглагдаж байна. Мөн эрлийзүүд болон тэдний хоёрдахь үеийн эзлэх хувь нэмэгдэх тусам он удаан жил тогтворжиж байгалийн шалгарлыг давж ирсэн үндэстэн угсаатнуудын генийн тогтцыг сулуруулан эвдэх аюулын тухай ч яригдах болжээ.

3. Монгол Улс дахь гадаад шилжилт хөдөлгөөн

Дэлхий нийтийг хамарсан дээрх гадаад шилжих хөдөлгөөн нь манай улсыг ч мөн алгассангүй. 1990-ээд оноос хойш Монгол улсын иргэд ардчилсан Үндсэн хуулиар олгогдсон “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх” эрхийнхээ дагуу гадаадын олон улс оронд сурч, хөдөлмөрлөж, амьдарч эхэлснээс хойш Монгол улсын улс төр-эдийн засаг, боловсрол, нийгмийн сэтгэл зүй, оюуны сэтгэлгээнд маш их өөрчлөлтүүдийг оруулж байна.

Германы нэрт гүн ухаантан Иммануил Кант /1724-1804/ “Мөнх энх тайван” гэдэг зохиолдоо хүний эрхийг нийтээр хүндэтгэх нь олон улсын дэг журмын үндэс болох ёстой гэдэг үзэл баримтлал дэвшүүлж, түүнийгээ олон талаар нотолж байжээ. Дотооддоо хууль дүрэм сахидаггүй Засгийн газар, гадаад бодлогодоо шижээргүй араншинтай байдаг гэдэг үндэслэлийг Кант гаргаж гадаад, дотоод бодлогын хууль зүй, сэтгэл санааны холбоог нотолж байжээ. Үүнээс үндэслэн олон улсын харилцаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахих журмыг нэвтрүүлэхийн чухлыг зааж нотолсон нь энэ харилцааг ардчилах чигт өнөөгийн гарч байгаа хандлагыг холч мэргэнээр төсөөлж байсны илэрхийлэл ажээ.

Энэ талаар гавъяат хуульч, доктор, профессор Б.Чимид өөрийн бүтээлдээ “Хүний эрхийг хангах, хамгаалах нь засаг төрийн зөвхөн халамж анхаарлын буюу сайн санааны үйлс төдий биш юм. Харин дотоод, гадаад хоёр үндсэн шалтгаанаар ард түмнийхээ өмнө Үндсэн хуулийн ёсоор хүлээсэн зайлшгүй үүрэг мөн. Ямар шалтгаан байна бэ? Гэвэл өөрсдөө өөрсдийн тусын тулд байгуулж эцэг эх нь болсон ард түмнийхээ эрх, эрх чөлөөг хамгаалах, сайн сайхныг хангах нь засаг төрийн эрхэм зорилго мөн. Энэ бол дотоод гол шалтгаан. Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүний хувьд хүний эрхийн олон улсын гэрээг шударгаар сахин биелүүлэх үүргийг дэлхийн улсуудын өмнө хүлээсэн байдаг. Энэ бол гадаад гол шалтгаан.” хэмээн

тэмдэглэжээ.⁸

Монгол Улс Үндсэн хуулийнхаа 19 дүгээр зүйлд «Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна» хэмээн заасан байна. Мөн Монгол улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд “Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлнэ” хэмээн заасан нь хүний эрх, эрх чөлөөний асуудал зөвхөн Монгол улсын төрийн дотоод бодлого төдийгүй олон улсын эрх зүйтэй нягт холбоотой гадаад үүргийн нэг болохыг илтгэн харуулж байна.

Тиймээс ч Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд⁹ “Гаднын дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээ авна.”, Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэддээ эх орондоо эргэн ирж ажиллаж, амьдрах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ. Гадаадад төрж тухайн улсын иргэний харьяалалтай болсон иргэд, тэдний үр хүүхдэд Монгол Улсад зорчих, оршин суух, суралцах, ажиллаж амьдрах,

⁸ Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 148 дахь тал

⁹ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай. УИХ-ын тогтоол, 2010 оны 07 сарын 15 өдөр. Төрийн ордон, УБ, Дугаар 48, www.legalinfo.mn/law/details/6163



даатгалд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Хоёрдмол харьяалал үүсч, төрөөс иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах баталгаа алдагдахаас сэргийлнэ. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшинг хадгалж, бүртгэл, мэдээллийн тогтолцоо, эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.” гэж заахын зэрэгцээ Монгол улсын хүний эрхийн үндэсний хөтөлбөрт¹⁰ “Гадаадад зорчин оршин сууж, сурч, ажиллаж байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх бодлого боловсруулж, энэ талаар Монгол Улсаас гадаад орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын үүрэг хариуцлагыг өндөржүүлнэ. Хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гадаадын иргэдийн эрх, ашиг сонирхлыг харилцан хүндэтгэж хамгаалах талаар Монгол Улсаас бусад улстай байгуулсан эрх зүйн туслалцааны болон консулын зэрэг гэрээнүүдийг хуулийн дагуу хянан шинэчилж, түүний биелэлтэд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлнэ. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн эрхийг хамгаалах журмыг боловсронгуй болгоно.” хэмээн тодорхойлж Монгол улсын Их хурлаас гадаадын зарим улс орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх 2 талт гэрээг байгуулахын зэрэгцээ Засгийн газраас зарим журмыг батлан хэрэгжүүлж

байна.

Монгол улсын иргэд гадаадад явах, тэнд оршин суухаар цагаачлахад тухайн иргэнийг хүлээн авах улсын дотоодын хуулиар тогтоосон журмаас өөр Монголын төр, засгийн зүгээс учруулах ямар нэг хязгаарлалт байдаггүй. Гагцхүү очих орны хууль тогтоомжоор урьдчилан зөвшөөрөл авах, амьдрах баталгаатай холбоотой болзол шаардах тохиолдол зарим орны хувьд нилээд хатуу, заримынх нь хувьд бага зэрэг хязгаарлалт байдаг бөгөөд тэр нь тухайн орны дотоодын асуудал учраас монголын иргэн уг журмыг хүссэнээр зөрчиж болдоггүй байна.

Монгол улсад зорчих, оршин суух, цагаачлах гадаадын иргэдийн тоо жил тутам өсөн нэмэгдэж,¹¹ тэдний эрх зүйн байдлыг тогтоосон хууль тогтоомжийг төдийгүй гадаадын иргэнтэй холбогдох асуудлыг хариуцсан байгууллагын тогтолцоог бүрдүүлэх, байр суурийг нь бэхжүүлэх, эрх зүйн байдлыг нь тогтоох, тодорхой болгох асуудлыг төрийн бодлогын хэмжээнд авч үзэж ирснээр өнөөдрийг хүржээ. Гэвч энэ асуудал өнөөдөр Монгол улсад хангалттай түвшинд хийгэж чадахгүй байгаагаас олон улсын шилжилт хөдөлгөөн нь улс орны болон шилжин суурьшиж байгаа хүмүүсийн хувьд дараах сөрөг үр дагаврыг үүсгэж байгаа нь практикаас илэрхий байна. Тухайлбал:

- Мэргэжлийн болон оюуны өндөр чадавхийн урсгал гадагш чиглэж, улмаар

нийгэмд өндөр чадвар бүхий мэргэжилтнүүдийн хомсдолыг бий болгоход хүрч байна.

- Нийгэм, эдийн засаг, хөдөлмөрийн тогтолцоо, эрх зүй, хэл, ёс заншил, сэтгэл зүйн огт өөр нөхцөлд ажиллаж буй монгол иргэдэд орчиндоо дасан зохицох, хөгжих, өөрийн эрх ашиг, эрүүл мэндээ хамгаалах талын мэдээлэл дутагдалтай байдаг¹²-аас эрсдэлд өртөх магадлал их байдаг.
- Гадаад дахь ажиллах хүчиний тухайд хөдөлмөрийн хөлсөө авч чадахгүй байх, үйлдвэрийн осолд орох, гэмтэх бэртэх, эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдах зэргээр эрх нь зөрчигдөх тохиолдол цөөнгүй гардаг
- Гадаадын иргэнтэй гэрлэсэн эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөх
- Цагаачлагчид нийгэм сэтгэл зүйн хувьд хямрах
- Цаашлаад улсын аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдалд хор хохирол учруулах зэрэг сөрөг үр дагаварууд авч ирж болно.

Тиймээс төр, засгийн зүгээс цагаачлал буюу гадаад шилжилт хөдөлгөөний талаар хэрэгжүүлж буй олон талт арга хэмжээний үр нөлөөг нэмэгдүүлэх үндэс нь гадаад шилжилт хөдөлгөөний

¹⁰ Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай.УИХ-ын тогтоол, 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдөр,Төрийн ордон, УБ, дугаар 41, <http://www.legalinfo.mn/law/details/6265>

¹¹ Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газраас 2010 оны 06 дугаар сард хийсэн мэдэгдэлдээ тус улсад 29150 гадаадын иргэн амьдарч байгаа бөгөөд эдгээрийн 16675 БНХАУ-ын, 871 ОХУ-ын, 36 БНСУ-ын, бусад улсын 28 иргэн байгааг дурьджээ.

¹² Судалгаанд оролцсон нийт хүмүүсийн 88.3 хувьд нь харилцааны бэрхшээл, 71.3 хувьд нь мэдээллийн дутмаг байдал, 75.1 хувьд нь цалингаа авах хүртлээ санхүүгийн хүндрэлтэй тулгардаг бол 64.6 хувь нь сэтгэл санааны багагүй дарамтанд орж, 50.9 хувьд нь хоол унд тохирохгүй, цаг агаарт нь дасахгүй байх, 34.2 хувьд нь орон байрны асуудал тулгарсан байна.



талаарх бодитой судалгаа хийх хэрэгцээг бий болгож байна. Тухайлбал,

1. Шилжин суурьшигч гадаадын иргэний мэдээлэл, түүнд тавих хяналтыг тодорхой төвшинд хэрэгжүүлэг боловч, шилжин суурьшигч монгол иргэдийн талаарх нэгдсэн бүртгэл мэдээлэл хангалтгүй байгаа нь хүний аюулгүй байдлын асуудалд төр, засгийн зүгээс анхаарал хандуулахгүй байна гэж үзэх үндэслэл болоод байна. Учир нь цагаачлалын бүртгэл нэг дор төвлөрдөггүйгээс, дипломат төлөөлөгчийн газар болон зонсулын газруудын энэ талаарх тайлан мэдээ улсын хэмжээнд нэгтгэгддэггүйгээс хэдэн хувь нь түр хугацаагаар шилжин суурьшиж байгаа хэдэн

хувь нь цагаачилж байгааг нарийн тодорхойлох боломжийг хязгаарладаг байна.

2. Манай улсын гадаад шилжилт хөдөлгөөн олон улсын шилжилт хөдөлгөөний аль замаар, ямар үндэслэл, зорилгоор хийгдэж байгаа болон энэ нь хүн амын насжилт, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл төлөвлөлт, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр зэргийг тооцоолсны үндсэн дээр хийгдэж байгаа эсэхийг судалж үзсэний үндсэн дээр шилжилт хөдөлгөөний нэгдсэн хөтөлбөр боловсруулж, түүний хүрээнд зохион байгуулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл гадаад шилжилт хөдөлгөөн нь хувь хүний сайн сайхан амьдрах, материаллаг болон оюуны хэрэгцээнд

үндэслэхийн зэрэгцээ улс орны нийгэм, эдийн засгийн болон бусад нөхцөл, аюулгүй байдал, төрийн гадаад болон дотоод бодлогын хэрэгжилтэд үндэслэсэн байх нь зайлшгүйг төр засгийн зүгээс анхаарах цаг болжээ.

3. Нөгөө талаас Монгол улсад гадаад улс орнуудаас шилжин суурьшигчдын шилжин суурьших болсон үндэслэл, аль улсаас хэдэн хувийг эзэлж байгаад үнэлгээ хийж, хууль ёсны болон хууль бус цагаачдын дүн мэдээг нэгтгэн авч үзэж, энэ нь улсын аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд хүрсэн эсэхийг үнэлж, энэ талаар нийтэд мэдээлж байх нь зүйн хэрэг гэж үзэж байна.



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН
ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ТРУДОВАЯ ЗАНЯТОСТЬ ОСУЖДЕННЫХ В
ПРОЦЕССЕ ДЕТЕРМИНАЦИИ ПЕНИТЕНЦИАРНОЙ
ПРЕСТУПНОСТИ

*доцент кафедры управления и организации
деятельности УИС Академии ФСИИ России кандидат
юридических Минкова Елена Анатольевна наук*



Аннотация: в статье исследуется проблема влияния трудовой занятости осужденных на процесс детерминации пенитенциарной преступности. Автор приходит к выводу, что реализация социальных целей труда осужденных в комплексе с мероприятиями по организации социальной адаптации будет способствовать снижению уровня рецидивной преступности.

Ключевые слова: трудовая занятость, детерминация преступности, уровень рецидивной преступности.

Исследуя проблему детерминации пенитенциарной преступности, нельзя не отметить, что криминогенная ситуация в современной России сформировалась под воздействием целой совокупности факторов,

прежде всего социально-экономического характера, среди которых ведущую роль играют сохраняющиеся последствия масштабного кризиса, который поразил экономику и социальную сферу не только нашей страны, но и мира в целом. Это инфляция, снижение уровня жизни основной массы граждан, резкая поляризация и дифференциация по уровню доходов, нарастание официальной и скрытой безработицы, алкоголизация, наркотизация и маргинализация общества, а также иные процессы, которые порождают, «подпитывают» и обуславливают преступность в России. Совершенно прав, на наш взгляд, И.И. Карпец, указывающий: «Пора понять, что за экономические просчеты и политически неверные решения общество расплачивается, в числе прочего, и такой высокой ценой, как преступность»¹.

Все указанные негативные процессы, безусловно, зеркально отражаются и на деятельности исправительных учреждений, поскольку «общество создает тюрьму по своему образу и

подобию»². Жизнь в местах лишения свободы неотделима от жизни общества, поэтому современная пенитенциарная система в целом, а также правовое и социальное положение осужденных «являются, в конечном счете, отражением несправедливости и антигуманности того общества, в котором мы живем»³.

Чем выше уровень насилия в стране, чем больше жестокости присутствует в конфликтах между отдельными людьми и социальными группами, тем выше и опаснее этот уровень в исправительных учреждениях⁴. Феномен пенитенциарной системы нельзя определить точнее, чем это сделал в своем бессмертном произведении великий классик русской литературы Ф.М. Достоевский, отметивший, что «об уровне цивилизации народа можно судить, когда открываешь ворота его тюрьмы»⁵.

² Митфорд Дж. Тюремный бизнес / Пер. с англ. Ю.А. Неподаева; Под общ. ред. И.Б. Михайловской. М., 1978. С. 345.

³ Там же.

⁴ См.: Верещагин В.А. Прогнозирование и профилактика противоправного поведения осужденных в местах лишения свободы: Автореф. дис. ... д-ра юрид. наук. М., 1997. С. 24.

⁵ Достоевский Ф.М. Записки из Мертвого дома. М., 1983. С. 132.

¹ Карпец И.И. Дело, которому мы служим. М., 1989. С. 243.



Зависимость жизни осужденных в пенитенциарных учреждениях от социально-экономического состояния общества очевидна, что, по нашему мнению, нет необходимости специально комментировать. Кризисное состояние российской экономики с несовершенной системой рыночных отношений закономерно повлекло за собой снижение экономического потенциала мест лишения свободы, спад промышленного производства, резкое уменьшение средств на содержание осужденных, их коммунально-бытовое, медицинское обеспечение, что, без сомнения, отрицательно отразилось в целом на состоянии криминогенной обстановки в исправительных учреждениях.

Осужденные, несмотря на изоляцию, живут и действуют в рамках той же системы общественных отношений, испытывают на себе влияние тех же кризисных и конфликтных ситуаций, которые возникают в экономических отношениях, социальной сфере, политике, то есть во всем том, что составляет суть противоречивого развития современного общества.

Нет нужды рассуждать о том, что отрицательные экономические тенденции, существующие в настоящее время в исправительных учреждениях Федеральной службы исполнения наказаний, оказывают самое непосредственное влияние на весь процесс исполнения наказаний, в целом отрицательно отражаются на состоянии оперативной обстановки в исправительных учреждениях,

дестабилизируя ее.

Как известно, действие экономических факторов носит опосредованный характер, то есть они не детерминируют непосредственно преступные проявления. Однако, как показало проведенное нами исследование, одним из важнейших социально-экономических факторов, существенно влияющих на состояние оперативной обстановки в исправительных учреждениях, является спад промышленного производства и сокращение трудовой занятости осужденных, поскольку, как справедливо отметил Н.П. Барабанов, «чем больше осужденных не занято трудом, тем криминогеннее их среда»⁶.

Следует отметить, что эта проблема начала усугубляться еще в 90-х годах прошлого столетия, когда экономическое состояние исправительных учреждений стало приобретать кризисный характер, а огромная масса осужденных оказалась не обеспеченной трудом. Переход к рыночным отношениям, сопровождаемый разрывом хозяйственных связей в сочетании с технической отсталостью материальной базы и нестабильностью финансовой системы, поставил промышленность уголовно-исполнительной системы в крайне неблагоприятные условия, не позволяющие обеспечивать эффективную трудовую занятость всех осужденных в местах лишения свободы⁷.

⁶ См.: Барабанов Н.П. Криминогенные факторы, обуславливающие осложнение оперативной обстановки в ИУ, и организация ее оценки: Монография. Рязань, 2011. С. 28.

⁷ См.: Емельянова Е.В. Организационные формы привлечения осужденных к труду как элемент усилительного свойства в системе управления исполнения наказания // Вестник

В настоящее время согласно данным официальной статистики для обеспечения трудовой занятости осужденных организован производственный комплекс, в который входят 53 государственных унитарных предприятия, 587 центров трудовой адаптации осужденных, 52 лечебно-производственных и 41 учебно-производственная трудовая мастерская⁸.

По словам начальника Управления трудовой адаптации осужденных ФСИН России А.П. Сорокина, «... к настоящему моменту нам удалось выйти на докризисный уровень как по объемам производства, так и по количеству привлеченных к труду осужденных»⁹. Ежегодно исправительными учреждениями производится продукции, выполняется работ и оказывается услуг в объеме более 30 млрд. рублей. Значительная часть (почти 50%) выпускаемой продукции поставляется исправительными учреждениями для собственных нужд, а также по заказам силовых министерств и ведомств¹⁰.

Однако перспектив кардинального решения проблемы трудовой занятости осужденных в ближайшее время не предвидится. Так, по данным официальной статистики, на производственных объектах подразделений уголовно-исполнительной системы и

Владимирского юридического института ФСИН России. 2012. № 2. С. 19; Задача – обеспечить работой максимальное количество осужденных // Преступление и наказание. 2011. № 8. С. 11.

⁸ См.: Официальный сайт ФСИН России // <http://фсин.рф/statistics>.

⁹ Задача – обеспечить работой максимальное количество осужденных // Преступление и наказание. 2011. № 8. С. 11.

¹⁰ См.: Официальный сайт ФСИН России // <http://фсин.рф/statistics>.



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

их партнеров ежемесячно трудится более 140 тысяч осужденных. Если учесть, что по состоянию на 1 января 2014 г. в учреждениях УИС содержалось 677,2 тыс. человек, получается, что практически 80 процентов осужденных не занято трудовой деятельностью¹¹.

Нельзя также обойти стороной тот факт, что значительная часть работающих осужденных особой активности и усердия в труде не проявляет, что объясняется, по-видимому, невозможностью их трудоустройства согласно профессии, полученной до осуждения, и привлечением их, как правило, к занятиям не к в а л и ф и ц и р о в а н н ы м ручным трудом, а также их нежеланием трудиться вообще и склонностью к паразитическому образу жизни.

На сегодняшний день средний показатель выработки осужденными своей месячной нормы составляет около 55 %, а в отдельных исправительных учреждениях – 11-23%¹². Кроме того, согласно исследованиям, проведенным К. Бегищевой и О. Патласовым, 54,8 % опрошенных осужденных работают только для того, чтобы приблизить момент освобождения и лишь 16,2 % – потому что выполняемая работа представляет для них интерес¹³.

¹¹ См.: Официальный сайт ФСИН России // <http://фсин.рф/statistics>.

¹² Задача – обеспечить работой максимальное количество осужденных // Преступление и наказание. 2011. № 8. С. 11.

¹³ См.: Бегищева К., Патласов О. Проблемы труда осужденных. Создание системы «социальных лифтов» // Человек и труд. 2012. № 3. С. 42.

Не вызывает сомнений, что данное обстоятельство не может не оказывать негативного воздействия на состояние криминогенной обстановки в исправительном учреждении, поскольку такая низкая трудовая занятость и трудовая активность осужденных приводят к тому, что большинство из них имеют массу свободного времени, избыток которого они, как правило, заполняют азартными играми, употреблением спиртных напитков, что нередко приводит к конфликтным ситуациям, заканчивающимся в ряде случаев совершением преступлений.

Совершенно справедливо в этой связи высказывание И.И. Карпеца о том, что «безделье здоровых, да еще запущенных социально людей – это страшная вещь»¹⁴. Прав также В.И. Игнатенко, отмечающий, что в условиях изоляции большое количество свободного времени у осужденных при неумелом использовании его сотрудниками исправительных учреждений в воспитательных целях является достаточно сильным криминогенным фактором, приводящим к преступлению¹⁵.

Таким образом, можно констатировать, что в современных условиях функционирования уголовно-исполнительной системы

¹⁴ Карпец И.И. Преступность: иллюзии и реальность. С. 284.

¹⁵ См.: Игнатенко В.И. Основы предупреждения антиобщественного образа жизни и рецидива преступлений несовершеннолетних (криминологические и пенитенциарные проблемы): Автореф. дис. ... д-ра юрид. наук. М., 1993. С. 26.

возможности использования в исправительных колониях такого действенного средства предупреждения рецидивных преступлений, как трудовая занятость осужденных, значительно сокращаются. В свою очередь, кардинальное решение проблемы обеспечения осужденных трудом можно рассматривать в качестве мощного антикриминогенного фактора, поскольку труд осужденных к лишению свободы не только преследует воспитательные, экономические, социальные и оздоровительные цели, но и должен способствовать исправлению осужденных, предупреждению совершения ими новых преступлений.

Иначе говоря, реализация социальных целей труда осужденных в комплексе с мероприятиями по организации социальной адаптации будет способствовать закреплению результатов исправления, что, в свою очередь, является одним из условий снижения рецидивной преступности. Совершенно прав С.Х. Шамсунов, утверждающий, что от того, как будет налажен процесс привлечения осужденных к труду, решена проблема трудовой занятости и организовано трудовое воспитание, зависят не только экономические и хозяйственные результаты их трудового использования, но и уровень преступности в целом¹⁶.

¹⁶ См.: Шамсунов С.Х. Комплексный подход в работе с кадрами – необходимое условие эффективности деятельности // Ведомости уголовно-исполнительной системы. 2004. № 3. С. 6.

